



УДИРДЛАГЫН
АКАДЕМИ

ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ: ИРГЭДИЙН ДУУ ХООЛОЙ БА ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ ХЭМЖИХ НЬ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

048

Улаанбаатар хот

2024 он

ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ: ИРГЭДИЙН ДУУ ХООЛОЙ БА ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ ХЭМЖИХ НЬ

Энэхүү бүтээлийг зохиогчийн эрхийг хуулийн дагуу хамгаалсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.

Удирдагч:

О.Цэрэнчимэд	Удирдлагын академийн Докторантур, магистрантурын албаны дарга, доктор, дэд профессор
--------------	--

Зөвлөх:

Я.Бямбасүрэн	Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор, профессор
--------------	---

Судлаачид:

Ж.Жаргал	Удирдлагын академийн Судалгаа, эрдэм шинжилгээний албаны дарга, доктор, дэд профессор
В.Данаасүрэн	Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн багш, доктор, дэд профессор
Ж.Энхжаргал	Удирдлагын академийн докторант
М.Элбэгсайхан	Удирдлагын академийн Чанарын баталгаажуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээний албаны мэргэжилтэн
Р.Ганцэцэг	Удирдлагын академийн Докторантур, магистрантурын албаны сургалтын ажилтан

“Адмон принт” ХХК-д хэвлэв.

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	V
--------------------------------	---

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	VI
---------------------------	----

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	IX
------------------------	----

ӨМНӨХ ҮГ	XI
----------------	----

НЭГ. УДИРТГАЛ	1
---------------------	---

1.1 Судалгааны асуудал	1
------------------------------	---

1.2 Судалгааны зорилго	3
------------------------------	---

1.3 Судалгааны асуулт	3
-----------------------------	---

1.4 Судалгааны хамрах хүрээ	3
-----------------------------------	---

1.5 Судалгааны ач холбогдол	3
-----------------------------------	---

1.6 Нэр томъёоны тайлбар	4
--------------------------------	---

ХОЁР. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ	7
-------------------------------------	---

2.1 Ардчилсан засаглалын тухай ойлголт, түүний хамрах хүрээ	7
---	---

2.2 Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагын тухай ойлголт, хэрэгжилт	14
---	----

2.3 Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлт, онолын арга зүй	19
---	----

2.4 Улс төрийн эрх, иргэний эрхийн хэрэгжилт ба иргэдийн дуу хоолой	27
--	----

2.5 Судалгааны үзэл баримтлал	34
-------------------------------------	----

ГУРАВ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	37
----------------------------------	----

3.1 Судалгааны арга, түүний төрөл	37
---	----

3.2 Судалгааны эх олонлог, түүвэр	37
---	----

3.3 Хувьсагч, түүний хэмжүүр	39
------------------------------------	----

3.4 Онч ба найдвартай байдал	41
------------------------------------	----

3.5 Өгөгдөл цуглуулах үйл явц	43
-------------------------------------	----

3.6 Өгөгдөл боловсруулалт	44
---------------------------------	----

ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН БОЛОВСРУУЛАЛТ	45
--	----

4.1 Монгол Улс дахь иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагын төлөв байдал	45
---	----

4.2 Асуулга судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл	49
---	----

4.3 Судалгааны дан тооллын үр дүн	53
---	----

4.4 Улс төрийн эрхийн тухай ойлголт	54
---	----

4.5 Эгэх хариуцлага	69
---------------------------	----



4.6 Үзүүлэлтийн тархалт	78
4.7 Хамаарлын шинжилгээний үр дүн	93
4.8 Эгэх хариуцлага ба улс төрийн эрх, иргэний эрхийн харьцуулалт	96
4.9 Кросстаб хүснэгтийн нэгдсэн үр дүн	101
4.10 Экспертүүдтэй хийсэн ярилцлагын дүн шинжилгээ	106
ТАВ. ДҮГНЭЛТ	111
5.1 Судалгааны дүгнэлт	111
5.2 Судалгааны хязгаарлалт	113
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	115
ХАВСРАЛТУУД	118
Хавсралт 1. Асуулга судалгааны анкет	118
Хавсралт 2. Экспертийн ярилцлагын асуулт	122

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ASD	Asian Development Bank Country Policy and Institutional Assessments
BTI	Bertelsmann Transformation Index
EIU	Economist Intelligence Unit
IFD	IFAD Rural Sector Performance Assessments
GWP	Gallup World Poll
GCS	Global Competitiveness Report
FRH	Freedom House
HER	Heritage Foundation Index of Economic Freedom
RSF	Reporters Without Borders Press Freedom Index
PRS	Political Risk Services
WBCPIA	World Bank Country Policy and Institutional Assessments
WJP	World Justice Project Rule of Law Index
GIBCRI	Global Insight Business Condition and Risk Indicators
VDM	Varieties of Democracy Project

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Засаглалын хэлбэр, түүний ангилал	15
Хүснэгт 2. Бертелсманы шилжилтийн индексийн суурь 17 шалгуур үзүүлэлт	25
Хүснэгт 3. Судалгааны үл хамаарах болон хамаарах хувьсагчдын үзүүлэлт	39
Хүснэгт 4. Судалгааны үл хамаарах ба хамаарах хувьсагчдыг хэмжих асуултууд	40
Хүснэгт 5. Хүчинтэй ба дотоод нийцтэй байдлын шинжүүрийн үр дүн ...	41
Хүснэгт 6. Судалгааны нийт хувьсагчдын Кронбах Альфа утга	42
Хүснэгт 7. Судалгааны хүчин зүйл тус бүрийн Кронбах Альфа утга	43
Хүснэгт 8. Улс төрийн эрхийн ойлголтын нэгтгэл	57
Хүснэгт 9. Улс төрийн эрхийн хэрэгжилт	61
Хүснэгт 10. Улс төрийн эрхийн хэрэгжилтийн талаарх ANOVA шинжилгээний үр дүн	62
Хүснэгт 11. Бүлэг хоорондын ялгааны үр дүн	62
Хүснэгт 12. Иргэний эрхийн асуултууд	65
Хүснэгт 13. Иргэний эрхийн хэрэгжилт	68
Хүснэгт 14. Иргэний эрхийн хэрэгжилтийн талаарх ANOVA шинжилгээний үр дүн	69
Хүснэгт 15. Бүлэг хоорондын ялгааны үр дүн	69
Хүснэгт 16. Иргэд дуу хоолойгоо хүргэх байдалтай холбоотой асуултын нэгтгэл	73
Хүснэгт 17. Эх орондоо үнэнч байдал	76
Хүснэгт 18. ANOVA шинжилгээ (иргэний улс төрийн эрхийн хэрэгжилт) .	76
Хүснэгт 19. ANOVA шинжилгээ (иргэний эрхийн хэрэгжилт)	77
Хүснэгт 20. ANOVA шинжилгээ (иргэний улс төрийн эрхийн хэрэгжилт, Дархан-Уул аймагт)	77
Хүснэгт 21. ANOVA шинжилгээ (иргэний эрхийн хэрэгжилт, Дархан-Уул аймагт)	77
Хүснэгт 22. ANOVA шинжилгээ (Дундговь аймагт)	77

Хүснэгт 23. ANOVA шинжилгээ (Иргэний эрхийн хэрэгжилт, Дундговь аймагт)	78
Хүснэгт 24. ANOVA шинжилгээ (Улаанбаатар хотод)	78
Хүснэгт 25. ANOVA шинжилгээ (Иргэний эрхийн хэрэгжилт, Улаанбаатар хотод)	78
Хүснэгт 26. Эгэх хариуцлага ба дуу хоолой (Асуулт 19, 22)	79
Хүснэгт 27. Эгэх хариуцлага ба дуу хоолой (Асуулт 19, 24)	80
Хүснэгт 28. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Дархан-Уул аймаг (Асуулт 19, 22)	81
Хүснэгт 29. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Дархан-Уул аймаг (Асуулт 19, 24)	81
Хүснэгт 30. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Дундговь аймаг (Асуулт 19, 22)	82
Хүснэгт 31. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Дундговь аймаг (Асуулт 19, 24)	83
Хүснэгт 32. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Улаанбаатар хот (Асуулт 19, 22)	84
Хүснэгт 33. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Улаанбаатар хот (Асуулт 19, 24)	85
Хүснэгт 34. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 27, 22)	86
Хүснэгт 35. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 27, 24)	87
Хүснэгт 36. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 28, 22)	87
Хүснэгт 37. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 28, 24)	88
Хүснэгт 38. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 29, 22)	89
Хүснэгт 39. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 29, 24)	90
Хүснэгт 40. Дуу хоолой ба эх орондоо үнэнч байдал (Асуулт 22, 27)	91
Хүснэгт 41. Дуу хоолой ба эх орондоо үнэнч байдал (Асуулт 22, 28)	91
Хүснэгт 42. Дуу хоолой ба эх орондоо үнэнч байдал (Асуулт 22, 29)	92
Хүснэгт 43. Улс төрийн эрхийн ойлголт/хэрэгжилт, иргэний эрхийн ойлголт/хэрэгжилт ба дуу хоолой	93



Хүснэгт 44. Дуу хоолой (идэвхтэй), улс төрийн эрхийн ойлголтын харьцуулалт (асуулт 22, 8)	94
Хүснэгт 45. Дуу хоолой (идэвхгүй), улс төрийн эрхийн ойлголтын харьцуулалт (асуулт 24, 8)	95
Хүснэгт 46. Иргэний эгэх хариуцлага, улс төрийн эрхийн ойлголтын харьцуулалт (асуулт 19, 8)	96
Хүснэгт 47. Иргэний эгэх хариуцлага, улс төрийн эрхийн хэрэгжилтийн харьцуулалт (асуулт 19, 15)	97
Хүснэгт 48. Иргэний эгэх хариуцлага, иргэний эрхийн хэрэгжилтийн харьцуулалт (асуулт 19, 20)	98
Хүснэгт 49. Нийгмийн эгэх хариуцлага, улс төрийн эрхийн ойлголтын харьцуулалт (асуулт 21, 8)	99
Хүснэгт 50. Нийгмийн эгэх хариуцлага, улс төрийн эрхийн хэрэгжилтийн харьцуулалт (асуулт 21, 15)	100
Хүснэгт 51. Нийгмийн эгэх хариуцлага, иргэний эрхийн хэрэгжилтийн харьцуулалт (асуулт 21, 20)	101

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Ардчилсан засаглалын тодорхойлолт, түүний хамрах хүрээ	8
Зураг 2. Либерал ардчиллын индекс, 2015-2022 оноор	16
Зураг 3. Ардчилал дахь иргэдийн оролцооны индекс, 2015-2022 оноор	16
Зураг 4. Ардчилал дах тэгш эрхийн индекс, 2015-2022 оноор	17
Зураг 5. Русбултын онол дахь хувьсагч хоорондын харилцан хамаарал ..	28
Зураг 6. Улс төр дэх харилцаа “Орхих”, “Дуу хоолой”, “Үнэнч байх”	30
Зураг 7. Судалгааны үзэл баримтлалын зураглал	35
Зураг 8. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын эрхийн ангиллын үзүүлэлт, хувиар (2023-2024.05 сар)	47
Зураг 9. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, агуулга (2023-2024.05 сар) ..	48
Зураг 10. Өргөдөл, гомдолд хариу өгсөн байдал, хувиар	49
Зураг 11. Судалгаанд хамрагдсан аймгуудын түүврийн хэмжээ, тоогоор	50
Зураг 12. Судалгаанд хамрагдагчдын насны бүлэг, дүнд эзлэх хувиар	50
Зураг 13. Судалгаанд хамрагдагчдын насны бүлэг, дүнд эзлэх хувиар, аймгаар	51
Зураг 14. Судалгаанд хамрагдагчдын хүйсийн харьцаа, аймгаар, тоогоор	51
Зураг 15. Судалгаанд хамрагдагчдын боловсролын түвшин, аймаг, хотоор	52
Зураг 16. Судалгаанд хамрагдагчдын ажил эрхлэлтийн байдал, аймаг, хотоор	52
Зураг 17. Судалгаанд хамрагдагчдын ажилладаг байгууллагын төрөл, хувиар	53
Зураг 18. Иргэд үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох эрхээ эдэлдэг эсэх	54
Зураг 19. Улс төрийн эрх нь ардчиллын баталгаа мөн эсэх	55
Зураг 20. Иргэдийн улс төрийн эрхийн халдашгүй байдал	55

Зураг 21. Иргэд улс төрийн эрхээ хараат бусаар эдэлж чаддаг эсэх	56
Зураг 22. Сонгуулийн холимог тогтолцоо зөв эсэх	58
Зураг 23. Сонгууль шударга явагддаг эсэх	58
Зураг 24. СЕХ хараат бусаар сонгууль зохион байгуулдаг эсэх	59
Зураг 25. СЕХ-ны удирдлагын сонгон шалгаруулалтын оновчтой байдал ..	60
Зураг 26. УИХ-ын гишүүд шударгаар сонгогдсон эсэх	60
Зураг 27. Иргэний эрхээ хэрэгжүүлэхэд нийгмийн байгууллагын талаарх ойлголт	63
Зураг 28. Хэнийг ч сонгоод өөрчлөлт авчрахгүй	63
Зураг 29. Эх орондоо сайхан амьдрах боломжтой эсэх	64
Зураг 30. Сонгогчдын бүртгэл зөв хийгддэг эсэх	65
Зураг 31. Нэр дэвшигчдэд ижил, тэгш боломж олгогддог эсэх	66
Зураг 32. Сонгууль нууц санал хураалтаар явагддаг эсэх	67
Зураг 33. Санал хүсэлтээ илэрхийлэх хэрэгтэй эсэх	67
Зураг 34. Эгэх хариуцлагатай байх ёстой эсэх	70
Зураг 35. Нийгмийн тулгамдсан асуудлын талаар хаана ч хэнд ч хандаад нэмэргүй	71
Зураг 36. Жагсаал, цуглаанд оролцох хэрэгтэй эсэх	71
Зураг 37. Нийгмийн сүлжээгээр санал бодлоо илэрхийлдэг эсэх	72
Зураг 38. Өндөр хөгжилтэй улсад амьдрах хүсэлтэй эсэх	74
Зураг 39. Гадаад, дотоод шилжилт хөдөлгөөний идэвхжилийн талаар ...	74
Зураг 40. Орхих хүсэлтэй эсэх	75
Зураг 41. Судалгаанд оролцогчдын “дуу хоолой, үнэнч байдал, орхих” гурван хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн	102
Зураг 42. Дархан хотын иргэдийн “дуу хоолой, үнэнч байдал, орхих” хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн	103
Зураг 43. Улаанбаатар хотын иргэдийн “дуу хоолой, үнэнч байдал, орхих” хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн	104
Зураг 44. Дундговь аймгийн иргэдийн “дуу хоолой, үнэнч байдал, орхих” хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн	105

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 47 дугаар заалтаар “Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба хариуцлага”-ыг жил тутамд хэмжих, үзүүлэлтийг тоон болон экспертийн ярилцлагын үр дүнгээр тодорхойлж байх, хэрэгжүүлэгч байгууллагыг ЗГХЭГ-ын харьяа Төрийн албаны сургууль гэж үүрэгжүүлж өгсний дагуу Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн судалгааны баг “Засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагыг хэмжих нь” сэдэвт тодорхойлох судалгааг 2024 оны захиалгаар гүйцэтгэв.

Монгол Улсын хувьд иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага засаглалын үзүүлэлт сүүлийн жилүүдэд буурч, иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага 2021 онд 58.45 оноотой, 2022 онд 57.49 оноотой, 2023 онд 56.04 оноотой байна (World Bank, 2023). Хэдийгээр “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг судлах, түүний үр нөлөөг үнэлэхээс гадна хэрэгжилтийг тодорхойлох шалгуур үзүүлэлт тус бүрийн агуулгыг зөвөөр ойлгох, үзүүлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тайлбарлах, улмаар засаглалын чанарыг сайжруулах зөвлөмж гаргахад чиглэнэ.

Судалгаагаар нэгдүгээрт, “иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагын үзүүлэлтэд улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт хэрхэн нөлөөлж байгааг” тодорхойлох судалгааны асуултыг дэвшүүлж, санал асуулгын анкетаар Улаанбаатар хот, Дархан-Уул, Дундговь аймгуудын иргэдийн төлөөллийг хамруулсан судалгааны үр дүнгээс үзэхэд улс төрийн эрхийн ойлголт нэмэгдэх тусам иргэдийн дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхол нэмэгдэж байгаа нь нотлогдсон. Өөрөөр хэлбэл, ардчилсан засаглалын чанар иргэдийн улс төрийн боловсролоос шууд хамааралтай болох нь харагдаж байна.

Судалгаагаар хоёрдугаарт, “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагад иргэний эрхийн хэрэгжилт хэрхэн нөлөөлж байгааг” тодруулах асуулт дэвшүүлж, улс төрийн эрхийн хэрэгжилт иргэний эрхийн хэрэгжилтийн хамаарлыг тодорхойлсон. Улс төрийн эрхийн хэрэгжилтийг тодорхойлох иргэдийн дуу хоолойгоо илэрхийлэх байдал, эгэх хариуцлага шаардах байдал нь иргэний эрхийн хэрэгжилтээс шууд хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, иргэний эрхийн хэрэгжилт нь улс төрийн эрхийн ойлголтоос шууд хамааралтай байна.

Үүнийг тодруулж, судлаач О.Хиршманы онолын үзэл баримтлалын хүрээнд иргэдийн “Дуу хоолой”, “Үнэнч байдал”, “Орхих” хүчин зүйлсийн харилцан хамааралд Улаанбаатар хот, Дархан-Уул болон Дундговь аймгийн хооронд харьцуулсан дүгнэлт хийхэд Улаанбаатар хотын зургаан дүүргийн 395 иргэдийн дунд улс төрд итгэл алдарсан “цөхөрсөн бүлэг” 14.2 хувь, Дархан-Уул аймгийн 382 иргэдийн дунд “цөхөрсөн бүлэг” 17.9 хувь, Дундговь аймгийн 267 иргэдийн дунд “цөхөрсөн бүлэг” 13.1 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, иргэд дуу хоолойгоо төрийн байгуулалд хүргэх хүсэлтэй боловч иргэдийн дуу хоолойд хариу үйлдэл үзүүлэх эгэх хариуцлагын механизм сул байна.

Нэгтгэн дүгнэхэд, иргэний эрхийн хэрэгжилт муу байх нь нийгмийн эгэх хариуцлага муу байхад шууд нөлөөтэй буюу хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцаанд иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт муудахад иргэний эрхийн хэрэгжилт муудах нөхцөл болж, улмаар нийгмийн эгэх хариуцлага буурахад шууд нөлөөлдөг байна.

Судалгааны баг

1.1 Судалгааны асуудал

Монгол Улсын хувьд урт хугацааны хөгжлийн бодлогыг тогтвортой байлгах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зорилгын хүрээнд 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 25-р зүйлийн 7-р заалтад “Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна” хэмээн хуульчилж, улмаар хуулийн хэрэгжилтийг хангахын тулд УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 47 дугаар заалтаар “Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба хариуцлага”-ыг жил тутамд хэмжих, үзүүлэлтийг тоон болон экспертийн ярилцлагын үр дүнгээр тодорхойлж байх, хэрэгжүүлэгч байгууллагыг ЗГХЭГ-ын харьяа Төрийн албаны сургууль гэж үүрэгжүүлсэн.

Засаглалын чанарыг тодорхойлох судалгаанд дараах Дэлхийн Банкны зургаан үзүүлэлтийг ашиглаж байхаар хуульчилсан. Үүнд:

1. Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага (*Voice and Accountability*) – Тухайн улс орны иргэд төрийн байгууллыг сонгох үйл явцад оролцож чадаж байгаа эсэх (Хууль тогтоох засаглал), төрийн үйл ажиллагааны хүрээнд Үндсэн хуулиар олгосон жам ёсны эрхээ эдлэхдээ өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэж байгаа эсэх, иргэний эрхийг хамгаалах чөлөөт хэвлэл мэдээллийн хараат бус тогтолцоо бий эсэх,
2. Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл/терроризмгүй байх (*Political Stability and Absence of Violence*) – Улс төрийн тогтворгүй байдал эсвэл улс төрийн сэдэлтэй хүчирхийлэл, терроризм гарах магадлал, нөхцөл бий эсэх,
3. Засгийн газрын үр дүн (*Government Effectiveness*) – Төрийн үйлчилгээ, төрийн албаны чанар, түүний улс төрийн нөлөөллөөс ангид эсэх, бодлого боловсруулалт, хэрэгжилтийн чанар, засгийн газрын бодлогод тавих хяналт, хариуцлагатай байх нөхцөл бүрэлдсэн эсэх,
4. Зохицуулалтын чанар (*Regulatory Quality*) – Засгийн газар нь зөв бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чадвартай, хувийн салбарын хөгжлийг дэмжих, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж байгаа эсэх,

5. Эрх зүйт төрийн үйл ажиллагаа (*Rule of Law*) – Нийгмийн дүрэм журмыг сахих итгэл үнэмшлийн хэр хэмжээ, гэрээний хэрэгжилт, өмчлөх эрх, цагдаа болон шүүхийн чанар, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлал байгаа эсэх,

Авлигын хяналт (*Control of Corruption*) – Хувийн зорилгоор төрийн эрх мэдлийг ашиглаж буй байдал, жижиг болон том хэмжээний авлигын хэлбэрүүд, элитүүд болон хувийн ашиг сонирхол төрийг “эзэлсэн” эсэх зэрэг үзүүлэлтүүд юм (World Bank, 2021).

Улсын Их Хурал нь 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай хуулийг баталж, Монгол Улсын хувьд засаглалын үзүүлэлтийг хэмжих эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үүнтэй зэрэгцэн улс орны хөгжлийн бодлогыг урт хугацаанд төлөвлөх, түүнд чиглэсэн Засгийн газрын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх, мөрийн хөтөлбөрийг Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулах, төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх арга зүйг тодорхойлон хуульчилсан (Улсын Их Хурал, 2020).

Монгол Улсын хувьд 1996 оноос хойш Дэлхийн Банкны засаглалын индекс тодорхойлох судалгаанд тасралтгүй хамрагдаж ирсэн бөгөөд хамгийн сүүлийн судалгааны үр дүн нь 2022 оны үнэлгээгээр гарсан байна. Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлт нь олон тооны судалгааны үр дүнг нэгтгэн гаргадаг аргачлалтай тул нэг жилээр хоцорч гардаг уламжлалтай. Энэхүү засаглалын индексийг тодорхойлох арга зүй нь зургаан үзүүлэлттэй хэдий ч энэ судалгааны хүрээнд зөвхөн “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” (*Voice and Accountability*) үзүүлэлтийн үнэлгээг судалж, цаашид иргэдийн дуу хоолой болон эгэх хариуцлага үзүүлэлтийг хуулийн дагуу хэрхэн жил тутамд үнэлж байх арга зүйг тодорхойлоход чиглэж байна.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг үнэлж, жил бүр зөвлөмж боловсруулах, засаглалын үзүүлэлтийн үнэлгээний үр дүн, түүний шалтгаант холбоог шинжлэх ухаанчаар тайлбарлах, үнэлгээнд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлсийг оношилж тогтоох нь энэхүү судалгааны зорилго.

1996 оноос хойш Монгол Улс засаглалын үзүүлэлт тус бүрээр ямар үнэлгээ авч байсан, ямар хүчин зүйлсийн улмаас тодорхой үзүүлэлт буурч, өсөж байсан шалтгааныг тодруулснаар цаашид бодлого боловсруулах,

хэрэгжүүлэхэд анхаарах хүчин зүйлсийг илрүүлж, улмаар Засаглалын үзүүлэлт тус бүрийг Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилттэй уялдуулан сайжруулах шаардлага хуулийн дагуу үүсээд байгаа болно.

Энэ нь нэг талдаа Засгийн газрын үйл ажиллагааны чанарыг сайжруулах боломж, нөгөө талдаа төрийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд иргэдийн дуу хоолойг хэрхэн тусгах, иргэдийн эгэх хариуцлагын үнэлгээ ямар төлөвтэй байгааг тодорхойлох нь судалгааны суурь хэрэгцээ юм. Засаглалын үзүүлэлт “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” ямар үүрэгтэй болохыг онолын хүрээнд тайлбарлах, уг үзүүлэлтийн агуулга, түүний тоон утгын ач холбогдлыг улс төрийн шийдвэр гаргагч нарт таниулахад судалгааны үр дүн чиглэж байна.

1.2 Судалгааны зорилго

Засаглалын үзүүлэлт “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага”-ын хэрэгжилтэд иргэний улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт болон иргэний эрхийн хэрэгжилт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлон тайлбарлахад чиглэнэ.

1.3 Судалгааны асуулт

- “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” үзүүлэлтэд улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт хэрхэн нөлөөлж байна вэ?
- “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” үзүүлэлтэд иргэний эрхийн хэрэгжилт хэрхэн нөлөөлж байна вэ?

1.4 Судалгааны хамрах хүрээ

Дэлхийн Банкнаас гаргасан засаглалын зургаан үзүүлэлт нь ТӨР-ИРГЭН-ИРГЭНИЙ НИЙГЭМ, ХУВИЙН ХЭВШИЛ-ийг оролцуулсан нийгмийн харилцааны хувьд засаглалын оролцогч талуудын үйл ажиллагааг хамруулан засаглалын чанарыг тодорхойлоход чиглэх ба Удирдлагын академийн захиалгат судалгааны хамрах хүрээ нь зөвхөн “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” үзүүлэлтэд иргэний улс төрийн эрхийн хэрэгжилт, иргэний эрхийн хэрэгжилт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох, тайлбарлахад чиглэгдэнэ.

1.5 Судалгааны ач холбогдол

Монгол Улсын хувьд иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага засаглалын үзүүлэлт сүүлийн жилүүдэд буурч, иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага 2021 онд 58.45 оноотой, 2022 онд 57.49 оноотой, 2023

онд 56.04 оноотой байна (World Bank, 2023). Харин Фрийдом Хаус¹ 2023 оны судалгааны ардчиллын эрх чөлөөний үзүүлэлтээр Монгол Улс 84 оноо авсан буюу эрх чөлөөтэй ангилалд багтаж² (Freedom House, 2023) эрх чөлөөний түвшин 1.5 оноо, улс төрийн эрхийн хэрэгжилт 1 оноотой, иргэний эрхийн эрхийн хэрэгжилтээр 2 оноотой байна. Фрийдом Хаусын ардчиллын эрх чөлөөний үзүүлэлтээр сайн үнэлгээтэй байгаа хэдий ч засаглалын үзүүлэлтүүд нь Дэлхийн Банкны судалгааны үр дүнгээр яагаад сулраад³ байна вэ? гэсэн асуулт гарч байна. Иймд иргэний улс төрийн болон иргэний эрхийн хэрэгжилтийн үнэлгээ нь ардчиллын эрх чөлөө болон засаглалын чанар гэсэн ялгаатай ойлголтуудад ямар ач холбогдолтой байгааг тодруулах шаардлага үүсэж байна.

Мөн УИХ-аас 2020 онд баталсан “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөг тасралтгүй үнэлэх шаардлага тулгарч байна. Гэхдээ үнэлэхээс гадна үнэлгээний үзүүлэлт тус бүрийн агуулгыг зөвөөр ойлгох, үзүүлэлтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулан тайлбарлах, улмаар засаглалын чанарыг сайжруулах хэрэгцээнд энэхүү судалгааны үр дүн хувь нэмэр оруулах боломжтой юм.

“Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” үзүүлэлт буурсан шалтгааныг шинжлэх ухааны үндэслэлтэй, нотолгоонд суурилж тодорхойлсноор олон улсын болон дотоодын судлаач, экспертүүдийн санал зөвлөмжийг тусгасан нөхцөл байдлын үнэлгээ хийх боломжтой. Энэ нь урт, дунд болон богино хугацааны бодлогын хэрэгжилтийн үр дүн, нийгэмд үзүүлж буй үр нөлөөг дүгнэх, шаардлагатай нөхцөлд зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

1.6 Нэр томьёоны тайлбар

Засаглал – Грекийн “Kubernáo” буюу “Залуурдах, жолоодох” гэсэн үгнээс гаралтай. Монгол хэлний тайлбар тольд энэ үгийг “Засаг төр барих” гэжээ. Энэ нь өргөн утгаараа, засгийн газар, орон нутгийн эрх мэдлийн байгууллагуудаас эрх мэдлийн хүрээндээ хэрэгжүүлж буй үйл ажиллагаа юм (Конрад-Аденауэр-Сан, 2022).

Улс төрийн эрх – Улс төрийн эрх гэдэг нь хувь хүн болон бүлэгт засгийн эрх, төрийн үйл ажиллагаанд оролцох, өөрийн хүсэл зоригоо илэрхийлэх,

¹ Фрийдом хаус нь төрийн бус байгууллага нь 1973 оноос эхлэн Дэлхийн улс орнуудын ардчиллыг үнэлж, эрх чөлөөтэй, хагас эрх чөлөөтэй, эрх чөлөөгүй гэсэн үнэлгээг өгч ирсэн. Тухайн улс орны ардчиллын түвшинг үнэлэхдээ улс төрийн эрх болон иргэний эрх гэсэн хоёр үндсэн шалгуур үзүүлэлтээр үнэлдэг. Үнэлгээг өгөхдөө 1-7 хүртэл оноо өгдөг бөгөөд 1 хамгийн ардчилсан, 7 оноо хамгийн эрх чөлөөгүй юм.

² [0 = хамгийн бага эрх чөлөөгүй, 100 = хамгийн их эрх чөлөөтэй]

³ <https://www.theglobaleconomy.com/Mongolia/indicators> retrieved on 2024.12.05

бодлого тодорхойлох үйл явцад нөлөөлөх хууль ёсны боломжийг хэлнэ. Энэ нь иргэний эрхийн нэгэн хэсэг бөгөөд ардчилсан засаглалтай нийгэмд хүн бүрт олгогдсон үндсэн эрх, эрх чөлөөнд хамаардаг.

Иргэний эрх – Иргэний эрх нь тухайн улсын иргэдэд олгогдсон хуулиар баталгаажсан үндсэн эрх, эрх чөлөөний цогц ойлголт юм. Энэ нь иргэний хувьд улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн салбарт чөлөөтэй амьдрах, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах, хүний эрхийг эдлэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Улс төрийн эрхийн хэрэгжилт – Улс төрийн эрхийн хэрэгжилт гэдэг нь иргэдийн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг бодитойгоор эдлүүлэх, тэдний үзэл бодлоо илэрхийлэх, сонгох, сонгогдох, төрийн байгууллагад оролцох нөхцөлийг хангах үйл явц юм. Улс төрийн эрхийн хэрэгжилт нь ардчилсан тогтолцооны үндэс бөгөөд хууль эрх зүйн орчин, төрийн хяналт, иргэний оролцоогоор баталгааждаг. Үүнийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд улс төрийн шударга байдал, мэдээллийн хүртээмж, сонгуулийн хяналт, иргэдийн тэгш оролцоог хангах шаардлагатай.

Иргэний эрхийн хэрэгжилт – Иргэний эрхийн хэрэгжилт гэдэг нь иргэдийн хууль ёсоор олгогдсон үндсэн эрх, эрх чөлөөг амьдралд бодитой хэрэгжүүлж, хамгаалах үйл явц юм. Иргэний эрхийн хэрэгжилт нь тухайн улсын хуулийн тогтолцоо, төрийн үйл ажиллагааны ил тод байдал, иргэдийн эрх зүйн мэдлэгтэй салшгүй холбоотой. Энэ нь хүний эрхийг хамгаалах, ардчилсан нийгмийг бэхжүүлэх гол үндэс суурь болж өгдөг.

Шалгуур үзүүлэлт – Тус судалгаанд шалгуур үзүүлэлт гэсэн ойлголтыг Дэлхийн Банкнаас гаргасан засаглалын үзүүлэлт гэсэн утгаар ойлгож, хэрэглэж байгаа болно. Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлтээр 1996 оноос хойш дэлхийн улс орнуудын засаглалын чанарыг үнэлж байна. Энэхүү зургаан үзүүлэлтээр дэлхийн 200 гаруй улсын засаглалын чанарыг 30 гаруй олон улсын нэр хүнд бүхий байгууллагаас хийдэг 40 орчим судалгаан дээр тулгуурлан хэмждэг (World Bank, 2021).

Иргэдийн оролцоо – “Participation” гэдэг нь Францын “Participacion” (XIII зууны үе), Латины “Participationem” үгнээс үндэстэй. Үгийн утга нь “оролцоо [partaking]” гэсэн санааг илтгэдэг. Гэхдээ “Participation” гэдэг нь доороос дээш чиглэсэн буюу иргэдийн санаачилгад тулгуурласан оролцооны хэлбэр юм (Конрад-Аденауэр-Сан, 2022).

Иргэдийн дуу хоолой – Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага (Voice and Accountability) гэсэн ойлголт нь Дэлхийн Банкнаас гаргасан засаглалын үзүүлэлтийн хүрээнд тухайн улс орны иргэд төр засгаа сонгох

үйл явцад оролцож чадаж байгаа эсэх, түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, чөлөөт хэвлэл мэдээлэл байгаа эсэх тухай агуулгыг багтаана (World Bank, 2021).

Эгэх хариуцлага – (Accountability) Улс төрийн шинжлэх ухаанд эгэх хариуцлага хэмээх ойлголт нь тухайн үүрэг хариуцлагыг алдсаны төлөө хүлээх зэм шийтгэл болон ажил үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагаврыг тайлагнах, хамгаалах үүргийг багтаасан субъект өөртөө хүлээх, ухамсарлагдах явдлыг хэлдэг (Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг, 2020. х.809).

Үнэнч байх – (Loyalty) Үнэнч байдал нь нийтлэг ёс суртахууны хэм хэмжээнд суурилсан эсвэл оновчтой ашиг сонирхолд тулгуурласан дотоод холбоо, түүний зан төлөвт хүн эсвэл бүлэгт хандах хандлагын илрэл. Үнэнч байдал гэдэг нь нийтлэг дээд зорилгын төлөө бие биеийнхээ үнэт зүйлийг (болон үзэл суртлыг) хуваалцах, төлөөлөх, эсвэл бүрэн хуваалцаагүй байсан ч энэ нь хуваалцсан дээд зорилгыг хадгалахыг дэмжих гэсэн агуулгатай. Үнэнч байдал нь үнэнч байгаа хүмүүст болон гуравдагч этгээдэд хандах зан төлөвт хоёуланд нь илэрдэг⁴.

Орхих – (Exit⁵ буюу Орхих агуулга нь) Альберт О.Хиршманы дэвшүүлсэн эдийн засаг, социологи, улс төр судлалын нэр томьёо. Үүний гол агуулга нь нийгмийн харилцаа, хүн хоорондын харилцаа, улс төрийн харилцаанд иргэдийн хариу үйлдэл үзүүлэх үндсэн гурван арга замын тодорхойлолт юм. Иргэд аливаа нэгэн байгууллагатай харилцаагаа таслах (Орхих-Exit), иргэд өөрсдийн зүгээс гомдол, өөрчлөлт оруулах хүсэлт гэх мэтээр харилцаагаа дахин нэгтгэхийг оролдох (Дуу хоолойгоо хүргэх - Voice), эсхүл тухайн байгууллагыг дэмжсэн хэвээр байхыг (Үнэнч - Loyalty) илэрхийлнэ. Эдгээр хэлбэр нь ихэвчлэн улс төрийн харилцаанд иргэдийн оролцооны төрөл (Voice), санаатай эс оролцох буюу орхих (Exit), үнэнч бус байх (Disloyalty) гэсэн байдлаар илэрдэг (Hirschman, 1970).

⁴ <https://www.values-academy.de>

⁵ Герман хэлээр Abwanderung, Widerspruch und Loyalität

ХОЁР. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

2.1 Ардчилсан засаглалын тухай ойлголт, түүний хамрах хүрээ

1992 оны Үндсэн хуулиар “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” (Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр заалт) хэмээн засаглалын хэв шинжийг тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, Улсыг удирдах бүрэн эрх⁶-ийг улс төрийн сонгуулиар УИХ-д шилжүүлж, УИХ-ын гишүүдийн олонхын саналаар байгуулсан Засгийн газрын үйл ажиллагаанд иргэд шууд болон төлөөллөөр уламжлан оролцдог, мөн хариуцлага тооцдог байх механизмыг Үндсэн хуулиар бүрдүүлсэн байна.

Дэлхий дахинд өрнөсөн ардчиллын гурав дахь давлагаатай зэрэгцэн Монгол Улс төлөөллийн ардчилсан тогтолцоонд 1990 онд шилжиж, 1992 онд шинэ Үндсэн хуулиа батлаад 32 жил өнгөрч байна. Энэхүү ардчиллын шилжилт нь улс төрийн нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоо руу, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн тогтолцоо руу, нэг намын үзэл суртлын хязгаарлалттай нийгмийн харилцаанаас олон ургалч үзэлтэй хувь хүний хөгжлийг чухалчилсан нийгмийн харилцааны шилжилт байсан. 2023 оны Бертелстманны⁷ судалгааны улс төрийн шилжилтийн үзүүлэлтээр Монгол Улс нь 7.25 оноо авсан⁸ буюу улс төрийн шилжилтийн онолоор “Соготой буюу гажуудсан”⁹ засаглалтай улс орны эгнээнд байна (Merkel. W, Puhle. H.J, Croissant. A, 2003).

Өнөөгийн байдлаар улс төр, эдийн засаг болон нийгмийн салбарын судлаачдын дунд ардчилсан засаглалын тухай нэгдсэн тодорхойлолт байдаггүй. Учир нь тухайн улсын засаглалын хэв шинжээс хамааран судлаачид өөр өөрийн тодорхойлолтыг санал болгож, судалгааны үзэл баримтлалыг боловсруулсаар ирсэн. 2002 онд Дэлхийн Банкнаас гаргасан “Зах зээлийг дэмжсэн институтыг бий болгох нь” дэлхийн хөгжлийн илтгэлд засаглалыг “дүрэм журам, хэрэгжүүлэх механизм, байгууллагууд”

⁶ Sovereignty

⁷ Ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжиж байгаа улс орнуудын хөгжлийн болон шилжилт, өөрчлөлтийн үйл явцыг судлах зорилготой төсөл бөгөөд хоёр жил тутамд шинэчлэгддэг. 137 улс орныг хамардаг бөгөөд улс орнуудын оноог 1-10 хүртэлх үнэлгээгээр тодорхойлдог. Индекс нь судалгаа, мэргэжилтнүүдийн үнэлгээнд үндэслэн гардаг бөгөөд дэлхий нийтийн ардчилал, зах зээлийн эдийн засгийн чиг хандлагыг ойлгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

⁸ <https://bti-project.org/en/reports/country-dashboard/MNG/2024/12/22>.

⁹ Wolfgang Merkel. Defekte Demokratie, 2003.

гэж тодорхойлсон (World Bank, 2021). Харин 1992 онд “Хөгжлийн төлөө улс орны нийгэм, эдийн засгийн нөөцийн удирдах эрх мэдлээ хэрэгжүүлж буй арга барил” гэж илүү явцуу утгаар тодорхойлжээ (Kaufmann. D, Крау. А, Mastruzzi. М, 2010).

1990 оноос хойших ардчилсан засаглалын судалгаанууд голчлон тухайн улсын төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч байгууллага (Парламент) нь иргэдийнхээ улс төрийн эрх чөлөөг (*Freedom*) хангаж чадаж байгаа эсэх, иргэд өөрсдөө нийгэм, улс төрийн харилцаанд гарааны тэгш эрхтэй (*Equality*) орж чадаж байгаа эсэх, иргэд улс төрийн шийдвэр гаргах үйл явцад бодит оролцоотой, хяналттай (*Control*) байгаа эсэх зэрэг шалгуурыг тоон болон чанарын үзүүлэлтээр хэмжих, засаглалын индексийг тооцоолох зорилгоор төрөл бүрийн судалгааны арга зүйг ашиглаж байна.

Энэ ч утгаараа ардчилсан засаглалын тухай онолын үзэл баримтлал, түүний хамрах хүрээг судлаачид ялгаатай авч үздэг (Buehlmann. М, Merkel. W, Mueller. L, Giebler. H, Wessels. B, 2012). Тухайн судлаачийн харах өнцөг, судалгааны асуудал, онолын үзэл баримтлал зэргээс шалтгаалан ардчилсан засаглалын тухай тодорхойлолтыг гурван ялгаатай түвшинд авч үзэн судалж байна (Зураг 1).

Зураг 1. Ардчилсан засаглалын тодорхойлолт, түүний хамрах хүрээ



Эх сурвалж: Lauth. H.J, Schlenkrich. O (2020). *Konzeption der Demokratiematrix.*

Ардчилсан засаглалын ялгаатай тодорхойлолт, түүний хамрах хүрээ хамгийн бага байх нөхцөлийг Роберт Далийн онолын үзлээр авч үзвэл улс төрийн хүрээнд нэр дэвшигчдийн өрсөлдөөнийг бага байлгах, нийт сонгогчдын олонхын саналыг авах боломжийг бүрдүүлэх, иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилтийг хангасан байх тухай сонгуулийн мажоритар тогтолцооны ойлголтоос эхэлдэг (Dahl. R.A, 1971). Энэхүү агуулга нь ардчилсан засаглалын хэв шинжийг иргэдийн улс төрийн оролцоогоор илэрхийлэх хэдий ч иргэд улс төрийн бодит оролцоотой, дүр эсгэсэн оролцоотой байсан эсэхийг тодорхойлохгүй бөгөөд засаглалын хэв шинж нь автократ болон гажуудалтай ардчилсан тогтолцоотой эсэхийг үнэлээгүй, мөн засаглал хоорондын үндсэн ялгааг илэрхийлж чаддаггүй сул талтай. Өөрөөр хэлбэл, иргэд улс төрийн сонгуулийн бодит оролцоотой засаглах үйл явцыг бүрэн эрхтэйгээр удирдаж байна уу? эсрэгээр засаглах үйл явц нь улс төрийн сонгуулийн оролцоогоор иргэдийг удирдан чиглүүлж байна уу? гэдэг асуултад хариулт өгдөггүй. Үүний цаана ардчилсан засаглалын хамрах хүрээний тухай ойлголт, ялгаатай тодорхойлолтууд болон түүнийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлтийн утга оршдог.

Ихэнх улс орнуудад үндсэн хуулиараа ардчилсан засаглалын тогтолцоог¹⁰ хуульчилсан байдаг. Парламентын болон Ерөнхийлөгчийн хэв шинжтэй ардчилсан засаглал төлөвших шилжилтийн процесст нэг сонгуулиас нөгөө сонгуулийн мөчлөгт иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилт сулрах нөхцөлүүд үүсдэг гэж судлаачид үздэг. Энэхүү шилжилтийн процессын явцад улс төрийн сонгуульт дарангуйлал болон либерал ардчилсан засаглалын хооронд орших завсрын саарал бүсийн ялгааг олж тогтоох боломж хомс гэдгийг судлаачид онцолдог (Gerardo. L.M, Vertkuilen. A, 2002).

Учир нь эрх зүйт төрийн (*Rule of Law*) хэв шинж буюу төрийн байгууллын зохион байгуулалт нь хуульчлагдсан, нийгэм, улс төр, эдийн засгийн харилцаанд хараат бус мэт хэвлэл мэдээллийн тогтолцоо бүрэлдсэн буюу эрх чөлөөт иргэний нийгэм төлөвшсөн шинжтэй, Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх засаглалын эрх мэдлийн хуваарилалтыг хуулиар заагласан боловч улс төрийн үйл ажиллагаанд сонгуульт дарангуйллын хэв шинж байгаа эсэх зэргээс улбаалан засаглал дахь улс төрийн нөлөө, түүний харилцан хамаарлыг нарийвчлан олж тогтоох боломж хэцүү байдаг. Ийм ч учраас засаглалын хэв шинж нь улс орон бүрийн хувьд өвөрмөц, тухайн улсын соёл, уламжлал болон улс төр, эдийн засаг,

¹⁰ Парламентын болон Ерөнхийлөгчийн ардчилсан засаглалын тухай.

нийгмийн хөгжлийн онцлогоос хамаарч ялгаатай байдаг. Үүний цаад шалтгаан нь Ерөнхийлөгчийн болон Парламентын засаглалын хэв шинжтэй холбоотой бөгөөд сонгуульт ардчилал (*electoral democracy*) эсвэл либерал ардчилал (*liberal democracy*) нийгмийн харилцаанд хэр сайн төлөвшсөн гэдгээс хамаардаг байна.

Хэдийгээр сонгуульт ардчиллын (*electoral democracy*) онол нь 1941 онд АНУ-ын судалгааны институцийн санал болгосон хувилбар боловч дэлхийн хүйтэн дайны цаг үед “барууны” гэх тодотголтой “либерал ардчилал” нэг талд, нөгөө талд зүүний гэх тодотголтой, ЗХУ-д бий болсон улс төрийн “сонгуульт ардчилал” гэх авторитар хэв шинжтэй засаглал бүрэлдэн бий болж, ардчилсан засаглал нэрийн дор ялгаатай засаглах хэв шинж бүхий концепц үүссэн түүхтэй (Campbell, D.F.J, Barth, T.D., 2009). Энэхүү сонгуульт ардчилсан засаглалын хэв шинж нь дараах дөрвөн шалгуурыг өөртөө агуулах бөгөөд Фрийдом Хаус (Freedom House)¹¹ эдгээр шалгуурыг ардчилсан засаглалын хамгийн бага хамрах хүрээ гэж үздэг. Үүнд:

1. Олон намын тогтолцоотой байх,
2. Сонгуулийн насны иргэн бүр сонгох эрхтэй байх,
3. Сонгууль улс төрийн зөрчилгүй явагдаж, тогтсон хугацаатай, иргэдийн саналын дагуу төлөөллийн байгууллага бүрддэг байх,
4. Сонгогчид хэвлэл мэдээлэл, улс төрийн үйл ажиллагаа, олон нийтийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлдэг байх.

Энэхүү ардчилсан засаглалын хамгийн бага хамрах хүрээний шалгуур, тэдгээрийг хэрэгжүүлэх асуудлыг улс төрийн шинжлэх ухаанд ардчиллын давлагаатай холбон тайлбарлаж байна. Учир нь 1945 оноос хойш ардчилсан засаглалын хэв шинж, ардчиллын хамрах хүрээний шалгуурыг тодорхойлохдоо тухайн улс орны нийгмийн хөгжлийн явцыг ардчиллын давлагаатай холбон тайлбарлаж эхэлсэн байдаг (Huntigton, 1991). Мөн 2000 оноос эхлэн даяарчлалын¹² агуулга, түүний хамрах хүрээг ардчиллын дөрөв дэх давлагаа (McFaul, 2002) хэмээн үзэж, Ерөнхийлөгчийн болон Парламентын засаглалын хэв шинжээс үл хамааран сайн засаглалын шалгуурыг дэлхий дахинаа ашиглахыг санал болгож эхэлсэн (Luethi, 2023).

Сонгуульт ардчилал (*electoral democracy*) болон либерал ардчиллын хэв шинжийн (*liberal democracy*) хооронд чанарын асар ялгаа байгааг

¹¹ <http://freedomhouse.org/>

¹² Globalization

судлаачид тэмдэглэдэг (Pickel, S., Gert. P, 2006b). Тухайлбал, Ларри Диамонд, Леонардо Морлино (Diamond. L, Morlina. L, 2004) нар ардчилсан засаглал дахь хамрах хүрээг найман хэмжээстэй байхаар тодорхойлж, засаглалын чанарыг хэмжихийг оролдсон. Үүнд:

1. Эрх зүйт төрийн тогтолцоо (*Rule of Law*)
2. Иргэний оролцоо байгаа эсэх (*Partizipation*)
3. Өрсөлдөөний тэгш боломж байгаа эсэх (*Competition*)
4. Босоо эгэх хариуцлагын тогтолцоо байгаа эсэх (*Vertical accountability*)
5. Хэвтээ эгэх хариуцлагын тогтолцоо байгаа эсэх (*Horizontal accountability*)
6. Иргэний улс төрийн эрх хангагдсан эсэх (*Freedom*)
7. Иргэний тэгш эрх хангагдсан эсэх (*Equality*)
8. Хариу үйлдэлтэй эсэх (*Responsiveness*)

Эдгээр үзүүлэлтүүдээр төрийн байгуулал дахь засаглалын үйл ажиллагааны чанарыг тодорхойлохдоо нэг талаас үр дүн, нөгөө талаас төрийн бодлого, бодлогын хэрэгжилт буюу процессыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааны чанарыг өргөн хүрээнд ялгаатай байдлаар гаргах боломжийг олгодог давуу талтай байна. Энэ утгаараа ардчилсан засаглалыг хэрхэн тодорхойлсон, ямар хамрах хүрээнд асуудлыг дэвшүүлсэн болон юуг судлахыг зорьж байгаа зэргээс шалтгаалан засаглалын онолын үзэл баримтлалын хүрээ гардаг.

Мөн ардчилсан засаглалын хэв шинжийг “Нийгмийн ардчиллын хүрээнд тодорхойлсон” О’Доннеллын дэвшүүлсэн онолын үзэл баримтлалыг нарийвчлан авч үзвэл нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзах, нийгмийн чиг баримжаат төрт улсын (*Sozialstaat*) зохион байгуулалтыг задлан шинжлэх шаардлагатай тулгарч байна (O’Donnel. G, Cullell, J.V, Iazzetta, O.M, 2004). Учир нь О’Доннелл НҮБ-аас гаргасан Хүний хөгжлийн индексийг (*Human Development Index/HDI*) онолын үзэл баримтлалын суурь болгож, боловсрол болон амьдралын чанар, хүний дундаж наслалт зэргийг ардчилсан засаглалын үзэл баримтлалдаа оруулсан. Түүний үзлээр ардчилсан засаглалын чанарт хоёр гол үзүүлэлтийг харгалзах ёстой бөгөөд энэ нь хүний хөгжил болон хүний эрхийн хэрэгжилтийг хангасан байх санааг дэвшүүлсэн. Энэ нь нийгмийн хөгжил өөрөө тодорхой эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн шалгуурыг хангасан байх шаардлагатай болохыг илтгэнэ. Зарим судлаачид ардчилсан засаглалын энэ төрлийн тодорхойлолтыг үгүйсгэх бөгөөд үүнийг засаглалын тухай ойлголтод үйл ажиллагааны

гарц талаас нь харсан материаллаг үзэл баримтлал гэж шүүмжилдэг. Тийм ч учраас ардчилсан засаглалыг тодорхой бодлогын агуулга (*Policy*) талаас нь тодорхойлох боломжгүй, харин ардчилсан засаглалыг олон төрлийн бодлого, янз бүрийн шийдлийг хэлэлцэх улс төрийн үйл явц гэж ойлгох ёстой хэмээн үзсэн байна (Lauth H.-J. , 2004).

Харин ардчилсан засаглалын тодорхойлолтын хамрах хүрээний дунд түвшний ойлголт нь засаглах үйл ажиллагаанд ялгамжтай байдлаар дүн шинжилгээ хийх боломжийг олгодог учир цаашид ирээдүйтэй гэж судлаач Марк Бюлманн тэмдэглэсэн (Buhlmann, 2012). Энэхүү үзэл баримтлал нь ардчилсан засаглалын тухай ойлголтыг нарийвчлан хэмжээсжүүлж, тодорхойлолт болон түүний хамрах хүрээний судлагдахуунд операционализаци хийснээр хэрэгжилтийг үнэлэх матрицыг ашигладаг давуу талтай болсон. Ардчилсан засаглалын онолын үзэл баримтлалыг хэлэлцүүлж, задлан шинжилж дүгнэснээр иргэний улс төрийн эрх чөлөө хангагдсан эсэх, нийгмийн харилцаанд иргэний тэгш эрх баталгаажсан эсэх, улс төрийн шийдвэр иргэдийн оролцоотой, бодит хяналттай байгаа эсэхийг хэмжих боломж бүрдэж, хэмжигдэхүүний үр дүнд тулгуурлан засаглалын үйл ажиллагаанд дүгнэлт хийснээр үйл ажиллагааны чанарыг тодорхойлж байна.

Эдгээр хэмжигдэхүүн нь хөндлөнгөөс харилцан хамаарал бүхий таван түвшинд ялгаатай байдлаар илэрхийлэгддэг (Campbell, D.F.J, Barth, T.D., 2009). Үүнд:

1. Улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаа
2. Иргэн-төрийн хоорондын хараат бус зуучлал буюу иргэний нийгмийн төлөвшил
3. Нийгэм дэх олон нийтийн эрх чөлөөт харилцаа
4. Хууль эрх зүйн хүрээнд баталгаажсан байдал
5. Дээрх үзүүлэлтүүдийн хэрэгжилт багтана.

Өөрөөр хэлбэл, иргэд нь засгийн бүх эрхийг хэрэгжүүлэх чадамжтай ба улс төрийн чөлөөт сонгуулиар парламентын гишүүдийг хараат бусаар сонгож чаддаг эсэх, өөрсдийн итгэл үнэмшлээр сонгож байгуулсан парламент болон засгийн газрын шийдвэрт шууд болон төлөөллийн механизмаар дамжуулан оролцдог эсэх, мөн парламентын гишүүдэд хариуцлага тооцох, улс төрийн шийдвэрт хөндлөнгийн хяналт тавих боломжтой эсэх тухай засаглалын ойлголт юм.

Ардчилсан засаглалын хэв шинжийг тодорхойлох үзүүлэлт, түүний хэрэгжилтийн үнэлгээний аргачлалыг нарийвчлан боловсруулсан

ардчилсан засаглалын матрицыг (Lauth Н.-J. и., 2019) авч үзвэл:

- Нэгдүгээрт, иргэдийн сонгох, сонгогдох эрхийн хэрэгжилтийн чанарын (*Quality*) тухай буюу иргэдийн улс төрийн боловсролын тухай асуудал,
- Хоёрдугаарт, иргэний нийгмийн төлөвшил буюу улс төрийн нам, сонирхлын бүлэг, төрийн бус байгууллага (ТББ)-ын нийгэмд эзлэх байр суурь болон тэдгээрийн үйл ажиллагааны төлөвшил болон чанарын (*Intermediary Mediation-дундын зуучлал*) тухай асуудал,
- Гуравдугаарт, олон нийтийн мэдээлэл олон эх сурвалжтай байх тухай бөгөөд хэвлэл мэдээллийн бие даасан, хараат бус байдал хангагдсан эсэх, засаглалын үйл ажиллагааны ил тод байдал нийгмийн мэдээллийн харилцаанд бүрдсэн буюу иргэд өөрсдийн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаанд оролцох эрх, түүний хэрэгжилтийн чанарын (*Quality of the media*) тухай асуудал,
- Дөрөвдүгээрт, төрийн байгуулал дахь эрх мэдлийн хуваарилалт, төрийн чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилт, шүүх засаглалын хараат бус шийдвэр гаргах чадамж буюу эрх зүйт төрийн үйл ажиллагааны чанар (*Quality of the rule of law*)-ын тухай асуудал,
- Тавдугаарт, төрийн байгуулал дахь Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн институци, Засгийн газрын үйл ажиллагааны чанарын (*Quality of effective governance and horizontal accountability*) тухай асуудлыг тодорхойлж байна.

Монгол Улсын хувьд ардчиллын төлөв байдлыг тодорхойлох болон засаглалын бүтэц зохион байгуулалт, хэв шинжийг олон улсын байгууллагын дэмжлэгтэй, тухайлбал IDEA, Дэлхийн банк, НҮБХХ зэрэг байгууллагатай хамтран судалсан. 2003 онд Монгол Улсад Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурлыг амжилттай зохион байгуулж, хурлын шийдвэрийн дагуу “Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт” боловсруулах ажлыг эхлүүлсэн байдаг (эмхэтгэл, 2003). Мөн 2005-2006, 2007-2008, 2009-2010 онуудад ШУА-ийн ФСЭХ-ээс “Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт” сэдэвт судалгааг гурван удаа дараалан үндэсний хэмжээнд зохион байгуулсан (ШУА-ийн Философи, 2010). Эдгээр судалгааны ажлууд нь Фрийдом хаус, НҮБХХ, Амнести интернешнл, Дэлхийн банк, IDEA зэрэг байгууллагуудын аргачлалыг харьцуулан судалж, эдгээрээс IDEA (Ардчилал болон сонгуульд туслах олон улсын хүрээлэн)-ийн аргачлалын шалгуур үзүүлэлтийг үндэс болгожээ.

ФСЭХ-ийн эдгээр судалгааны онцлог нь ардчилсан засаглалын хамрах хүрээг ерөнхийлөн авч судлахын зэрэгцээ Монгол Улс дахь ардчиллын үйл явцыг улс төрийн систем талаас нь анхаарал хандуулж, улс төрийн системийн шилжилтийн үйл явцыг судалжээ. Тухайлбал, энэ хүрээнд судлаач О. Хатанболд 2017 онд “Ардчилал судлал: онол, арга зүй сэдэвт бүтээл, 2019 онд “Монгол дахь ардчиллын мөн чанар, төлөвших үйл явцын онцлог зэрэг бүтээлийг хэвлүүлсэн байна. Эдгээр судалгааны бүтээлд ардчиллын талаарх Монгол хүний уламжлалт ойлголт, өнөөгийн ардчилсан нийгмийн төсөөлөл, парламентын засаглалын хэрэгжилт болон улс төрийн шилжилтийн хүрээнд тулгамдаж буй сорилт, боломжуудын тухай дэлгэрэнгүй авч үзсэн байна [Чулуунбаатар, 2013, хууд. 248].

Дээрх судалгааны хамрах хүрээ нь нэгдүгээрт, төлөөллийн ба шууд ардчиллын түүх, парламентын ардчиллыг төлөвшүүлэх тухай; хоёрдугаарт, ардчилал дахь улс төрийн оролцооны үзэл баримтлал, иргэний нийгмийн үүрэг болон оролцоо, түүнийг Монголд нутагшуулах тухай; гуравдугаарт, нутгийн өөрийн удирдлагын тогтолцооны өнөөгийн төлөв байдал, түүний хөгжлийн тухай; дөрөвдүгээрт, төлөөллийн ардчиллын хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийг дэлгэрэнгүй тоймлон судалсан байдаг.

Ардчилсан засаглалын олон янзын тодорхойлолт, түүний ялгаатай байдал болон хамрах хүрээг харгалзан энэхүү судалгаанд зөвхөн иргэдийн “дуу хоолой ба эгэх хариуцлага” үзүүлэлтийн төлөв байдлыг тодорхойлохын тулд Фрийдом Хаусын үзэл баримтлалд тулгуурлан улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт болон иргэний эрхийн хэрэгжилт гэсэн хоёр үзүүлэлтийг ардчилсан засаглалын тодорхойлолтын хамгийн бага хамрах хүрээнд судлахаар хязгаарлалт хийн ашиглана. Энэхүү судалгааны хязгаарлалт нь Монгол Улсын хувьд өмнө хийгдсэн ардчиллын тухай бусад судалгааны хүрээнд орхигдуулсан сул орон зай бөгөөд үүнийг тодруулснаар иргэдийн дуу хоолой, эгэх хариуцлагыг нөхцөлд үнэлгээ өгөх боломж бүрдэх юм.

2.2 Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагын тухай ойлголт, хэрэгжилт

“Хүмүүний сүр сүлдтэй¹³ орших эрх” (*human dignity*)-ийн халдашгүй байдлыг хангах нь засаглалын үндсэн үүрэг бөгөөд уг ойлголт нь тухайн улсын бүрэн эрхт байдлыг (*sovereignty*) төлөөлөн гүйцэтгэж байгаа бүхий л төрийн байгуулал дахь үйл ажиллагаа (*Хууль тогтоох засаглал, Гүйцэтгэх*

¹³ Я.Долгоржав. Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн зарим нэр томъёо, түүний агуулгыг орчин цагт нийцүүлэх шаардлага, 2017.

засаглал, Шүүх засаглал) нь хүний эрхийг хүндэтгэж, төр-иргэн гэсэн нийгмийн харилцаанд хүний жам ёсны эрхийг дээдлэх тухай онолын үзэл баримтлал юм. Энэ ч утгаараа 1992 оны Үндсэн хуулийн 16-р заалтад “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” хэмээгээд хүний эрхийн 18 эрх чөлөөг хуульчилсан. Гэсэн ч тэдгээрийн хэрэгжилтийн чанарыг үнэлсэн судалгааны бүтээл өнөөдөр ховор байна. Түүнчлэн, хүний эрхийн талаарх зарим нэр томьёо нь орчуулгын хувьд судлаачдын хүрээнд маргаантай хэвээр байгаа нь судалгааны хязгаарлалт болж байна.

Ардчилсан засаглал дахь иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага үзүүлэлт нь тухайн улсын төрийн байгууллын онцлог шинжтэй шууд холбоотойгоос гадна үүнд улс төрийн тогтолцоо чухал үүрэгтэй. Учир нь засгийн газрын үйл ажиллагааны чанар, түүний үр нөлөө нь олонхын ардчилалтай байна уу?, эсхүл зөвшилцлийн ардчилалтай байна уу? гэдгээс хамаарч ялгаатайгаар тодорхойлогдох ба улс төрийн соёл, улс төрийн намын төлөвшил, иргэний нийгмийн хөгжлийн түвшин болон иргэдийн улс төрийн боловсролын чанарын нөлөөлөл харилцан адилгүй байдаг. Үүнээс шалтгаалан иргэдийн дуу хоолой болон оролцоо ялгаатай байдаг байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Засаглалын хэлбэр, түүний ангилал

Авторитар	Хагас авторитар	Гажуудсан ардчилалтай	Ардчилсан
0-0.25	0.25-0.50	0.50-0.75	0.75-1.0


Эх сурвалж: Merkel. W, Puhle. H.J, Croissant. A (2003). Defekte Demokratie

В.Меркел, Х.Ю. Пууле, А.Кройсанта нарын Defekte Demokratie буюу “Гажуудалтай ардчилал” ном нь ардчиллын онол, түүний гажуудал болон дутагдалтай талуудыг онолын болон эмпирик судалгааны үндсэн дээр тайлбарласан чухал бүтээл юм. Тэд засаглалын хэлбэрийг авторитараас ардчилсан хүртэл дөрвөн түвшинд ангилж 0-1.0 хүртэл оноо өгсөн байна.

Монгол Улсын хувьд 1996 оноос хойш Дэлхийн Банкны засаглалын индекс тодорхойлох судалгаанд тасралтгүй хамрагдаж ирсэн түүхтэй бөгөөд засаглалын хэв шинж, чанарын үзүүлэлт нь 2022 онд хамгийн сүүлийн судалгааны дүнгээр “гажуудалтай ардчилал” ангилалд байна. Тухайлбал, либерал ардчиллын индексээр Монгол Улс 2015 онд 0.54 оноо авч байсан ч улам муудсаар 2022 онд 0.43 онооны түвшинд хүрсэн. Энэ нь хэдийгээр 171 орны дундаж болох 0.389 онооноос өндөр оноо боловч 2015-2020 оны хоорондох суурь түвшинтэй харьцуулан үзвэл дордсон үзүүлэлт юм.

Монгол Улсын хувьд 1999 онд либерал ардчиллын түвшин хамгийн өндөр цэгтээ буюу 0.615 оноонд хүрч байжээ. Харин 2022 оны байдлаар Дани (0.889), Швед (0.87), Норвег (0.857) зэрэг Скандинавын орнууд дэлхийн 171 улсыг уг индексээр тэргүүлж байна.


Зураг 2. Либерал ардчиллын индекс, 2015-2022 оноор



Эх сурвалж: Global Economy (2022). Mongolia: Liberal democracy index¹⁴

Монгол Улсын хувьд ардчилал дахь иргэдийн оролцооны индексийг харьцуулан үзэхэд авах ёстой оноо мөн л буурсаар байна. Энэ нь иргэдийн улс төрийн оролцоо нэг талдаа улам бүр муудаж байгааг илэрхийлэхийн зэрэгцээ нөгөө талдаа иргэдийн оролцоогүй, иргэдийн хяналтгүй засаглах боломж улам бүр нэмэгдэж байгааг илтгэнэ. 1997 онд уг үзүүлэлт хамгийн өндөр түвшиндээ буюу 0.423 оноо авч байсан. Харин иргэдийн оролцоогоор дэлхийд Швейцар улс тэргүүлж байгаа бөгөөд уг индекс 2022 оны байдлаар 0.80 оноотой байна.

Зураг 3. Ардчилал дахь иргэдийн оролцооны индекс, 2015-2022 оноор




Эх сурвалж: Global Economy (2022). Mongolia: Participatory democracy index¹⁵

¹⁴ https://www.theglobaleconomy.com/Mongolia/liberal_democracy_index/2014.12.12

¹⁵ https://www.theglobaleconomy.com/Mongolia/participatory_democracy_index/2024.12.12

Ардчилал дахь тэгш эрхийн индекс нь нийгмийн бүх бүлгүүд улс төрийн эрх, иргэний эрх чөлөөгөө бүрэн эдлэх, засгийн газрын үйл ажиллагаанд шууд болон төлөөллийн байгууллагаар уламжлан оролцох тэгш боломжоор хангагдсан байх агуулгыг илэрхийлдэг. Энэ нь иргэд улс төрийн шийдвэрт өөрсдийн дуу хоолойгоо хүргэх, тодорхой нийгмийн асуудлаар эгэх хариуцлага нэхэмжлэх тэгш эрхээр хангагдсан эсэх асуудал бөгөөд Монгол Улсын хувьд уг индексээр 0.38 оноо авсан байгаа нь 171 улсаас 73-р байранд эрэмбэлэгдэж байна.

Зураг 4. Ардчилал дахь тэгш эрхийн индекс, 2015-2022 оноор



Эх сурвалж: *Global Economy (2022). Mongolia: Egalitarian democracy index*¹⁶

Дээрх олон улсын үзүүлэлтүүд нь Монгол Улсыг ардчилсан засаглалын шилжилтийн үеийг даван туулж байгаа улс орнуудын нэг гэж тодорхойлдог. Тийм ч учраас урт хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтөөр парламентын ардчиллыг улам бэхжүүлэх зорилт дэвшүүлсэн. Энэ утгаараа УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт, хүрэх түвшинг 44, 45, 47 дугаар заалтаар, “Монгол Улсыг хөгжүүлэх 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг батлах тухай” 23 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтын 63, 64, 66 дугаар заалтаар засаглалын чанарын үнэлгээний арга зүй нь Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлтүүд байхаар тодорхойлжээ (Улсын Их Хурал, 2020).

Харин Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлт нь олон тооны судалгааны үр дүнг нэгтгэн засаглалын үзүүлэлтийг гаргадаг үнэлгээтэй тул нэг жилээр хоцорч гардаг онцлогтой. Хэдийгээр олон улсад Фрийдом хаус,

¹⁶ https://www.theglobaleconomy.com/Mongolia/egalitarian_democracy_index%20/2024.12.12

Ардчиллын индекс, Ардчиллын зэрэглэл тогтоох судалгаа зэргийг зэрэгцүүлэн хийдэг ч эдгээр судалгааны арга зүй, түүнийг хэмжих чанарын болон тоон статистик мэдээлэлд шинжилгээ хийх аргачлал нь ардчилсан засаглал бүрэн утгаараа төлөвшсөн барууны гэх тодотголтой, эдийн засгийн өндөр хөгжилтэй, ардчилал өөрөө “нийгмийн соёлын элемент” болж төлөвшсөн улс орнуудын засаглалын үйл ажиллагааны чанарыг хэмжихэд чиглэгдсэн байгааг анхаарах шаардлагатай гэж судлаачид үзсэн байдаг (Campbell, D.F.J, Barth, T.D., 2009). Монгол Улсын хувьд нийгмийн хөгжлийн түвшин сул, иргэдийн улс төрийн боловсрол муу, ардчиллын тухай ойлголт бүрэн төлөвшөөгүй, хувь хүний хөгжлийн түвшин өндөр биш, нийслэл болон орон нутгийн соёлын ялгаатай байдал зэргийг харгалзахгүй байгаа нь Дэлхийн Банкны засаглалын чанарыг тодорхойлох судалгааны үр дүнг манай нөхцөлд шууд хэрэглэх, тайлбарлах боломжийг хязгаарлаж эрдэм шинжилгээний хүрээнд дахин хэлэлцүүлэх хэрэгцээг үүсгэж байна.

Энэхүү ялгаатай байр суурь нь тухайлбал, ардчилсан засаглалын тодорхойлолт, түүний хамрах хүрээ болон Дэлхийн Банкны судалгаа, Фрийдом хаус, Ардчиллын индекс, Ардчиллын зэрэглэл тогтоох судалгааны арга зүй дээр ялгаатай илэрч байна. Тухайлбал, энэхүү судалгааны хүрээнд Дэлхийн Банкны 1996 оноос хойших судалгааны суурь дата мэдээллийг ашиглахаар төлөвлөсөн хэдий ч Дэлхий Банкны зүгээс судалгааны өгөгдлийг хуваалцах боломжгүйг 2024 оны 6 дугаар сард мэдэгдсэн. Мөн Ардчилсан засаглалын шилжилтийг тодорхойлох судалгаа хийдэг ХБНГУ-ын Бертелстманы сангаас засаглалын индексийг тооцсон, улс төрийн шилжилтийн үнэлгээ хийсэн судалгааны суурь дата мэдээллийг авах хүсэлтээ илэрхийлж 2024 оны 7 дугаар сард Берлин хотын Бертелстманы салбарт хандсан боловч тухайн жилийн судалгаа мэдээ, мэдээлэл, судалгааны анхдагч өгөгдөл нь судалгаа хийсэн судлаачдын оюуны өмч болохыг онцолж, мөн хуваалцах, судалгааны зорилгоор ашиглуулах боломжгүйг мэдэгдсэн.

Эдгээр нөхцөл байдлаас улбаалан иргэдийн дуу хоолойг тодорхойлох арга зүйг Фрийдом Хаусын улс төрийн эрх, иргэний эрхийн хэрэгжилтийн нээлттэй асуултуудтай уялдуулан Монгол хувилбарт хөрвүүлж, судалгааны тоон мэдээллийг цуглуулах асуулгын анкетыг боловсруулж, улмаар экспертийн ярилцлагын удирдамж боловсруулан судалгаанд ашигласан.

2.3 Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлт, онолын арга зүй

Кауфманн, Край, Лобатон болон Маструzzi¹⁷ нарын судлаачид 1999 онд дэлхийн засаглалын үзүүлэлтүүдийг нэгтгэж томоохон судалгааны санг бүрдүүлэх ажлыг эхлүүлсэн түүхтэй. Тэдний судалгааны эх сурвалж нь Дэлхийн Банкны хүрээлэн болон Дэлхийн Банкны судалгааны хэлтэст хэрэгжиж байсан төсөл дээр суурилдаг (The World Bank, 2007).

Засаглалын үзүүлэлтийн судалгаа нь 1996-2002 оны хооронд хоёр жил тутамд, харин 2002 оноос эхлэн жил тутам шинэчлэгдэх болсон бөгөөд жил бүрийн есдүгээр сард өмнөх жилийн үр дүнг нэгтгэн гаргаж байна. Хамгийн сүүлийн тайлан болох 2022 оны нэгтгэл дээр олон улсын нэр хүнд бүхий нийт 34 судалгааны эх сурвалжийн үр дүнг ашигласан байдаг. Дэлхийн Банкны засаглалын зургаан үзүүлэлт нь дараах агуулгыг багтаадаг. Үүнд:

1. Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага (*Voice and Accountability/Mitspracherecht und Verantwortlichkeit*) – Тухайн улс орны иргэд төр засгаа сонгох үйл явцад оролцож чадаж байгаа эсэх, түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, чөлөөт хэвлэл мэдээлэлтэй байх эрх хэрэгждэг эсэх, төр иргэний санал хүсэлтэд хариу өгдөг эсэхээр тодорхойлогдоно.
2. Улс төрийн тогтвортой байдал, хүчирхийлэл/терроризмгүй байх (*Political Stability and Absence of Violence/politische Stabilität und Abwesenheit von Gewalt*) Улс төрийн тогтворгүй байдал эсхүл улс төрийн сэдэлтэй хүчирхийлэл, терроризм гарах магадлал, нөхцөл бий эсэх,
3. Засгийн газрын үр дүн (*Government Effectiveness/Leistungsfähigkeit der Regierung*) – Төрийн үйлчилгээ, төрийн албаны чанар, түүний улс төрийн нөлөөллөөс ангид эсэх, бодлого боловсруулалт, хэрэгжилтийн чанар, засгийн газрын бодлогод тавих хяналт, хариуцлагатай байх нөхцөл бүрдсэн эсэх,
4. Зохицуулалтын чанар (*Regulatory¹⁸ Quality/Staatliche Ordnungspolitik*) – Засгийн газар нь зөв бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чадвартай, хувийн салбарын хөгжлийг дэмжих, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж байгаа эсэх,

¹⁷ Кауфманн, Край, Лобатон болон Маструzzi нарын (Daniel Kaufmann, Aart Kraay, Pablo Zoido-Lobaton and Massimo Mastruzzi) боловсруулсан энэхүү үзүүлэлтийг тухайн үед “KK”, “KKZ”, “KKM” гэж нэрлэдэг байжээ.

¹⁸ Үндсэн агуулга нь тохируулгын чанар юм. Гэхдээ монгол хэлэнд буулгахдаа зохицуулалтын чанар гэж ташаа буулгасан нь албан баримт бичигт тусгагдсан тул тогтсон нэр томъёо болгон энэхүү судалгааны тайланд тусгав.

5. Эрх зүйт төрийн үйл ажиллагаа (*Rule of Law/Rechtsstaatlichkeit*) – Нийгмийн дүрэм журмыг сахих итгэл үнэмшлийн хэр хэмжээ, гэрээний хэрэгжилт, өмчлөх эрх, цагдаа болон шүүхийн чанар, гэмт хэрэг, хүчирхийлэл гарах магадлал байгаа эсэх,

Авлигын хяналт (*Control of Corruption/Korruptionskontrolle*) – Хувийн зорилгоор төрийн эрх мэдлийг ашиглаж буй байдал, жижиг болон том хэмжээний авлигын хэлбэрүүд, элитүүд болон хувийн ашиг сонирхол төрийг “эзэлсэн” эсэх зэрэг үзүүлэлтүүд юм (World Bank, 2021).

Эдгээр ялгаатай тодорхойлолтууд дундаас Кауфманн, Край, Лобатон болон Маструцци нарын судлаачид өөрсдийн хувилбарыг дэвшүүлсэн нь судалгаанд түгээмэл ашиглагдаж байна. Учир нь тэд ардчилсан засаглалыг:

- Нэгдүгээрт, төрийн эрх барих байгууллагыг сонгох, хянах, солих үйл явц гэдэг утгаар буюу Төр-Иргэн хоорондын улс төрийн харилцаагаар авч үздэг.
- Хоёрдугаарт, Засгийн газар нь оновчтой бодлого боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлэх чадавхтай эсэх буюу төрийн байгуулал дахь нэгж институци хоорондын эгэх хариуцлагыг авч үздэг.

Гуравдугаарт, иргэдийн хүндлэл болон төрийн байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн хооронд эдийн засаг болон нийгмийн харилцааг зохицуулдаг гэж тодорхойлсон байна (Kaufmann. D, Kraay. A, Mastruzzi. M, 2010).

Өөрөөр хэлбэл, иргэний улс төрийн эрх, иргэний эрхийн хэрэгжилтийг үнэлэхдээ Фрийдом Хаусын суурь үзүүлэлтийг чухалчилдаг байна. Иргэдийн дуу хоолой гэсэн үзүүлэлт нь Төр-Иргэн хоорондын харилцаагаар тодорхойлогдох боломжтой. Энэ нь иргэний улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилтийн үнэлгээгээр тодорхойлогдоно.

Харин эгэх хариуцлага нь төрийн байгуулал дахь институци хоорондын харилцаанд болон төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн зүгээс итгэх итгэл үнэмшил болон бусад нийгмийн оролцогч талуудын харилцаагаар тодорхойлогдох боломжтой. Тухайлбал, сайн засаглалын гурван шинж бол иргэдийн оролцоо, эгэх хариуцлага, ил тод байдал хэмээн Олон улсын сэтгүүлчдийн холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга асан Айдан Уайт хэлсэн байдаг (Наранжаргал, 2018). Өөрөөр хэлбэл, иргэдийн оролцоо болон эгэх хариуцлага хоёр тусдаа үзүүлэлт хэдий ч харилцан хамааралтай оршдог байна.

Бүхэлдээ Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлтүүд нь парламент дахь төлөөллийн ардчиллын чанарыг дээшлүүлэх, засгийн газрын үйл ажиллагааны явцыг иргэдэд илүү ойртуулахад чиглэгдэж байдаг. Энэ утгаараа засаглалын үзүүлэлтүүд нь төлөөллийн ардчиллын онолын үзэл баримтлал дээр суурилж, ардчиллын чанарын үзүүлэлтийг тайлбарлахад чиглэдэг (Schmidt, 2013). Засаглалын үзүүлэлт тус бүр нь Төр-Иргэн-Аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг нийгмийн харилцаанд дэмжих зорилго агуулдаг онцлогтой. Учир нь нийгмийн зохицуулалт бүхий улс төрийн шийдвэрийг төрийн байгууллын нэрийн өмнөөс хэрэгжүүлэгч улс төрийн хүчин (*political party*) дангаар гаргах бус, харин нийгмийн харилцаанд оролцогч талуудын хамтын ажиллагаа, оролцоотой шийдвэрлэх ёстой гэсэн утга санааг илэрхийлдэг.

Энэ ч утгаараа иргэний улс төрийн эрхийн ойлголт, түүний хэрэгжилтийн үнэлгээ чухал үүрэгтэй бөгөөд улс төрийн эрх нь иргэн бүрийн улс төрийн сонгуулийн оролцоо, иргэний нийгмийн төлөвшлөөр илэрдэг байна. Иймээс 1980 оны сүүлээр Дэлхийн Банк олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад гаргасан олон алдааг дахин давтахгүй байх, хөгжиж буй улс орнуудын нийгмийн харилцаанд засгийн газрын үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд “Сайн засаглал”-ын онолыг (*Good Governance*) дэвшүүлсэн байдаг (Benz, 2001).

Хөгжиж буй зарим улс орнуудад олон улсын хэрэгжүүлсэн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд илэрсэн гашуун туршлагаас улбаалан улс төрөөс хараат шүүх засаглал¹⁹, парламентаас батлагдсан хуулийг хэрэгжүүлэх сонирхолгүй Засгийн газар²⁰, Олон улсын хөгжлийн хөтөлбөрийн зорилтод чиглэсэн мөнгө санхүүгийн дэмжлэгийг илтээр хууль бусаар завших авлига, хээл хахууль зэрэг алдааг засах нь НҮБ-ын зорилт болж хувирсан. “*Governance*” буюу төрийн байгуулал дахь удирдлагын тогтолцоог сайжруулах замаар эдгээр асуудлыг шийдвэрлэх боломжтой хэмээн Дэлхийн Банкны зарим судлаачид үзэж, улмаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны үзүүлэлт тус бүрээр “*Улс төрийн болон төрийн захиргааны*” орчинг сайжруулах асуудлыг дэвшүүлсэн байдаг (Hennig Nuißl, 2009).

Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлт нь тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч улс орны нөхцөл байдлаас улбаалан хөгжүүлэх шаардлагатай салбарт тохирсон байх ёстой гэсэн шаардлагыг зарим судлаачид тавьдаг. Тухайлбал, Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага

¹⁹ Korrupte Justiz

²⁰ Korrupte Executive und Legislative

(Voice and Accountability) үзүүлэлтийг хэмжихдээ Дэлхийн Банк Олон улсын 13 судалгааны үзүүлэлтийг суурь болгодог ч, дараах таван судалгааны байгууллагын үзүүлэлтийг голлон авч үздэг. Үүнд:

1. Эдийн засгийн судалгааны нэгж (Economist Intelligence Unit (EIU)
2. Фрийдом хаусын ардчиллын индекс (Freedom House (FRH)
3. Голлапын дэлхийн санал асуулга (Gallup World Poll (GWP)
4. Хил хязгааргүй сурвалжлагчдын хэвлэлийн эрх чөлөөний индекс (Reporters Without Borders Press Freedom Index (RSF)
5. Ардчиллын олон янз байдал төсөл (Varieties of Democracy Project (VDM) багтана.

Эдгээр судалгаанаас олон улсад хамгийн нэр хүнд өндөртэй, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн судалгаануудын нэг бол Фрийдом Хаусын ардчиллын индекс юм.

Судалгааны арга зүй нь хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948 оны *human dignity-хүмүүний сүр сүлдтэй орших эрх*)-ын үзэл баримтлал дээр тулгуурлах бөгөөд дэлхийн улс орнуудын газар зүйн байршил, угсаатны бүлэг, шашин шүтлэг, эдийн засгийн хөгжлөөс үл хамааран бүх улс оронд нэг стандартыг мөрдөж судалгааг хийдгээрээ онцлогтой. Тухайлбал, Каймпбэлл, Баерт нар “Ардчилал болон ардчилсан засаглалын хэрэгжилтийн чанарыг хэрхэн хэмжих вэ?” хэмээх нийтлэлдээ Фрийдом хаусын индекс, Ардчиллын индекс болон Ардчиллын зэрэглэл тогтоох судалгааны үзүүлэлтүүд нь ялгаатай байгааг онцолж, хүмүүсийн амьдралын чанар, боловсрол, нийгмийн хөгжлийн түвшин, эдийн засгийн үзүүлэлтүүд ардчиллын чанарт шууд нөлөөлж байна гэж дүгнэжээ (Campbell, D.F.J, Barth, T.D., 2009).

Ардчилсан засаглалын амин сүнс нь “засаглалын бүх эрх ард түмний мэдэлд байх” тухай ойлголт²¹ буюу тухайн улсын төрийн байгуулал нь иргэдийн халдашгүй байх эрхийг хүмүүний өөрийнх нь сүр сүлдтэй орших жам ёсны эрхийн хамтаар хамгаалах, түүнийг нийгмийн харилцаанд хүндэтгэх үүрэг хүлээдэг. Энэ ч утгаараа хүний эрхийг хамгаалах, хүндэтгэх чиглэлд Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх засаглалын үйл ажиллагаа Үндсэн хуулиар үүрэгжсэн байх тухай ойлголт юм. Үүний баталгаа нь хувь хүний улс төрийн эрх болон иргэний эрхүүд байдаг.

- Хүний улс төрийн эрхийн ойлголт нь өөрөө сонгуулийн үйл явц – хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын сонгуулиудтай, сонгуулийн

²¹ Үндсэн Хуулийн 3-р зүйлийн 1-р заалт.

орчинтой, үүнд улс төрийн олон ургалч үзэл баримтлал, иргэдийн оролцоо, улс төрийн намын төлөвшил, улс төрийн намуудын өрсөлдөх чадамж, цөөнх, олонхыг сонгох эрх, засгийн газрын үйл ажиллагаа, мөн төрийн байгууллага дахь авлига, хүнд суртал, хүний нөөц болон ил тод байдал, сонгогдсон албан тушаалтнууд үүргээ гүйцэтгэж чадаж байгаа эсэх зэргийг авч үздэг.

- Иргэний эрх чөлөө гэх агуулга нь хүн өөрийн сүр сүлдтэй орших эрхийн үндэс болох бөгөөд үүнд, хүний жам ёсны эрхийн дагуу өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх, эрх чөлөөт байдлаар хэвлэл мэдээлэл, шашин, академик эрх чөлөө, чөлөөт хэлэлцүүлэг өрнүүлэх эрхтэй байхыг ойлгоно.
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний агуулга нь нийгмийн харилцааны суурь үзүүлэлт болох бөгөөд иргэд өөрсдийн хүсэл сонирхлоор эвлэлдэн нэгдэх, иргэний нийгмийн бүлэг байгуулах, үйлдвэрчний эвлэлд гишүүн болох гэх зэргээр хамгаалах эрхүүд багтана.
- Эрх зүйт төрийн үйл ажиллагаа гэх агуулга нь төрийн байгуулал дахь төрийн институци хоорондын харилцаанд эрх мэдлийн хяналт-тэнцвэр хангагдсан байх тухай асуудал бөгөөд институцүүд нь бие даасан, улс төрийн намаас хараат бус үйл ажиллагаа эрхлэх чадамжтай байх ойлголт. Тухайлбал, шүүх, прокурорын байгууллага хараат бус байх нь гэмт хэрэг, хэв журмын зөрчил, цөөнхийн эрхийг хамгаалж чаддаг эсэх тухай асуудлууд юм. Хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн агуулга нь хувийн орон зай, хувь хүний эрх чөлөөт байдлын баталгаа болж өгөх бөгөөд чөлөөтэй оршин суух, хувийн аж ахуй эрхлэх, хүйсийн тэгш эрх, гэр бүлийн эрх зэргийг үүнд багтаан ойлгодог.

Эдгээр эрхийг Монгол Улс 1992 оны Үндсэн хуулийн 16-р зүйлд хуульчилж өгсөн. Хүн жам ёсныхоо болон нийгмийн гэрээний эдгээр эрхийг эдлэх нь өөрөө улс төрийн эрхийн тухай ойлголт. Нийгмийн харилцаа харин түүнийг хэрэгжүүлэх чадварыг иргэн бүрээс шаардах ба иргэд эрхээ бүрэн ухамсарлан хэрэгжүүлж чадахгүй нөхцөлд улс төрийн эрхийн хэрэгжилт сул байхаас гадна засаглалын хэв шинж, ардчиллын чанарын үзүүлэлтүүд сулардаг байна.

Хэдийгээр Дэлхийн Банкны судалгааны үр дүн нь эрдэм шинжилгээний байгууллага, тинк танк (оюуны төв), хүний эрхийн байгууллагуудын зөвлөх, шинжээч, экспертүүдийн багийн өгсөн онооны нэгдсэн үнэлгээ боловч энэхүү судалгаа нь дунджаар 60 орчим шинжээч, 30 орчим зөвлөхийн тусламжтай хийгддэг учир субъектив шинжтэй хэмээн

шүүмжлэлд өртдөг. Тухайлбал, 2021 оны судалгаанд 100 гаруй шинжээч, 30 орчим зөвлөх оролцсон байна. Улс орны үнэлгээг өгөхдөө тухайн улсын шинжээч нь үр дүнгийн төслийг бэлтгэх бөгөөд эх сурвалж болгон өдөр тутмын хэвлэл, сонингийн мэдээ, эрдэм шинжилгээний хурал, судалгааны тайлангийн үр дүнгийн шинжилгээ, ТББ-ын илтгэл, хувь мэргэжилтнүүдийн холбоог ашигладаг онцлогтой. Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцаанд оролцогч талуудын тоон болон чанарын мэдээллийг ашиглан боловсруулдаг байна.

Улс орны үнэлгээг өгөхдөө заасан хугацааны дотор хязгаарлах бөгөөд тухайн шинжээчийн бэлтгэсэн үнэлгээний төслийг жил бүрийн үнэлгээг хянах уулзалтын хүрээнд Фрийдом хаусын өөрийн судлаачид болон мэргэжлийн экспертүүд хянаж хэлэлцсэний үндсэн дээр эцсийн тайланд оруулдаг (Freedom House, 2023). Монгол Улсын хувьд 2023 оны байдлаар 84 оноо авсан буюу эрх чөлөөтэй ангилалд багтсан. Эдгээр үзүүлэлтүүдээс эрх чөлөөний түвшин 1.5/7, улс төрийн эрх 1/7, иргэний эрхийн үзүүлэлт 2/7 оноо авчээ (Freedom house, 2023).

Улс төрийн эрхийн шалгуур үзүүлэлтийг задлан авч үзвэл **40 оноо авахаас 36** оноо авсан бөгөөд үүнээс:

- Сонгуулийн үйл явц 11/12
- Улс төрийн олон ургалч байдал, оролцоо 16/16
- Засгийн газрын үйл ажиллагаа 9/12

Иргэний эрх чөлөө шалгуур үзүүлэлтийг задлан авч үзвэл **48/60** оноо авсан бөгөөд үүнээс:

- Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө 14/16
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө 11/12
- Эрх зүйт төр 11/16
- Хувь хүний халдашгүй дархан байдал болон хувийн эрх чөлөө 12/16 оноо тус тус авсан байна.

Засгийн газрын үр дүн (Government Effectiveness) үзүүлэлтийг хэмжихэд олон улсын 11 судалгааны үр дүнг суурь үзүүлэлт болгон ашигладаг. Эдгээр судалгаануудын заримыг дурдвал:

1. Азийн хөгжлийн банкны улс орны төрийн бодлого болон институцийн үнэлгээ (Asian Development Bank Country Policy and Institutional Assessments (ADB))

2. Бертелсманы шилжилтийн индекс Bertelsmann Transformation Index (BTI)
3. Глобал инсайтын бизнесийн нөхцөл ба эрсдэлийн үзүүлэлтүүд (Global Insight Business Condition and Risk Indicators (WMO))
4. Олон улсын хөдөө аж ахуйн хөгжлийн сангийн хөдөө, орон нутгийн салбарын гүйцэтгэлийн үнэлгээ (IFAD Rural Sector Performance Assessments (IFD))
5. Улс төрийн эрсдэлийн үйлчилгээ (Political Risk Services (PRS))
6. Дэлхийн Банкны улс орны төрийн бодлого болон институцийн үнэлгээ (World Bank Country Policy and Institutional Assessments (PIA)) зэрэг орно.

Дээрх судалгаануудаас онцолж авч үзэх нэг судалгаа бол Бертелсманы шилжилтийн индекс юм. Уг судалгаа нь ардчилсан засаглал, зах зээлийн эдийн засагт шилжиж буй улс орнуудын хөгжлийн төлөв байдал болон нийгмийн шилжилт, өөрчлөлтийн үйл явцыг судлах зорилготой бөгөөд хоёр жил тутамд шинэчлэгддэг. Судалгааны арга зүйн хувьд 17 суурь шалгуур үзүүлэлт нь 52 дэд шалгуур үзүүлэлт болж задардаг.

Хүснэгт 2. Бертелсманы шилжилтийн индексийн суурь 17 шалгуур үзүүлэлт

17 шалгуур үзүүлэлт		
Улс төрийн шилжилт	Эдийн засгийн шилжилт	Засаглал
1. Төр	1. Нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшин	1. Хүндрэлийн түвшин
2. Улс төрийн оролцоо	2. Зах зээл, өрсөлдөөний бүтэц	2. Залуурдах чадавх
3. Эрх зүйт төр	3. Төгрөгийн ханш болон үнийн тогтвортой байдал	3. Нөөцийн үр ашигтай зарцуулалт
4. Ардчилсан институтүүдийн тогтвортой байдал	4. Хувийн өмч	4. Зөвшилцлийг бий болгох
5. Улс төр, нийгмийн интеграци	5. Нийгмийн хамгаалал	5. Олон улсын хамтын ажиллагаа
	6. Эдийн засгийн үзүүлэлтүүд	
	7. Тогтвортой байдал	

Эх сурвалж: BertelsmannStiftung (2022). Transformation Index.

Тус судалгаанд олон улсын 300 экспертийн судалгаа шинжилгээний үр дүнг ашиглан үнэлгээг хийдэг. Үнэлгээний багийн зүгээс бүс нутгийн болон улс орон хариуцсан экспертийг сонгож, заавар зөвлөмж өгөх замаар ажилладаг. Хамгийн сүүлийн судалгаанд 129 улсын 248 эксперт ажилласан байна. Экспертүүдийн бичсэн чанарын судалгааны тайланг хэд хэдэн үе шаттайгаар үнэлсний эцэст үр дүнг нэгтгэн гаргадаг.

Судалгаа нь шатлалтай байх бөгөөд эхний эксперт асуулт болгоноор дэлгэрэнгүй тайлан бичих, хоёр дахь эксперт тухайн тайланд дүн шинжилгээ хийснээр санал, зөвлөмж боловсруулж өгөх, дараа нь бүс нутгийн зохицуулагч нар бүсийн тайлангуудад дүн шинжилгээ хийх ба үүний дараа бүс нутгийн зохицуулагч нар, төслийн багтай хамтарч дүн шинжилгээ, хяналт хийснээр төслийн удирдах зөвлөл хянаж, үр дүнг зөвшөөрсний дараа судалгааг олон нийтэд нээлттэй танилцуулдаг.

Монгол Улсын хувьд Улс төрийн шилжилтийн үзүүлэлтээр 7.25 оноо авснаар “согогтой” буюу гажуудсан²² ардчилалтай улс гэсэн ангилалд багтаж байна. Эдийн засгийн шилжилтийн үзүүлэлтээр 5.86 оноо авч “хязгаарлагдмал”, Засаглалын үзүүлэлтээр 5.83 оноо авчээ. Өөрөөр хэлбэл, ардчилал дахь улс төрийн шилжилтийн явц алдаатай байгаа бөгөөд засаглалын суурь үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай гэсэн зөвлөмж өгсөн.

Зохицуулалтын чанар (Regulatory Quality) үзүүлэлтийг хэмжихэд олон улсын 12 судалгааг суурь болгож ашигладаг. Эдгээр судалгаанууд нь бусад шалгуур үзүүлэлтийн судалгаануудтай давхцадаг бөгөөд онцлох заримыг нь дурдвал:

1. Херитейж сангийн эдийн засгийн эрх чөлөөний индекс (Heritage Foundation Index of Economic Freedom (HER))
2. Улс төрийн эрсдэлийн үйлчилгээ (Political Risk Services (PRS))
3. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан (Global Competitiveness Report (GCS))
4. Дэлхийн шударга ёс төслийн эрх зүйт ёсны индекс (World Justice Project Rule of Law Index (WJP)) зэрэг орно.

Дээрх судалгаануудын дотроос **Дэлхийн өрсөлдөх чадварын индекс (Global Competitiveness Index) судалгааны** тайлан нь Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр хэвлэгдэн гардаг бөгөөд 2004 оноос хойш дэлхийн өрсөлдөх чадварын индекс дээр тулгуурлан улс орнуудыг эрэмбэлж эхэлсэн. Энэхүү илтгэл нь өрсөлдөх чадварыг 12 үндсэн багана болсон үзүүлэлтээр хэмждэг. Дэлхийн өрсөлдөх чадварын индексээс гадна Швейцарт төвтэй Дэлхийн өрсөлдөх чадварын төвөөс мөн дэлхийн улс орнуудыг эрэмбэлэн өрсөлдөх чадварыг тодорхойлдог.

Дэлхийн улс орнуудыг 12 үзүүлэлтээр 100 хүртэл оноо өгч тухайн жил судалгаанд хамрагдсан улсуудтай харьцуулан эрэмбэлж байна. Үзүүлэлтүүд нь институтууд, дэд бүтэц, мэдээлэл харилцааны технологийг

²² Wolfgang, Merkel (2003). Defekte Demokratie.

нэвтрүүлж буй байдал, макро эдийн засгийн тогтвортой байдал, эрүүл мэнд, ур чадвар, бүтээгдэхүүний зах зээл, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн тогтолцоо, зах зээлийн хэмжээ, бизнесийн динамик, инновацын боломж чадварыг хэмждэг онцлогтой. Индексийн нийт 113 хувьсагч хэмжигдэхүүний 2/3-ийг эксперт, шинжээчид болон хамтын ажиллагаатай байгууллагуудаас 1/3-ийг олон нийтэд нээлттэй эх сурвалжаас цуглуулдаг (World Economic Forum, 2021).

Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлтийн үнэлгээг зарим судлаачид хэт субъектив хэмээн шүүмжилдэг. Учир нь засаглалын чанарыг тодорхойлох үзүүлэлтийн арга зүй нь хүний жам ёсны халдашгүй байх эрхийн үзэл баримтлал дээр тулгуурладаг ч тухайн улсын иргэдийн улс төрийн эрхийн болон иргэний эрхийн ойлголт, хэрэгжилтийг хэмжих ёстой гэж анхааруулдаг. Дэлхийн Банкны арга зүйгээр дэлхийн улс орнуудын газар зүйн байршил, угсаатны бүлэг, шашин шүтлэг, эдийн засгийн хөгжлөөс үл хамааран бүх улс оронд нэг стандартыг мөрдөж судалгааг хийдэг тул үүнийг сул тал хэмээн үзсэн (Campbell, D.F.J, Barth, T.D., 2009).

2.4 Улс төрийн эрх, иргэний эрхийн хэрэгжилт ба иргэдийн дуу хоолой

Нийгэм, улс төрийн харилцаанд иргэдийн улс төрийн зан төлөвийг ойлгоход судлаач О.Хиршманы (Exit, Voice and Loyalty)²³ дэвшүүлсэн онолын үзэл баримтлал чухал үүрэгтэй бөгөөд хувь хүний болон нийгмийн тодорхой бүлгүүдийн, аль нэг улс төрийн нам эсвэл төрийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байдлаа илэрхийлэх иргэдийн хариу үйлдлийг тайлбарлах боломжийг олгодог (Hirschman, 1970). Тухайлбал, Ардчилсан Герман Улсын (DDR)²⁴ иргэд 1989 оноос өмнө нийгмийн хөгжил, улс төрийн нэг намын тогтолцоог хүлээн зөвшөөрч чадахгүйн улмаас эх орноо орхих (EXIT) буюу баруун Герман улс руу 500 мянга гаруй иргэн цагаачилсан байдаг (Schmelz, 2002). Мөн нийгмийн нөхцөл байдлыг сайжруулахын тулд иргэд дуу хоолойгоо (Voice) хүргэх зорилгоор эсэргүүцэл илэрхийлсний улмаас тухайн үедээ 200 мянга гаруй хүн улс төрийн хоригдол болсон түүхтэй ажээ (Schröder & Wilke, 1998). Өөрөөр хэлбэл, улс төрийн харилцаанд иргэдийн **Орхих**²⁵ үйлдэл нь эх орноосоо дайжих, иргэдийн **Дуу хоолой**²⁶-гоо хүргэх арга зам нь улс төрийг өөрчлөхийг хүсэмжлэх, жагсаал, цуглаан хийн эсэргүүцэх байдлаар

²³ Hirschmann, A.O (1970). Exit, Voice, and Loyalty: Responses to Decline in Firms, Organizations, and States.


²⁴ Deutsche Demokratische Republik.

²⁵ Exit буюу Гарах үгийг Орхих гэх агуулгаар ашиглав.

²⁶ Voice буюу Дуу хоолой гэх агуулгаар ашиглав.

илэрдэг. Харин эсрэгээрээ **Үнэнч байх**²⁷ буюу идэвхгүй, хүлцэнгүй байдалд шилжих нь улс төрийн үйл ажиллагааг сайжрах байх гэсэн найдвар тээсэн хүлээлт болдог байна. Эдгээр ойлголт нь байгууллага, институци, улс төрийн орчинд сэтгэл ханамжгүй байгаа тохиолдолд хувь хүмүүс эсвэл бүлэг хүмүүс хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг тодорхойлдог тул энэхүү судалгаанд ач холбогдолтой (Зураг 5).

Зураг 5. Русбултын онол дахь хувьсагч хоорондын харилцан хамаарал



Эх сурвалж: Rusbult. C.E, Farrell. D, Rogers. G, Mainous. A.G (1988). *Impact of Exchange Variables on Exit, Voice, Loyalty, and Neglect: An Integrative Model of Responses to Declining Job Satisfaction*, In *The Academy of Management Journal*, vol 31, pp.599-627.

О.Хиршманы (Exit, Voice and Loyalty) дэвшүүлсэн онолын ойлголт тус бүрийг задлан авч үзвэл:

1. Орхих (EXIT):

Exit гэх үгийн агуулгыг Орхих гэсэн ойлголтоор судалгаанд ашиглах ба энэ нь сэтгэл ханамжгүй нөхцөл байдал, байгууллагаас гарах, компаниа орхих, эсвэл улс эх орноо “орхих” сонголтыг илэрхийлнэ. Ингэж орхих замаар хувь хүнийхээ зүгээс эсэргүүцэл илэрхийлэх идэвхтэй хэлбэр, эсхүл сэтгэл ханамжгүй байдалд шилжих идэвхгүй хэлбэрийг илэрхийлдэг. Хиршман үүнийг эдийн засгийн харилцаанд “зах зээлийн” хариулт хэмээн үзэж, харин улс төрийн харилцаанд “итгэл алдрах” гэж үзжээ. Учир нь энэ нь ихэвчлэн хувь хүний хувийн ашиг сонирхол, илүү сайн хувилбар хайх хүсэлд суурилдаг гэж тодорхойлсон.

²⁷ Loyalty буюу үнэнч байх гэх агуулгыг Эх орондоо үнэнч байх гэсэн ойлголтоор ашиглав.

2. Дуу хоолой (VOICE):


Дуу хоолой гэх ойлголт нь сэтгэл ханамжгүй байгаагаа илэрхийлэх хэлбэр бөгөөд улс төрийн орчинд санал бодлоо илэрхийлж, арга хэмжээ авах замаар нөхцөл байдлыг сайжруулахыг оролдох сонголт юм. Хувь хүмүүс эсвэл бүлгүүд орхихын оронд одоогийн нөхцөл байдлыг засах, шинэчлэх оролдлого хийж, дуу хоолойгоо хүргэх, өөрчлөлт хийхийг уриалдаг байна. Энэ хэлбэр нь ихэнх хүмүүсийн хувьд аливаа асуудлыг шийдвэрлэхийн тулд шийдвэр гаргагчид, эсхүл тухайн байгууллагад нөлөөлөхийг эрэлхийлдэг илүү хамтын чанартай улс төрийн хариу үйлдлийг илэрхийлдэг.

3. Үнэнч байдал (Loyalty):

Үнэнч байдал гэдэг нь аливаа зүйл сайжирна гэсэн итгэлтэй хүлээлтийн хэлбэрийг илэрхийлнэ. Улс төрийн хувьд эх орондоо үнэнч байх асуудал нь ихэнхдээ сэтгэл ханамжгүй хэдий ч ёс заншил, нийгмийн үүрэг хариуцлагын улмаас иргэн хүний хувьд сэтгэл ханамжгүй байсан ч эх орондоо үнэнч үлдэх сонголтыг илэрхийлдэг. Хиршманы онолын хувьд үнэнч байдал гэдэг ойлголт нь орхих эсвэл дуу хоолойгоо гаргах шийдвэрийг хойшлуулж, иргэдийг хүлээлтийн байдалтай буюу идэвхгүй төлөвт орших нөхцөлийг үүсгэдэг. Өөрөөр хэлбэл, улс төрийн сонголт хийх хүсэлгүй хэдий ч үүнээс илүү сонголт байхгүй гэсэн итгэл үнэмшлээр асуудалд хандах хандлага юм. Мөн үнэнч байх нь тогтворжуулах хүчин зүйл болж, хувь хүн аливаа нэг улс төрийн системд, эсвэл байгууллагад, мөн нийгэмд үүрэг хариуцлагаа ухамсарлаж, сонголтгүй нөхцөлд асуудал өөрөө шийдэгдэнэ гэсэн хүлээлтийн хэлбэр гэж үзсэн.

Орхих, дуу хоолой, үнэнч байх тухай ойлголтыг улс төрийн тогтолцоонд, засгийн газрын үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа улс төрийн шийдвэр болон аливаа нэгэн бодлогод сэтгэл хангалуун бус байгаа иргэд эсхүл бүлэг хүмүүс хэрхэн хариу үйлдэл үзүүлэх сонголтын хувилбар гэж судлаачид тайлбарладаг (Зураг 6).

Зураг 6. Улс төр дэх харилцаа “Орхих”, “Дуу хоолой”, “Үнэнч байх”



Эх сурвалж: Clark. W.R, Golder. M, Golder. S.N (2017). An Exit, Voice and Loyalty Model of Politics, The British Journal of Political Science.

Эдгээр ойлголтууд нь улс төр судлалд иргэдийн сэтгэл ханамжгүй байдал, амьдралын нөхцөл байдал муудаж байгаа үед улс төрийн үйл явцад оролцох эсвэл түүнээс татгалзах, идэвхгүй болж байгаа зэрэг янз бүрийн улс төрийн оролцооны хэлбэрийг тайлбарлахад тусалдаг. “Орхих” ба “дуу хоолой” үзүүлэлтүүд нь өөр хувилбар гэсэн Хиршманы санаа нь засгийн газартаа сэтгэл дундуур байгаа иргэд орхих үйлдэл үзүүлэхийн (гарах) өмнө аливаа зүйлийг өөрчлөх (дуу хоолой) эсэхээ шийдэх ёстой гэдэг улс төрийн угтвар нөхцөлийг шаарддаг. Тухайлбал, аль нэг улс орон авлига, дарангуйлалтай бол ардчилсан шинэчлэл хийхийг шаардахын тулд иргэд цагаачлах (гарах) эсхүл эсэргүүцэх (дуу хоолой) хэлбэрийг сонгох боломжтой байдаг. Учир нь аль нэг сонголтыг хийхийн өмнө тэд сонголтын хувилбаруудын тухай бодсон байдаг гэж үзжээ. Тухайлбал;

Улс төрийн нөхцөл дэх орхих гэсэн ойлголт нь улс төрийн тогтолцоо, нийгмийн хэрэгжүүлж буй бодлого, засаглалын үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байгаагаас үүдэн гарах буюу орхин явах шийдвэр, энэ шийдвэрийг гаргасан хувь хүн, бүлгүүдийг хэлнэ. Улс төрийн хүрээнд орхих гэх ойлголт нь дараах олон хэлбэрээр илэрч болно.

- **Цагаачлал:** Хүмүүс засгийн газар, улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн нөхцөл байдалд сэтгэл хангалуун бус байгаа нөхцөлд эх орноо орхин дайжих хөдөлгөөнд ордог. Үүний нэг жишээ бол улс төрийн дүрвэгсэд юм. Цагаачлагчид нь улс төрийн авторитар дэглэмээс зугтаж буй хүмүүс бөгөөд улс төрийн дургүйцлийн хариу

болгон “гарах буюу орхих” шийдвэр гаргаж буй үйл ажиллагаа юм.

- **Салан тусгаарлах буюу тусгаар тогтнолын хөдөлгөөн:** Тухайн улс дахь бүс нутаг эсвэл бүлгүүд улс төрийн тогтолцооноос салан тусгаарлахыг эрмэлзэх үзэгдэл. Тухайлбал, Каталаны Испани Улсаас садан тусгаарлах төлөөх оролдлого, мөн Шотландын Их Британи Улсаас салан тусгаарлах оролдлого зэрэг түүхэн үйл явцыг нэрлэж болно.
- **Сонгууль, улс төрд оролцохгүй байх:** Иргэд улс төрийн сонгуулийн санал хураалт болон бусад улс төрийн үйл явцад санаатайгаар оролцохгүй байх шийдвэр гаргах, улс төрийн сонгуульд цагаан хуудас өгөх, улс төрийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцохоо болих зэргээр гарах буюу орхих үйлдэл хийдэг. Эдгээр нь хувь хүний болон аливаа нэгэн нийгмийн бүлгийн эсэргүүцэл, эсхүл сэтгэл ханамжгүй байдлыг илэрхийлэх нэг хэлбэр бөгөөд хүмүүс одоо байгаа улс төрийн хүрээнд үлдэх нь боломжгүй гэж үзсэнээр ихэнхдээ орхин явах сонголтыг хийдэг байна.

Улс төрийн нөхцөл дэх дуу хоолой гэх ойлголт нь сэтгэл дундуур байгаагаа идэвхтэй илэрхийлэх хэлбэр бөгөөд улс төрийн өөрчлөлтөд нөлөөлөхийг эрэлхийлдэг. Тухайлбал, хүмүүс орхих үйлдэл хийхийн өмнө ихэнхдээ өөрсдийн дуу хоолойгоо хүргэх, өөрсдийн оролцоотой аль нэгэн шинэчлэлийг шаардах, төрийн бодлогыг эсэргүүцэх, удирдлага солих асуудлыг нийгэмд уриалдаг. Иргэдийн дуу хоолой нь улс төрийн хүрээнд олон хэлбэртэй байж болно. Тухайлбал,

- **Жагсаал, цуглаан:** Иргэд улс төр, нийгэм, эдийн засгийн шинэчлэл хийхийг шаардан олон нийтийн эсэргүүцэл зарлах, тухайн байгууллага дээр ажил хаялт хийх, нийгмийг хамарсан жагсаал цуглаан зохион байгуулж болно. Эдгээр нь иргэний эрхийн хөдөлгөөний хэлбэртэй, эмэгтэйчүүдийн сонгуулийн эрх ашгийн төлөөх хөдөлгөөний хэлбэртэй, мөн бусад нийгмийн хөдөлгөөний хэлбэрээр өөрсдийн үзэл бодол, дуу хоолойгоо улс төрийн өөрчлөлтийг уриалсан байдалтай илэрч болно.
- **Олон нийтийн мэтгэлцээн, хэлэлцүүлэг:** Иргэд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өөрсдийн байр суурийг илэрхийлэх замаар нийтийн санаа бодолд нөлөөлөх, улстөрчдөд шахалт үзүүлэх боломжтой. Тухайлбал, улс төрийн бүлэг, ТББ-ууд хууль батлах, төрийн аливаа нэгэн бодлогод өөрчлөлт оруулахыг лоббидож болно.

- **Сонгуулийн оролцоо:** Иргэд өөрсдийн хүсэл сонирхлоо илэрхийлж, хувь итгэл үнэмшил, нийгмийн үнэт зүйлс буюу улсын эрхэмжид нийцсэн сонголтыг хийх замаар улс төрийн орчныг өөрчлөхийн тулд дуу хоолойгоо илэрхийлэх хэлбэр юм.
- **Өргөдөл ба иргэний дуулгаваргүй байдал:** Нийгэмд эсвэл улс төрийн орчинд шинэчлэл хийх шаардлагуудыг илэрхийлэхийн тулд иргэний хувьд өргөдөл гаргах, хуулиар зөвшөөрсөн хэлбэрээр эсэргүүцэл илэрхийлэх зэрэг үйлдэл нь илүү албан ёсны шинжтэй бөгөөд иргэн хүний хувьд дуулгаваргүй байдалд шилжих нь албан бус хэлбэр юм. Өөрөөр хэлбэл, иргэд итгэл алдарч, цөхөрсөн нөхцөлд дуулгаваргүй байдалд ордог байна. Энэ утгаараа иргэдийн дуу хоолой нь улс төрийн сэтгэл ханамжгүй байдлыг шийдвэрлэх идэвхтэй хандлага бөгөөд улс төрийн нөхцөл байдлыг дотроос нь сайжруулах, өөрчлөх хүслийг илэрхийлдэг.

Улс төрийн нөхцөл дэх үнэнч байдал гэдэг нь иргэд төрийн үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байгаа хэдий ч улс төрийн тогтолцоонд, засгийн газрын бодлого, шийдвэрт болон аль нэгэн улс төрийн намд тууштай байх, дэмжлэг үзүүлэх хэлбэр юм. Энэхүү ойлголтыг “Эх орондоо үнэнч байх” гэсэн агуулгаар энэ судалгаанд ашиглаж байгаа болно. Учир нь О.Хиршман “Үнэнч байх” гэх ойлголтыг хүлээлтийн төлөв байдлаар тодорхойлсон. Өөрөөр хэлбэл, эх орондоо үнэнч байх нь эх оронч үзэл, тууштай байх утгыг илэрхийлнэ. Иймээс иргэдийн хувьд улс төрийн орчинд асуудлыг сайжруулах боломжтой гэдэгт итгэх итгэлээр илрэх хэлбэр юм. Үнэнч байх нь олон хэлбэрээр улс төрийн хүрээнд илэрдэг. Тухайлбал,

- **Улс төрийн санал хураалт ба оролцоо:** Иргэд тухайн улс төрийн шийдвэрт сэтгэл хангалуун бус байсан ч улс төрийн намд, улс төрийн үзэл баримтлалд итгэж, улс төрийн орчныг сайжирна гэсэн хүлээлттэй, өөрсдийн итгэл үнэмшлээс үүдэн нэг нам, эсвэл нэр дэвшигчийн төлөө үргэлжлүүлэн санал өгдөг.
- **Үндсэрхэг үзэл эсхүл эх оронч үзэл:** Иргэд төрийн байгуулал дахь институцийн гаргаж буй шийдвэрт бухимдсан ч улс орныхоо үнэт зүйлс, эрхэмлэх уламжлал, үндэсний соёлоо хадгалах нь зүйтэй гэж үзэн эх орондоо үнэнч байж болно.
- **Улс төрийн уучлал үзүүлэх:** Үнэнч байдал нь нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврыг үл харгалзан тухайн бодлого, удирдагч, улс төрийн намыг хамгаалах зэрэг хэлбэрээр асуудлыг зөвтгөх, улс төрчийг эсхүл улс төрийн намд уучлал үзүүлдэг байна.

- **Шинэчлэл хийх хүлээлт:** Иргэдийн хувьд засгийн газрын үйл ажиллагаа сайжрах байх гэсэн хүлээлтийн улмаас, эсхүл тэдний амлалт эерэг өөрчлөлтийг авчрахад тусална гэж итгэсэн итгэл үнэмшлээс үүдэн улс төрийн тогтолцоонд үнэнч, идэвхтэй байж болно. Үнэнч байх нь эерэг болон сөрөг үр дагавартай байдаг ба иргэд одоо байгаа тогтолцоогоо сайжирна гэсэн хүлээлтээс үүдэн орхин явах эсвэл дуу хоолойгоо хүргэж шийдвэр гаргах үйл явцыг удаашруулж болно. Энэ утгаараа үнэнч байх нь тогтворжуулах хүчин зүйл болох бөгөөд Хиршманы онолоор орхин явах, эсэргүүцэх үйлдлийг удаашруулдаг талтай.

Буфер болох үнэнч байдал: Үнэнч байдал нь орхих болон дуу хоолойгоо хүргэх хувилбарын аль алинд нь саад болдог. Иргэд муу засаглалын үед ч эх орондоо үнэнч хэвээр үлдэж, эсвэл улс орныхоо чадавхад итгэж, сэтгэл санаа, үзэл баримтлалын хувьд улс төрийн тогтолцоонд тууштай ханддаг учраас ихэнхдээ сайжирна гэсэн хүлээлттэйгээр үнэнч байх нь элбэг. Зарим тохиолдолд үнэнч байх нь иргэд өөрчлөлтийг хүлээж, бухимдах, тэвчээр нь барагдах үед орхин явахад хүргэдэг байна (Schröder & Wilke, 1998).

Харин иргэд төрөлх улс орноо өөрсдөө сонгодоггүй учраас улс орны эдийн засгийн уналт, улс төрийн доройтол, эсхүл төрийн удирдлагын гаргасан буруу шийдвэрт сэтгэл хангалуун бус байгаагийн хариу үйлдэл нь ихэнхдээ хувь хүний өөрийн сонголт байдаг. Тухайлбал, иргэд улс орноо орхин явах, эсвэл нийтийн бүтээгдэхүүн үйлчилгээнээс татгалзах боломж нь хязгаарлагдмал юм. Учир нь зарим нийтийн бараа бүтээгдэхүүний үндсэн чанараас хамааран иргэд орхих үйлдэл хийх боломжтой, тухайлбал төрийн нийлүүлж байгаа боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг орхиж хувийн үйлчилгээг авч болно. Гэхдээ энэ төрлийн хувийн үйлчилгээ авсан иргэд нийтийн үйлчилгээний чанар муугаас үүдэх хор хохирлоос зугтаах боломж хомс. Иймд иргэд дуу хоолойгоо илэрхийлэх эсхүл чимээгүй байх гэсэн сонголтыг хийх нь элбэг байдаг.

Дуу хоолойгоо илэрхийлэх нь үнэнч байхаас шууд хамааралтай. Иргэний улс орондоо үнэнч байх нь тухайн хүний өссөн гэр бүл, хүй элгэнээс хамаарах бөгөөд энд нийгмийн хэм хэмжээ, соёлд суралцаж, зөв буруугийн итгэл үнэмшилтэй болж нийгмийн харилцаанд оролцох суурь бүрдэнэ. Үнэнч байдал нь бага байх тусам орхих магадлал өндөр, үнэнч байдал нь өндөр бол дуу хоолойгоо илэрхийлэх магадлал өндөр байна. Мөн үнэнч байх нь улс орноо орхихгүй гэсэн баталгаа биш бөгөөд дуу хоолойгоо илэрхийлнэ ч гэсэн баталгаа бас биш юм. Өөрөөр хэлбэл, үнэнч байх нь иргэн буюу бүлгийн гишүүн улс орон, нийгмийн бүлгээ

орхихгүй байх, эсвэл дуу хоолойгоо илэрхийлэх гарцаагүй нөхцөл биш. Учир нь үнэнч байх асуудал ухамсаргүй үнэнч байхаас эхлэн зайлшгүй ухамсарлагдсан үнэнч байх гэсэн хоёр туйлын хооронд орших бөгөөд хариу үйлдэл нь бас олон тооцоололд үндэслэгдэн гарна (Hirschman, 1970).


Дуу хоолойгоо илэрхийлнэ гэдэг нь орхих нөхцөлийн нэмэлт гаргалгаа болохоос биш, түүнийг орлуулах үйлдэл биш. Зарим тохиолдолд иргэн тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг орхисон хойноо ч гэсэн дуу хоолойгоо илэрхийлж болно. Тухайлбал, дуу хоолойгоо илэрхийлэх нь төрийн үйл ажиллагааг сайжруулах өндөр ач холбогдолтой ч ямар түвшинд байх нь өнгөрсөн туршлагаас хамаардаг байна. Иргэд өөрсдийн дуу хоолойгоо үйл ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулж чадна гэж итгэсэн үед л илэрхийлэх ба үгүй гэж үзсэн нөхцөлд тэд чимээгүй, идэвхгүй хэв шинжид шилжинэ. Өөрөөр хэлбэл, өнгөрсөн туршлагын өртөг-үр дүнгийн шинжилгээнээс хамааран иргэн дуу хоолойгоо илэрхийлэх эсэхээ шийднэ.

Энэ утгаараа иргэдийн дуу хоолой эгэх хариуцлагатай шууд холбогддог. Хэрэв төрийн байгууллага эгэх хариуцлага өндөртэй байвал түүний бүтээгдэхүүн үйлчилгээний чанарын доройтол эхлэх үед л иргэд санал бодлоо илэрхийлэн чанарыг сайжруулах боломжийг эрэлхийлнэ. Харин төрийн байгууллагын эгэх хариуцлага сул байвал иргэд дуу хоолойгоо илэрхийлэхгүй, идэвхгүй төлөвт шилжин, хэдийгээр улс орондоо үнэнч байгаа ч гэсэн орхих боломжийг эрэлхийлж эхэлдэг байна.

2.5 Судалгааны үзэл баримтлал

“Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” үзүүлэлтийг хэмжиж Монгол Улсын өнөөгийн нөхцөлд уг үзүүлэлт ямар төлөвтэй байгааг тодорхойлохдоо нэгдүгээрт, Фрийдом Хаусын засаглалын үзүүлэлтийн дагуу “улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт болон иргэний эрхийн хэрэгжилт” үл хамаарах хувьсагч байхаар, хоёрдугаарт, Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлт “иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” хамаарах хувьсагч байхаар тодорхойлж, судлаач О.Хиршманы онолын үзэл баримтлал болох “Орхих”, “Дуу хоолойгоо хүргэх”, “Үнэнч байх” үзүүлэлтүүд Монгол Улсын иргэдийн хувьд ямар байгааг тодорхойлон тайлбарлахад чиглэнэ.

Зураг 7. Судалгааны үзэл баримтлалын зураглал



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Хамаарах хувьсагчийг “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” байхаар тодорхойлсон. Учир нь иргэд өөрсдийн дуу хоолойгоо нийгмийн харилцаанд илэрхийлж чадаж байгаа эсэхийг тодорхойлохын тулд нэгдүгээрт, иргэд өөрсдийн дуу хоолойгоо илэрхийлж чадахгүй нөхцөлд чимээгүй байх сонголт хийдэг, хоёрдугаарт, иргэд дуу хоолойгоо илэрхийлэх хүсэлгүй төлөвт буюу цөхөрсөн нөхцөлд орхих сонголт хийдэг гэсэн О.Хиршманы хэмжээсээр тодорхойлж байна.

Харин эгэх хариуцлага гэх ойлголтын хүрээнд нэгдүгээрт, иргэд дуу хоолойгоо хүргэх сонирхолтой байгаа эсэх буюу иргэний эрхээ хэрэгжүүлдэг, хоёрдугаарт, дуу хоолойгоо хүргэдэг боловч нийгмийн болон улс төрийн харилцаанд төрийн эгэх хариуцлага үзүүлдэггүй тул идэвхгүй, цөхөрсөн учраас орхих үйлдэл хийх хүсэлтэй байгаа зэргийг иргэдийн “эх орондоо үнэнч байх” гэсэн үзүүлэлтээр хэмжихээр тодорхойлсон.

Үл хамаарах хувьсагчийг улс төрийн эрхийн тухай ойлголт, хэрэгжилт болон иргэний эрхийн хэрэгжилт гэсэн хоёр хувьсагч байхаар тодорхойлж, нийт 17 асуултаар хэмжихээр судалгааны дизайныг боловсруулсан. Учир нь улс төрийн эрхийн ойлголттой хүн эрхээ бүрэн эдлэх чадвартай бөгөөд улс төрийн эрхийн хэрэгжилтийн үнэлгээ нь иргэний эрхийн хэрэгжилтийг тодорхойлно гэж үзсэн. Иймээс иргэний эрхийн ойлголтыг судалгааны асуулгад тусгаагүй болно. Үүнд:

- Улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт гэдэг нь Монгол Улсын иргэн үндсэн хуулиар баталгаажуулсан улс төрийн эрхийн тухай бүрэн ойлголттой эсэх, улс төрийн шийдвэр гаргалтад улс төрийн эрхийн хяналттай оролцдог эсэх буюу урьдчилсан байдлаар болзолт нөхцөлийг тодорхойлж, иргэн улс төрийн эрхээ бүрэн ухамсарласан нөхцөлд нийгмийн харилцаанд улс төрийн эрх үндсэн хуулийн дагуу хэрэгжинэ гэж тодорхойлсон.

- Иргэний эрхийн хэрэгжилт гэдэг нь Монгол Улсын иргэн Үндсэн хуулиар баталгаажуулсан жам ёсны эрх болон нийгмийн гэрээний эрхийг, тухайлбал, үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал цуглаанд оролцох, зохион байгуулах, итгэл үнэмшилтэй байх, хэвлэн нийтлэх эрхээ бүрэн ухамсарласан эсэх, улс төрийн харилцаанд эдгээр эрхийг бүрэн эдэлж байгаа эсэхээр тодорхойлсон.

ГУРАВ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

3.1 Судалгааны арга, түүний төрөл

Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага үзүүлэлтийн хэрэгжилтийг судлах энэхүү судалгааны ажил нь тодорхойлох судалгааны төрөлд хамаарна. Тодорхойлох судалгаа нь *“нийгмийн үйл явц, хүмүүс, бүлгүүдийн төрөл, хэлбэрүүдийн дүр зургуудыг тодорхойлон гаргах түгээмэл зорилт”, ямар, хэрхэн* гэсэн асуултуудад хариулт өгөхийг зорьдог (Баатартогтох, 2012). Учир нь бид судалгаагаар засаглалын үзүүлэлт болох “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” өнөөгийн нөхцөлд ямар байгааг судалж, эдгээрийн харилцаа, уялдааг судалгааны үзэл баримтлалын хүрээний дагуу судална.

Энэхүү судалгаанд тоон болон чанарын судалгааны аргууд болох баримт бичгийн шинжилгээ, контент анализ, асуулга судалгаа, харилцан хамаарал, вариаци болон корреляцийн шинжилгээ, ганцаарчилсан ярилцлага зэрэг аргуудыг хослуулан хэрэглэнэ. Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагын төлөв байдлыг тодорхойлох, түүнийг үнэлэхийн тулд тулгамдаж буй асуудал, ардчилсан засаглал, түүний хэв шинж, засаглалын үзүүлэлтүүд, индексүүд, олон улсын туршлага зэргийг хамруулан судлагдсан байдлын тоймыг бичихдээ баримт бичгийн шинжилгээний аргыг ашигласан.

Иргэдийн санал, гомдлыг хүлээн авах чиг үүрэгтэй Засгийн газрын 11-11 мэдээллийн төвд ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдолд контент анализ хийж, агуулгыг задлан шинжлэх аргыг ашиглан шинжилж, үр дүнг нэгтгэсэн. Судалгааны анхдагч мэдээллийг асуулга судалгааны аргаар цуглуулж, үр дүнг судалгааны боловсруулалт хэсэгт нэгтгэв. Судлагдсан байдлын тойм болон асуулгын үр дүнг шинжилсний үндсэн дээр тодруулах асуудлыг нарийвчлан гаргаж, энэ чиглэлээр судалгаа хийдэг, үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн 5 шинжээч/эксперттэй ганцаарчилсан ярилцлага хийж, экспертийн ярилцлагаа дүнгээр бусад шинжилгээний үр дүнг баталгаажуулав.

3.2 Судалгааны эх олонлог, түүвэр

Монгол Улсын 18 наснаас дээш 2,144,686 иргэд энэхүү судалгааны эх олонлог байхаар тодорхойлов. Гэвч судалгаа хийх цаг хугацаа, хүний нөөц болон санхүүгийн хязгаарлалтаас хамаарч энэхүү судалгаанд магадлалт бус түүврийг ашиглан асуулгын судалгааг Улаанбаатар хот,

Дархан-Уул, Дундговь аймгуудад зохион байгуулав. Эх олонлог, түүврийн хэмжээг тодорхойлоход дараах алхмуудыг хийсэн.

Эхний алхамд судалгааны мэдээллээ цуглуулах аймгуудыг тодорхойлж нийт 21 аймгаас 2 аймгийг төлөөлөл болгож, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийг сонгосон. Монгол Улсын хүн амын тал хувь буюу 49.5 хувь (1,734,848) нь амьдардаг Улаанбаатар хотыг эхний түүвэрт сонгосон. Улаанбаатар хотын хувьд хүн амын төвлөрлөө дагаад нийгмийн олон асуудал тулгамддаг, улс төрийн идэвхжил ихтэй, төрийн байгууллагууд бүгд байрладаг тул иргэдийн улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт ямар байгааг судлахад ихээхэн ач холбогдолтой юм.

Мөн хотжилт ихсэх төлөвтэй аймгуудын төлөөлөл болгож Дархан-Уул аймгийг сонгосон. Түүврийн 3 дахь төлөөллөөр Дундговь аймгийн төвийн сумыг сонгосон нь: Нэгдүгээрт хүн амын тоогоор цөөнөөрөө хоёрт (Говьсүмбэр аймаг хамгийн цөөн буюу 18,042 хүнтэй) эрэмбэлэгддэг, нийт 46,092 хүнтэй. Хоёрдугаарт, эдийн засгийн хөгжлөөр мөн л хамгийн сул хөгжилтэй 2 дахь аймаг байна. Иймд эдийн засгийн идэвхжил сул, хүн ам цөөн байх нь иргэдийн улс төрийн эрхийн хэрэгжилтэд ялгаатай байдлыг бий болгож буй эсэхийг тодруулах зорилгоор Дундговь аймгийг сонгосон.

Хоёрдугаар алхамд цаг хугацаа, хүний нөөц, төсвийн хязгаарлалттай холбоотойгоор судалгаа хийх хот, аймгаас дүүрэг, сумыг сонгон эх олонлогоо төлөөлөх байдлыг тодорхойлов. Хүн амын төвлөрлийг харгалзан Улаанбаатар хотын хувьд төвийн зургаан дүүрэг болох Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн сонгуулийн насны 947,939 иргэд эх олонлогийг бүрдүүлж байна. Эдгээр 6 дүүрэгт нийт 1.6 сая хүн буюу Улаанбаатар хотын хүн амын 96.0 хувь нь амьдардаг. Харин Дархан-Уул аймгийн хувьд Дархан хотод нийт хүн амын 81.6 хувь буюу 89,130 хүн амьдардаг. Дархан-Уул аймгийн сонгуулийн насны хүн ам нь нийт хүн амын 83.0 хувийг эзэлдэг байна. Дундговь аймгийн хувьд 15 сумтай ба тэдгээрээс хамгийн олон буюу 16,866 хүнтэй аймгийн төв буюу Сайнцагаан сумыг судалгаанд хамруулав. Дундговь аймгийн төв болох Сайнцагаан сумын хүн амын 9,930 буюу 59.0 хувь нь сонгуулийн насны иргэд байна. Түүнчлэн, Дархан-Уул аймаг болон Дундговь аймгийн байршил нь судалгааны багийнхан хүрч очиход харьцангуй ойр буюу 240-248 километр зайтай байгаа нь цаг хугацаа, тээвэр, томилолтын зардлын хувьд судалгааны төсөвт багтаж байсан зэрэг давуу талтай байв.

Гуравдугаар алхамд сонгосон гурван байрлалын хувьд түүврийн хэмжээг тодорхойлсон. Түүврийн хэмжээг тогтоохдоо эх олонлогоос 95

хувийн итгэх түвшинтэй ± 5 хувийн алдааны хязгаартай байхаар түүврийн хэмжээг тодорхойлох томьёогоор тооцооллыг хийв. Үүний дүнд Дархан-Уул аймгаас 382, Дундговь аймгаас 267, Улаанбаатар хотоос 385 хүн байхаар түүврийн хэмжээг тус тус тодорхойлсон.

Дөрөвдүгээр алхам, асуулга судалгаанд санамсаргүй бус/магадлалт бус түүврийн квот болон бололцоот түүврийн загварыг ашиглав. Квот түүврийн загварын хувьд “бололцоот байдлаас гадна судлаачийн сонирхож буй судалгааны эх олонлогийн хүйс, яс үндэс гэх зэрэг илэрхий шинж чанаруудад хөтлөгддөг” (Кумар, 2014, хууд. 258) тул сонгосон Дундговь, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотод хүн амын хүйс, нас, байгууллагын бүтцэд тулгуурлан квот тогтоож, шаардлагатай тоог гүйцтэл үргэлжлүүлсэн. Харин бололцоот түүврийг нь энэхүү судалгаанд ашиглагдсаны шалтгаан нь “хандалт амархан байх, газарзүйн дөхөмтэй байдал... зэрэг гол төлөв судлаачид тохиромжтой байхаар хийдэг” (Кумар, 2014, хууд. 259). Иймд богино хугацаанд томилолтоор явах судалгааны багийн гишүүд хүн олноор явдаг худалдааны төв, залуучууд цугладаг газар, их сургууль, настайчуудын хэвтэн эмчлүүлдэг эмнэлэг зэрэг газруудад очиж, асуулга бөглөхийг зөвшөөрсөн иргэдээс судалгааг бөглүүлж авсан.

3.3 Хувьсагч, түүний хэмжүүр

Хүснэгт 3. Судалгааны үл хамаарах болон хамаарах хувьсагчдын үзүүлэлт

Д/д	Ойлголт	Үзүүлэлт
Үл хамаарах хувьсагч		
1	Улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт	-Улс төрийн эрхийн ойлголт -Улс төрийн эрхийн хэрэгжилтийн үнэлгээ
2	Иргэний эрхийн хэрэгжилт	-Иргэний эрхийн хэрэгжилтийн үнэлгээ
Хамаарах хувьсагчид		
3	Дуу хоолой	-Хувь хүмүүс эсхүл бүлгүүд улс орноо орхин явахын оронд одоогийн нөхцөл байдлыг засах, шинэчлэх оролдлого хийж, дуугарч, өөрчлөлт хийхийг уриалах
4	Эгэх хариуцлага	Иргэний эгэх хариуцлагатай байдал, төрийн эгэх хариуцлагатай байдал

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Хүснэгт 4. Судалгааны үл хамаарах ба хамаарах хувьсагчдыг хэмжих асуултууд

Д/Д	Хувьсагч	Асуултын нэр	Хэмжих шкал (1-6)
1	Улс төрийн эрхийн ойлголт	-Иргэд улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох)-ээ бүрэн дүүрэн эдэлдэг	1. Эрхээ бүрэн эдэлдэггүй 6. Эрхээ бүрэн эдэлдэг
		-Иргэн таны улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох) бол ардчиллын баталгаа мөн.	1. Ардчиллын баталгаа биш 6. Ардчиллын баталгаа мөн
		-Миний улс төрийн эрхэнд хэн ч халдаж чадахгүй	1. Амархан халддаг 6. Халдаж чадахгүй
		-Таны бодлоор бусад иргэд улс төрийн эрхээ хараат бусаар эдэлж чаддаг	1. Чаддаггүй 6. Чаддаг
2	Улс төрийн эрхийн хэрэгжилт	-Улс төрийн намын жагсаалт болон тойргийн мандатын сонголт (2024 оны УИХ-ын сонгууль) маш зөв.	1. Маш буруу 6. Маш зөв
		-УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийг сонгох улс төрийн сонгууль үргэлж шударга явагддаг.	1. Шударга явагддаггүй 6. Шударга явагддаг
		-Сонгуулийн Ерөнхий хороо нь УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийг хараат бус, ардчиллын зарчмыг ханган зохион байгуулдаг.	1. Зохион байгуулж чаддаггүй 6. Зохион байгуулж чаддаг
		-Сонгуулийн Ерөнхий хорооны удирдлагын сонгон шалгаруулалт зөв явагддаг.	1. Буруу явагддаг 6. Зөв явагддаг
		-Одоогийн УИХ-ын гишүүд чөлөөт, шударга сонгуулиар сонгогдсон.	1. Чөлөөт, шударга сонгуулиар сонгогдоогүй 6. Чөлөөт шударга сонгуулиар сонгогдсон
3	Иргэний эрхийн хэрэгжилт	-Би өөрийнхөө эрх ашгийг хамгаалах үүднээс иргэний нийгмийн байгууллагыг байгуулах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох боломжоор бүрэн хангагдсан.	1. Хангагддаггүй 6. Бүрэн хангагдсан
		Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой.	1. Боломжгүй 6. Боломжтой
		-Сонгогчдын бүртгэл үнэн зөв, цаг тухайд нь ил тод, ялгаварлан гадуурхалтгүй хийгддэг.	1. Хийгддэггүй 6. Хийгддэг
		-Нэр дэвшигчид үг хэлэх, олон нийтийг хамарсан уулзалт хийх, сонгуулийн сурталчилгааны явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийг тэнцвэртэй ашиглах боломжоор бүрэн хангагддаг.	1. Хангагддаггүй 6. Бүрэн хангагддаг
		-Улс төрийн бүх шатны сонгууль нууц санал хураалтаар явагддаг.	1. Явагддаггүй 6. Явагддаг
		-Нийгэмд болохгүй байгаа асуудлыг төрийн байгууллагын иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах сувагт (11-11, санал хүсэлтийн хайрцаг, аймаг, сумын вэб хуудас) ил тод, нээлттэй илэрхийлэх нь асуудлыг шийдвэрлэх гарц мөн.	1. Шийдвэрлэх гарц биш 6. Шийдвэрлэх гарц мөн

4	Дуу хоолой	-Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай.	1. Үгээ хэлэх шаардлагагүй 6. Үгээ хэлэх шаардлагатай
		-Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг	1. Эсэргүүцлээ илэрхийлдэггүй 6. Эсэргүүцлээ илэрхийлдэг
	Төрийн эгэх хариуцлага	-Нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар хаана ч, хэнд ч хандаад нэмэргүй.	1. Хэлээд нэмэргүй 6. Хэлэх нь нэмэртэй
	Иргэний эгэх хариуцлага	“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ.	1. Нэгдэхгүй 6. Нэгдэнэ

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

3.4 Онч ба найдвартай байдал

3.4.1 Фактор шинжилгээ

Иргэдийн дуу хоолой, эгэх хариуцлагын тогтолцоогоор хүлээн зөвшөөрөгдсөн засаглалын гүйцэтгэлийн үндсэн хэмжигдэхүүнийг үнэлэх зорилгоор хүчин зүйлийн шинжилгээ хийсэн. Энэхүү статистикийн арга нь ажиглагдаж буй хувьсагчдын хэлбэлзлийг тайлбарлах далд бүтцийг тодорхойлох боломжийг олгож, засаглалын гүйцэтгэлийн гол хөдөлгөгч хүчний талаар илүү гүнзгий ойлголттой болох боломжийг олгож байна.

Хүснэгт 5. Хүчинтэй ба дотоод нийцтэй байдлын шинжүүрийн үр дүн

Rotated Component Matrix			Cronbach's Alpha
Улс төрийн эрхийн ойлголт/хэрэгжилт			
Фактор 1	7. Иргэд улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох)-ээ бүрэн дүүрэн эдэлдэг.	0.754	
	8. Иргэн таны улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох) бол ардчиллын баталгаа мөн.		
	9. Миний улс төрийн эрхэнд хэн ч халдаж чадахгүй		
	10. Таны бодлоор бусад иргэд улс төрийн эрхээ хараат бусаар эдэлж чаддаг.		
Фактор 2	11. Улс төрийн намын жагсаалт болон тойргийн мандатын сонголт (2024 оны УИХ-ын сонгууль) маш зөв.	0.893	
	12. УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийг сонгох улс төрийн сонгууль үргэлж шударга явагддаг.		
	13. Сонгуулийн Ерөнхий хороо нь УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийг хараат бус, ардчиллын зарчмыг ханган зохион байгуулдаг.		
	14. Сонгуулийн Ерөнхий хорооны удирдлагын сонгон шалгаруулалт зөв явагддаг.		
	15. Одоогийн УИХ-ын гишүүд чөлөөт, шударга сонгуулиар сонгогдсон.		

Иргэний эрхийн хэрэгжилт		
Фактор 3	20. Би өөрийнхөө эрх ашгийг хамгаалах үүднээс иргэний нийгмийн байгууллагыг байгуулах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох боломжоор бүрэн хангагдсан.	0.781
	26. Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой.	
	16. Сонгогчдын бүртгэл үнэн зөв, цаг тухайд нь ил тод, ялгаварлан гадуурхалтгүй хийгддэг.	
	17. Нэр дэвшигчид үг хэлэх, олон нийтийг хамарсан уулзалт хийх, сонгуулийн сурталчилгааны явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийг тэнцвэртэй ашиглах боломжоор бүрэн хангагддаг.	
	18. Улс төрийн бүх шатны сонгууль нууц санал хураалтаар явагддаг.	
	23. Нийгэмд болохгүй байгаа асуудлыг төрийн байгууллагын иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах сувагт (11-11, санал хүсэлтийн хайрцаг, аймаг, сумын вэб хуудас) ил тод, нээлттэй илэрхийлэх нь асуудлыг шийдвэрлэх гарц мөн.	
Эх орондоо үнэнч байх		
Фактор 4	27. Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар.	0.735
	28. Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу явсан.	
	29. Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна.	

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

3.4.2 Найдвартай байдлын шинжилгээ

Судалгааны хувьсагчдын найдвартай байдлыг хэмжихийн тулд “улс төрийн эрхийн ойлголт/хэрэгжилт”, “иргэний эрхийн талаарх ойлголт/хэрэгжилт”, “иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага”-г тандсан нийт 23 бүлэг асуултын найдвартай байдал Кронбах альфа утга 0.847 байгаа нь асуултуудын дотоод нийцтэй байдал нь онч найдвартай байгааг илтгэсэн. Улмаар Дархан-Уул, Дундговь аймгууд болон, Улаанбаатар хотод асуулгын аргыг ашиглан өгөгдөл цуглуулсан.

Хүснэгт 6. Судалгааны нийт хувьсагчдын Кронбах Альфа утга

Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standartixed Items	N of Items
0.847	0.854	23

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд ашигласан нийт 23 асуултын хүрээнд “дуу хоолой”-г бүрдүүлж буй хувьсагчид хэдийгээр нэг хүчин зүйлийг бүрдүүлж байгаа боловч, найдвартай байдлын Кронбах альфа утга эргэлзээтэй байгаа тул судалгаанд хувьсагч тус бүрийг шинжилж үзсэн.

Хүснэгт 7. Судалгааны хүчин зүйл тус бүрийн Кронбах Альфа утга

Хүчин зүйлсийн нэр	Cronbach's Alpha	N of Items
Улс төрийн эрхийн ойлголт	0.754	4
Улс төрийн эрхийн хэрэгжилт	0.893	5
Иргэний эрхийн хэрэгжилт	0.749	4
Эх орондоо үнэнч байх	0.735	3

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Шинжилгээнээс харахад дуу хоолойноос бусад хувьсагчдын Кронбах альфа нь 0.7-оос их гарсан тул найдвартай байдал хангагдаж байна.

3.5 Өгөгдөл цуглуулах үйл явц

Судалгааны анхдагч өгөгдлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр (Google form) асуулга авч цуглуулсан. Тодруулбал, Улаанбаатар хотын судалгааг цахим хэлбэрээр авсан. Харин Дархан-Уул болон Дундговь аймгийн төв болох Сайнцагаан суманд судалгааны багийнхан очиж хэвлэмэл асуулгын хуудсаар асуулгыг бөглүүлсэн.

Асуулгын судалгааг авч эхлэхээс өмнө судалгааны багийнхан 2 удаа дотоод уулзалт хийж асуулт нэг бүрээр арга зүйн зөвлөгөө авч, асуулт бүрийн тайлбарыг судалгааны багийн гишүүн бүр адил авч, судалгааны зорилго, ойлголтыг нэгтгэсэн. Эхний асуулгын судалгааг Дархан-Уул аймагт хийсэн ба томилолтын хоёр бүтэн өдөр ажиллахдаа өдөр бүрийн төгсгөлд асуулга, асуулттай холбоотой тодруулах зүйл гарсан эсэх, хариултуудыг судалгаанд оролцогчид хэр ойлгож буйг багаараа ярилцаж, дараагийн өдрөөс өмнө ойлголт, тайлбараа жигдэлсэн. Мөн орой бүр асуулгын өгөгдлөө Google form-д шивж оруулахын зэрэгцээ өгөгдлийн боловсруулалтыг хариуцсан судлаач өгөгдөл зөв оруулсан эсэхэд давхар хяналт тавьж ажилласан.

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлын дараа асуулгын өгөгдлийг программд бүрэн шивж нягтлан асуултын агуулгыг алдагдуулахгүйгээр томъёоллыг өөрчлөх эсэх талаар ярилцаж хоёр асуултын хувьд товч тайлбарыг хаалтад хийж оруулаад, асуулгыг Улаанбаатар хотоос цахим хэлбэрээр (Google form) авах зарчмаар ажилласан. Асуулгыг бодитой бөглөсөн эсэхийг мөн асуулгын боловсруулалт хариуцсан судлаач нягталж ажиллав.

Экспертийн ганцаарчилсан ярилцлагыг иргэний улс төрийн эрхийн хэрэгжилтийн чиглэлээр судалгаа хийж, эрдэм шинжилгээний бүтээл

гаргасан туршлагатай, эрдэмтдээс авсан. Судалгааны баг судлагдсан байдлын тойм хийхдээ Монгол Улсын ардчилал, засаглалын талаар олон улсын индексүүдийн үр дүнгээс тодруулах шаардлагатай ойлголт, үр дүнг шүүж харьцуулан дүгнэсэн. Мөн асуулгын судалгааны үр дүнг боловсруулж, иргэдийн улс төрийн ойлголт, хэрэгжилт болон иргэний эрхийн хэрэгжилтийг үнэлүүлэх асуудлыг нягтлан гаргаж, Фрийдом Хаусын 2023 оны судалгааны тайлангийн суурь үнэлгээг судалгааны үр дүнтэй харьцуулан асуултын удирдамж боловсруулсан. Эдгээр тодруулах шаардлагатай асуудлын хүрээнд мэргэжлийн экспертүүдээс авах бүтэцлэгдсэн ярилцлагын асуултуудыг судалгааны багаараа хэлэлцэн баталснаар эксперт бүртэй цаг тохирон, ганцаарчилсан байдлаар уулзаж ярилцлагыг хийсэн.

3.6 Өгөгдөл боловсруулалт

Асуулгын аргаар цуглуулсан өгөгдлийг боловсруулахдаа Microsoft Excel болон SPSS25 программуудыг ашиглаж, харин өгөгдлийн боловсруулалтыг шалгахдаа JASP программ хэрэглэв.

ЗГХЭГ-ын Иргэдээс санал, гомдол хүлээн авах 11-11 төвд утас, и-мэйл, албан бичиг, факсаар ирсэн 1062 өргөдөл, гомдолд контент анализ хийхдээ иргэний “улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт” болон “иргэний эрхийн ойлголт, хэрэгжилт”-д хамаарах 3-4 шалгуурыг тодорхойлж, түүний дагуу өргөдөл, гомдлыг нэг бүрчлэн уншиж, шалгуурт холбогдох байдлаар нь анхдагч болон хоёрдогч түвшний кодлолыг хийсэн. Анхдагч түвшинд санал, гомдлыг төрлөөр нь ангилсан бол хоёрдогч түвшний буюу зүй тогтлын кодлолыг тодорхойлсон шалгууруудын дагуу хийв. Контент шинжилгээний боловсруулалтыг Microsoft Excel программаар хийж, үр дүнг нэгтгэсэн.

Экспертийн ганцаарчилсан ярилцлагын хувьд судлаач бичгээр тэмдэглэж авахын зэрэгцээ аудио хэлбэрээр бичлэг хийсэн. Ярилцлагын дараа аудио файлыг бичгийн хэлбэрт хөрвүүлж, агуулгын шинжилгээ хийн ярилцлагын хүрээнд тодруулсан асуудлыг судалгааны үр дүнгийн боловсруулалтдаа тусгасан.

ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН БОЛОВСРУУЛАЛТ

4.1 Монгол Улс дахь иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагын төлөв байдал

Иргэдийн зүгээс Улсын Их Хурал, Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны нэгжийн түвшинд дуу хоолойгоо илэрхийлэх, шууд оролцох албан ёсны механизмуудыг ашиглах боломжийг хуулиар олгосон. Тухайлбал, УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог хангах, УИХ-ын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэд өргөдлөө цахимаар илгээх боломжийг бүрдүүлэх (УИХ, 2024) үүднээс “Нийтийн өргөдөл, гомдлын систем [d.parliament.mn]” сайтыг 2022 оноос ажиллуулж эхэлсэн. Тухайлбал, уг системээс УИХ-д өргөн барьсан болон УИХ-ын гишүүдийн санаачилсан хуулийн төслүүдийн мэдээллийг авч, иргэдийн санал, бодлогыг тодорхойлох санал асуулгад оролцох, саналаа өгөх боломжтой. Хэрэв иргэд өөрсдөө санаачлан тодорхой асуудлаар ажлын хэсэг байгуулах (33,000 хүний дэмжлэг хэрэгтэй), байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах (70,000 хүний дэмжлэг хэрэгтэй), хуулийн төсөл санаачлах (100,000 хүний дэмжлэг хэрэгтэй) бол уг системийн “Нийтийн өргөдөл, гомдол шинээр санаачлах [petition.parliament.mn]” хэсэгт хандаж нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар хяналт тавиулах, хууль санаачлах боломжтой. Тухайлбал, 2024 оны 11 дүгээр сарын 25-нд иргэн Б.М нь Улаанбаатар хотын агаарын бохирдол ноцтой хэмжээнд хүрсэн тул нийтийн сонсгол хийх санаачилгыг УИХ-ын “Нийтийн өргөдөл, гомдол шинээр санаачлах” системд гаргаж 73,000 иргэний дэмжлэг авсан. Иймд 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн УИХ-ын чуулганаар агаарын бохирдлын талаар нийтийн сонсгол зохион байгуулах үүргийг УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд даалгасан²⁸ байна.

Орон нутгийн засаг захиргаа, нэгжийн түвшинд иргэд дуу хоолойгоо орон нутгийн захиргааны цахим хуудас болон бичгээр хандан илэрхийлж болохоос гадна өөрсдийн амьдрах орчинд тулгамдсан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх боломжийг Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) олгосон байдаг. 2012 оноос хэрэгжсэн олон нийтийн оролцоотой төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх зорилго бүхий ОНХС-д иргэд санал асуулгаар,

²⁸ <https://news.mn/r/2770396/>

эвлэлдэн нэгдэж бүлгийн (хүн амын нягтралаас хамаарч 20, 30, 50 хүн сайн дурын үндсэн дээр нэгдсэн) ярилцлага хийх, цахим сувгаар хөрөнгө оруулалтын санал өгч, тухайн орон нутгийн засаг захиргааны нэгжид хамгийн өндөр санал авч эрэмбэлэгдсэн төслүүдийг ОНХС-аас санхүүжүүлдэг зохицуулалт хэрэгждэг.

Уг сан нь Нэмэгдсэн өртгийн албан татвар, Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн орлого, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, Хайгуул хийх, олборлолт хийх тусгай зөвшөөрлийн орлогын тодорхой хувиас бүрддэг. Улмаар жил бүр ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийн аргачлалын дагуу аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилах төсвийн хөрөнгө оруулалтын дүнг тодорхойлж, хуваарилдаг. 2013-2023 оны хооронд ОНХС-аар дамжуулан 1.9 их наяд төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалтыг иргэдийн оролцоотойгоор хуваарилсан байна (Үндэсний Статистикийн Хороо, 2023).

Харин Засгийн газрын үйл ажиллагаанд иргэд дуу хоолойгоо илэрхийлэхэд Монгол Улсын Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв 11-11” (цаашид 11-11 төв гэх) зориулагддаг. Иргэдийн хүсэл, санал, гомдлыг сонсох, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн санаачилгын эргэх холбоог сайжруулах, уг тогтолцоог бий болгох, төрийн байгууллагын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэх нь тус төвийн зорилго юм.


Уг төвийг анх БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1957 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 209 дүгээр тогтоолын дагуу хөдөлмөрчдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хүлээн авч уулзах зэрэг ажлыг зохион байгуулах зорилготойгоор байгуулж байсан. Улмаар 2012 оноос хойш Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Захидал харилцааны хэлтсийн харьяа “Иргэдийг хүлээн авах байр” нэртэйгээр иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, хариу өгөх, шийдвэрлэлтийг хянах мэдээллийн тогтолцоог бий болгож, төрийн үйлчилгээг цаасгүй, түргэн шуурхай, хүнд сурталгүй хүргэх Засгийн газрын 11-11 төв болгон өөрчилсөн байна.

Программын хэрэглэгч талуудад төрийн байгууллага, оператор, иргэн, төрийн байгууллагын удирдлага байгаа бөгөөд тус тогтолцоо нь иргэдийн санал, хүсэлтийг утас, биечлэн, мессеж, мобайл, вэб сайт, вэб чат, сошиал цахим хэрэгсэл зэрэг 12 сувгаар хүлээн авч бүртгэн, холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах үүрэгтэй. Одоогоор тус тогтолцоонд 75 төрийн байгууллага холбогдсон бөгөөд иргэдийн санал, хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэж байна.

Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдлын ирүүлсэн хэлбэр, төрлийг бүртгэхдээ цахимаар, бичгээр, бусад гэсэн ялгаатай байдлаар бүртгэдэг. 2023 оны 01 дүгээр сарын 02-ноос 2024 оны 5 дугаар сарын 10-ны хугацаанд ирүүлсэн 1062 өргөдөл, гомдолд хийсэн контент шинжилгээний үр дүнг энэ хэсэгт нэгтгэн оруулав. Нийт өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилан авч үзэхэд 18.2 хувийг өргөдөл, 42.8 хувийг гомдол, 2.2 хувийг мэдээлэл, 3.3 хувийг санал, 33.1 хувийг хүсэлт, 0.4 хувийг шаардлага эзэлж байна.

Иргэдээс 11-11 төвд ирүүлсэн өргөдөл, гомдлын төрлийг авч үзвэл “Улс төрийн эрхийн”, “Иргэний эрхийн” гэж ангилж болохоор байна.

Зураг 8. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын эрхийн ангиллын үзүүлэлт, хувиар (2023-2024.05 сар)



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улс төрийн эрхийн үзүүлэлтэд хамаарах өргөдөл, гомдлыг агуулгаар нь харвал Засгийн газрын “Шүүр ажиллагаа”-тай холбоотой, Тэтгэвэр, тэтгэмжийн асуудлаарх, Газар зохион байгуулалт, газрын маргааны талаарх, Засгийн газрын шийдвэртэй холбоотой, Шүгэл ажиллагаатай холбоотой өргөдөл гомдол зэрэг багтаж байна. Тухайлбал, иргэн Х улсын тусгай хамгаалалттай газрын Х аймаг дахь хамгаалалтын захиргаатай холбоотой асуудлаар гомдол гаргасан бөгөөд 2023.04.03-ны өдөр гомдол гаргагчийн 9999**** дугаарт холбогдож, гомдолд дурдсан асуудал нь авлигын гэмт хэргийн шинжтэй тул Авлигатай тэмцэх газрын 110 дугаарт хандан мэдээлэх талаар зөвлөгөө өгсөн байдаг. Үүгээр Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл гомдлыг

шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт заасны дагуу хариуг утсаар өгч гомдлыг хаажээ.

Иргэний эрхийн хэрэгжилтэд хамаарах өргөдөл гомдлын агуулгыг харвал Ажлын байрны дарамт, Төрийн албан хаагчийн буруу шийдвэр, Шүүхийн шийдвэрийн хэрэгжилт, Багш нар, оршин суугчид, ахмад настнууд гэх мэтээр хэсэг бүлгээр эвлэлдэн нэгдэж хандсан өргөдөл гомдол, оршин суугчдын холбооны, ногоон байгууламж сүйтгэн барилга, орон сууц барихыг эсэргүүцсэн иргэдийн, иргэний маргаантай холбоотой өргөдөл гомдол зэрэг багтаж байна. Тухайлбал, Х аймгийн У сумын нэгэн нөхөрлөл, ашигт малтмал олборлолттой холбоотой асуудлаар иргэн гомдол хүргүүлсэн бөгөөд иргэний гомдлын дагуу Х аймгийн Засаг даргад албан бичиг хүргүүлж, Ажлын хэсэг гарган хяналт шалгалт хийлгэн дүгнэлт гаргаж, уг дүгнэлтээр илэрсэн зөрчилд үндэслэн У сумын Засаг даргад хариуцлага тооцуулж, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулсан асуудлыг тухайн аймгийн Засаг даргаас тус аймгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн жишээ байна.

Иргэдийн гомдлыг нарийвчилсан агуулгаар нь ангилбал дараах дүр зурагтай байна. (Зураг 9).

Зураг 9. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, агуулга (2023-2024.05 сар)²⁹




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулгад дүн шинжилгээ хийж үзэхэд Улс төрийн олон ургалч байдал, Иргэний оролцоотой холбоотой өргөдөл, гомдол хамгийн өндөр буюу 24.0 хувийг эзэлж байна. Харин хувь хүний Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй

²⁹ Давхардуулан бүртгэсэн хүчингүй 100 өргөдөл, гомдлыг хассан дүнг харуулав.

илэрхийлэх асуудалтай холбоотой өргөдөл, гомдол 21.0 хувь, Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой нь 17.0 хувь, Эвлэлдэн нэгдэх эрхийн хэрэгжилттэй холбоотой 15.0 хувь, Эрх зүйт төрийн үйл ажиллагаатай холбоотой 14.0 хувь, Хувь хүний халдашгүй байдал болон хувийн эрхийн хэрэгжилтийн асуудалтай холбоотой өргөдөл, гомдол 9.0 хувьтай байгаа бол Сонгуулийн үйл явцтай холбоотой нь хамгийн бага буюу 0.1 хувьтай байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын ирсэн төрлийг авч үзвэл, Албан бичгээр 54.0 хувь, утсаар 16.5 хувь, бусад байдлаар 27.7 хувь нь ирсэн байна (Зураг 10).

Зураг 10. Өргөдөл, гомдолд хариу өгсөн байдал, хувиар



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан


Эдгээр өргөдөл, гомдол, хүсэлтийг нэгтгэн үзэхэд улс төрийн болон иргэний эрхийн хэрэгжилтийг хангахын тулд Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд иргэд тодорхой хэмжээгээр ханддаг боловч, эргээд тэдний гомдол, саналд хариу өгсөн эсэх, тэдгээрийг Засгийн газар үйл ажиллагаандаа тусгасан эсэх мэдээлэл хангалтгүй буюу эргэх хариуцлагын холбоо сул, тодорхой мэдээллийн сан, мэдээлэлд дүн шинжилгээ хийн тайлагнасан баримт байхгүй байна.

4.2 Асуулга судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Иргэдийн дуу хоолой, эгэх хариуцлагын нөхцөл байдлыг тодруулах үүднээс судалгааны анхдагч өгөгдлийг цуглуулахаар 29 асуулт бүхий анкетын судалгааг Дархан-Уул, Дундговь аймгууд болон Улаанбаатар хотын төвийн зургаан дүүрэгт хийхээр 18-аас дээш насны хүн амыг хамруулан түүврийн хэмжээг тодорхойлж, судалгаанд хамруулсан. Магадлалт бус түүврийн аргаар Дархан-Уул аймгаас 382 иргэн, Дундговь аймгаас 267 иргэн, Улаанбаатар хотын төвийн зургаан дүүргээс 385 иргэн байхаар түүврийн хэмжээг тодорхойлон судалгааг хийж гүйцэтгэсэн.

Асуулга судалгаанд хамрагдсан 1034 иргэний ерөнхий мэдээлэлд боловсруулалт хийж үзэхэд дараах байдалтай байна (Зураг 11).


Зураг 11. Судалгаанд хамрагдсан аймгуудын түүврийн хэмжээ, тоогоор



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд хамрагдагчдыг насны бүлгээр нь авч үзвэл 18-34 насны иргэд хамгийн өндөр буюу 42.6 хувь (440), 35-49 насны иргэд 37.2 хувь (385), 50-64 насны иргэд 14.9 хувийг (154) тус тус эзэлж байгаа бол 65-аас дээш насны иргэд хамгийн бага буюу 5.3 хувийг (55) эзэлж байна.

Зураг 12. Судалгаанд хамрагдагчдын насны бүлэг, дүнд эзлэх хувиар




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаа хийсэн байршлуудад насны бүлэгт эзлэх хүний тоог харахад Улаанбаатар хотод залуусын хамрагдалт их, харин 50-иас дээш насныхны судалгаа бөглөсөн тоо бага байв. Дундговь аймагт асуулга бөглөсөн

иргэдийн дунд 50-64 нас болон 65-аас дээш насны ахмадууд өндөр хувь эзэлж асуулгад идэвхтэй оролцжээ.


Зураг 13. Судалгаанд хамрагдагчдын насны бүлэг, дүнд эзлэх хувиар, аймгаар



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Нийт судалгаанд оролцогчдын 46.0 хувь буюу 473 нь эрэгтэй, 54.0 хувь буюу 561 нь эмэгтэй байна.


Зураг 14. Судалгаанд хамрагдагчдын хүйсийн харьцаа, аймгаар, тоогоор



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Асуулга судалгаанд хамрагдсан хүмүүсийн боловсролын түвшинг нэгтгэн дүгнэвэл дараах байдалтай байна.


Зураг 15. Судалгаанд хамрагдагчдын боловсролын түвшин, аймаг, хотоор



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Нийт судалгаанд оролцогчдыг боловсролын түвшингээр нь авч үзвэл, 58.0 хувь нь дээд боловсролтой, ялангуяа бакалавр зэргийн боловсролтой иргэд байна. Тухайлбал, Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан иргэдийн 59.0 хувь, Дархан-Уул аймагт 40.1 хувь, Дундговьд 39.3 хувь нь тус тус бакалавр зэрэгтэй байна. Харин “Боловсролгүй” болон “Бага боловсролтой” иргэд нийт судалгаанд хамрагдагчдын нэг орчим хувийг эзэлжээ.


Зураг 16. Судалгаанд хамрагдагчдын ажил эрхлэлтийн байдал, аймаг, хотоор



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын иргэдийн 59.7 хувь (230), Дундговь аймгийн 64.4 хувь (172), Дархан-Уул аймгийн 63.4 хувь (242) нь бүтэн цагийн ажил эрхэлдэг иргэд байв. Харин хамгийн бага хувийг эзэлж байгаа үзүүлэлтүүдийг дурдвал, Ажил хайгаагүй болон хайж байгаа төлөвтэй Ажилгүйчүүд, Гэртээ өвчтэй хүн асардаг иргэд байна.

Зураг 17. Судалгаанд хамрагдагчдын ажилладаг байгууллагын төрөл, хувиар



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдагчдын 45.7 хувь нь Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн ажилтан, 18.2 хувь нь Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, 19.0 хувь нь Бусад гэсэн ангилалд хамаарах байгууллагад ажиллагч байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Дундговь аймгаас судалгаанд хамрагдагчдын 18.4 хувь нь Төрийн захиргааны байгууллагын ажилтан, 19.5 хувь нь Төрийн үйлчилгээний байгууллагад ажиллагч, 28.8 хувь нь Бусад гэсэн ангилалд хамаарах байгууллагад ажиллагчид байна. Дархан-Уул аймгаас судалгаанд хамрагдагчдын 15.4 хувь нь Төрийн захиргааны байгууллагад, 16.5 хувь нь Төрийн үйлчилгээний байгууллагад, 23.8 хувь нь Бусад гэсэн ангилалд хамаарах байгууллагад ажиллагч байна. Харин дээрх хоёр аймаг болон Улаанбаатар хотоос Малчид судалгаанд хамгийн бага хамрагдсан төлөвтэй байна. Дархан-Уул болон Дундговь аймгийн судалгаанд оролцогчдод төрийн албан хаагчдын эзлэх хувь Улаанбаатар хотын энэ төрлийн үзүүлэлттэй харьцуулахад харьцангуй өндөр байна.

4.3 Судалгааны дан тооллын үр дүн

Улс төрийн эрхийн тухай ойлголтыг Судалгааны 7-10 дугаар асуултаар; Улс төрийн эрхийн хэрэгжилтийг 11-15 дугаар асуултаар; 20, 25, 26 дугаар асуултаар иргэний эрхийн хэрэгжилтийг; 16-18 болон 23 дугаар асуултаар; 19, 21 дүгээр асуултад эгэх хариуцлага; 22 болон 24 дүгээр асуултаар иргэдийн дуу хоолой; 27-29 дүгээр асуултаар эх орондоо үнэнч


байх асуудлыг тодруулан 1-6 онооны³⁰ симантик дифференциал арга зүйн үнэлгээтэй байхаар асуулга судалгааг авч дан тооллын үр дүнг энэ хэсэгт нэгтгэв.

4.4 Улс төрийн эрхийн тухай ойлголт

“Иргэд улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох)-ээ бүрэн дүүрэн эдэлдэг” гэсэн асуултад Дундговь аймгийн оролцогчдын 46.8 хувь нь бүрэн эдэлдэг гэсэн нь Дархан-Уул болон Улаанбаатар хотын судалгаанд хамрагдагчдаас даруй 22.9-28.2 пунктээр өндөр байна. Улаанбаатар хотын судалгаанд хамрагдагчдын 53.8 хувь нь ямар нэг хэмжээгээр улс төрийн эрхээ эдэлдэг гэж хариулсан бол Дархан-Уул аймгийн оролцогчид улс төрийн эрхээ төдийлөн эдэлж чадахгүй байгаа нь тэдний 54.9 хувь нь улс төрийн эрхээ тодорхой хэмжээнд эдэлж чаддаггүй гэж хариулснаас харагдаж байна (Зураг 18).

Зураг 18. Иргэд үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох эрхээ эдэлдэг эсэх

7. Иргэд улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох)-ээ бүрэн дүүрэн эдэлдэг




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улс төрийн эрх ардчиллын баталгаа мөн гэсэн асуултыг Дундговь аймгийн (48.7%) болон Улаанбаатар хотын (41.8%) оролцогчид бүрэн дэмжиж 6 онооны үнэлгээ өгсөн бол Дархан-Уул аймгийн асуулгад оролцогчдын 25.7 хувь нь бүрэн дэмжсэн хариулт өгсөн байна. Уг асуултыг дэмжсэн хариултууд болох 4-6 онооны үнэлгээний нийлбэрийг харахад асуулгад хамрагдагчдын 57.4-72.2 хувь иргэдийн улс төрийн эрх нь ардчиллын баталгаа хэмээн ухамсарлаж буй нь ажиглагдлаа.

³⁰ 1-6 оноогоор үнэлсэн нь тархалтыг илүү нарийвчлан гаргах зорилготой.

Зураг 19. Улс төрийн эрх нь ардчиллын баталгаа мөн эсэх

8. Иргэд таны улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох)
бол ардчиллын баталгаа мөн




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Түүнчлэн, иргэдийн улс төрийн эрх халдашгүй байх тухай ойлголтын хүрээнд асуусан асуултад халдашгүй байх ёстой гэж Дархан-Уул аймгаас судалгаанд оролцогчдын 29.3 хувь, Дундговь аймгаас оролцогчдын 48.7 хувь, Улаанбаатар хотоос оролцогчдын 27.8 хувь нь тус тус хариулжээ. Гэвч уг эрхийн халдашгүй байдал сайн хангагдаагүй гэдэгтэй (хэрэв 1-3 онооны үнэлгээний нийлбэрийг авч үзвэл) Дархан-Уул аймгийн асуулгад оролцогчдын 44.5 хувь, Улаанбаатар хотын 43.6 хувь, Дундговь аймгийн 31.9 хувь нь санал нэг байна. Дүгнэн хэлбэл, улс төрийн эрхийн халдашгүй байдал бүрэн хэрэгждэггүй байна. Мөн Улаанбаатар хотын иргэд улс төрийн эрхийн халдашгүй байдалд сэтгэл дундуур байдлаар хандаж байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн эрхийн зөрчил нийгэмд байгааг илтгэж байна (Зураг 20).

Зураг 20. Иргэдийн улс төрийн эрхийн халдашгүй байдал

9. Миний улс төрийн эрхэнд хэн ч халдаж чадахгүй




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Ардчиллын баталгаа болсон улс төрийн эрхээ иргэд хэнээс ч хараат бусаар эдэлж чадаж байна (5-6 онооны нийлбэр) хэмээн Дундговь аймгийн оролцогчид (40.8%) нэлээд өөдрөгөөр дүгнэсэн байна. Харин Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын 28.3 хувь болон Дархан-Уул аймгийн судалгаанд оролцогчдын 29.8 хувь нь улс төрийн эрхээ хэнээс ч хараат бусаар эдэлж чадаж байна хэмээн хариулжээ. Харин Дархан-Уул аймгийн оролцогчдын 53.4 хувь, Улаанбаатар хотын оролцогчдын тал хувь (50.9%), Дундговь аймгийн оролцогчдын 43.4 хувь нь улс төрийн эрхийн хэрэгжилт тодорхой хэмжээгээр улс төрийн орчинд хараат байгааг хүлээн зөвшөөрсөн байна (Зураг 21).

Зураг 21. Иргэд улс төрийн эрхээ хараат бусаар эдэлж чаддаг эсэх

10. Таны бодлоор бусад иргэд улс төрийн эрхээ хараат бусаар эдэлж чаддаг



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Иргэдийн улс төрийн эрхийн ойлголт дунд түвшинд байгаа ч уг эрхээ бүрэн дүүрэн, халдашгүй, бусдаас хараат бусаар эдэлж чаддаг эсэх нь эргэлзээтэй байна. Бусад оролцогчидтой харьцуулахад Дундговь аймгийн оролцогчдын улс төрийн эрхийн хэрэгжилт харьцангуй өндөр байна. Улс төрийн эрхийн ойлголтын талаар тодруулсан асуултын хариултыг нэгтгэвэл дараах байдалтай байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Улс төрийн эрхийн ойлголтын нэгтгэл

Асуултын дугаар	Асуулт	1 [оноо]	2	3	4	5	6 [оноо]
Улс төрийн эрхийн ойлголт		Хувь					
7	Иргэд улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох)-ээ бүрэн дүүрэн эдэлдэг	14.4	10.0	21.2	15.5	11.1	27.9
8	Иргэн таны улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох) бол ардчиллын баталгаа мөн	11.0	6.1	16.6	15.5	13.2	37.6
9	Миний улс төрийн эрхэнд хэн ч халдаж чадахгүй	11.6	11.0	18.3	14.0	11.3	33.8
10	Таны бодлоор бусад иргэд улс төрийн эрхээ хараат бусаар эдэлж чаддаг	15.6	10.9	23.4	18.0	12.2	19.9

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдоос “Улс төрийн эрхийн ойлголт”-ын талаар тандсан 4 асуултын хүрээнд 1-6 онооны үнэлгээгээр (1-сөрөг үнэлгээ-6 эерэг үнэлгээ) үнэлүүлсэн үр дүнд 6 онооны түвшинд “Иргэд улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох)-ээ бүрэн дүүрэн эдэлдэг” 27.9 хувь, “Иргэн таны улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох) бол ардчиллын баталгаа мөн” 37.6 хувь, “Миний улс төрийн эрхэнд хэн ч халдаж чадахгүй” 33.8 хувь, “Таны бодлоор бусад иргэд улс төрийн эрхээ хараат бусаар эдэлж чаддаг” гэсэн хариулт 23.4 хувийг тус тус эзэлж байна. Нэгтгэн дүгнэж үзэхэд улс төрийн эрхийн ойлголт, түүний ерөнхий төлөвийг авч үзвэл арван хүн тутмын 3 нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан улс төрийн эрхийн агуулгыг ойлгодог гэж дүгнэхээр байна.


4.4.1 Улс төрийн эрхийн хэрэгжилт

Улс төрийн эрхийн хэрэгжилтийн гол талбар болох улс төрийн сонгуулийн хэрэгжилтийг үнэлүүлэхэд 2024 оны УИХ-ын сонгууль холимог тогтолцоогоор болсныг асуулгад оролцогчдын 16-18 хувь нь тун буруу гэсэн бол 12.2-25.5 хувь нь маш зөв шийдвэр болсон гэжээ. Өөрөөр хэлбэл, иргэдийн зүгээс өгсөн хариулт үнэлгээний онооны хоёр туйл руу савлаж байгаа нь иргэд улс төрийн сонгуулийн пропорциональ болон мажоритар тогтолцооны тухай ойлголт муутай болохыг илтгэж байна.

Энэхүү асуултын хариултын хувьд Дундговь аймгаас судалгаанд оролцогчдын 25.1-31.4 хувь нь уг сонгуулийн тогтолцоонд эргэлзэж байна. Хэрэв 1-3 онооны үнэлгээ буюу ер нь буруу гэсэн хариултын нийлбэрийг нэгтгэвэл 49.1-60.2 хувьтай байгаа бөгөөд иргэд улс төрийн сонгуулийн орчинд сэтгэл хангалуун бус байна (Зураг 22).

Зураг 22. Сонгуулийн холимог тогтолцоо зөв эсэх

11. Улс төрийн намын жагсаалт болон тойргийн мандатын сонголт
(2024 оны УИХ-ын сонгууль) маш зөв




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улс төрийн сонгууль хэр шударга явагддаг талаар иргэдээс асуухад 55.4-74.5 хувь нь ямар нэг байдлаар шударга бус явагддаг гэж хариулсан. Ялангуяа, Улаанбаатар хотын иргэд үүнд ихээхэн (31.7%) сэтгэл дундуур байна. Уг асуултад Дундговь аймгийн оролцогчдын 22.8 хувь нь сонгуулийг маш шударга явагддаг гэж хариулсан бол энэ үзүүлэлт Дархан-Уул аймагт 10.5 хувь, Улаанбаатар хотод дөнгөж 5.7 хувьтай байна (Зураг 23).

Зураг 23. Сонгууль шударга явагддаг эсэх

12. УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийг сонгох улс төрийн сонгууль үргэлж шударга явагддаг




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага болох Сонгуулийн Ерөнхий Хороо (СЕХ)-ны талаар иргэдээс үнэлгээ авахад 18.4-24.9 хувь нь хараат бус, ардчилсан байдлаар сонгуулийг зохион байгуулж чаддаггүй гэж хариулжээ. 1-3 онооны үнэлгээний нийлбэр нь Дархан-Уул аймагт 58,7 хувь, Дундговь аймагт 48,7 хувь, Улаанбаатар хотод 69.6 хувьтай байна. Судалгаанд оролцогчдын 6.5-26.2 хувь нь СЕХ-нь хараат бус гэж хариулжээ. Хариултын дүнг нэгтгэж үзэхэд СЕХ-ны талаарх иргэдийн үнэлгээ муу гарсан бөгөөд улс төрийн сонгуулийн зохион байгуулалт улс төрөөс хараат гэж дүгнэж болохуйц байна (Зураг 24).

Зураг 24. СЕХ хараат бусаар сонгууль зохион байгуулдаг эсэх

13. Сонгуулийн Ерөнхий хороо нь УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийг хараат бус, ардчиллын зарчмыг ханган зохион байгуулдаг




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

СЕХ-ны удирдлагын сонгон шалгаруулалтын талаар иргэдээс асуухад нийт судалгаанд оролцогчдын 4.9-23.6 хувь нь маш зөв явагддаг гэж хариулсан бол 15.7-25.7 хувь нь шударга бус гэж хариулжээ. Сонгуулийн Ерөнхий хорооны үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ болон удирдлагын сонгон шалгаруулалттай холбоотой асуудалд иргэд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлжээ. Эдгээр иргэдийн зүгээс өгсөн хариултын үр дүнг улс төрийн онолын хүрээнд авч үзвэл Волфганг Меркелийн 2003 онд дэвшүүлсэн “Гажуудсан ардчилал” буюу ардчиллын гажуудалд байдаг үр дүнг илэрхийлж байна. Нийт оролцогчдын 25.0 хувь нь сонгон шалгаруулалт төдийлөн зөв явагдаж чаддаггүй гэж үзсэн буюу институцийн түвшинд Сонгуулийн ерөнхий хороог иргэд хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь асуултын хариултаар тодорч байна (Зураг 25).

Зураг 25. СЕХ-ны удирдлагын сонгон шалгаруулалтын оновчтой байдал

14. Сонгуулийн Ерөнхий хорооны удирдлагын сонгон шалгаруулалт зөв явагддаг




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Сонгуулийн болон СЕХ-ны шударга байдалд эргэлзэж буй иргэд өнөөгийн УИХ-ын гишүүд чөлөөт, шударга байдлаар сонгогдсон гэдэгт ч мөн эргэлзэж байгаа нь асуулгад оролцогчдын 50.6-66.1 хувь нь 1-3 оноог өгснөөс харагдаж байна. Харин Дундговь аймгаас судалгаанд оролцогчдын 1/4 нь, Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотын оролцогчдын 1/10 орчим нь УИХ-ын гишүүдийг шударгаар сонгогдсон гэж үзэж үнэлгээ өгсөн байна (Зураг 26).

Зураг 26. УИХ-ын гишүүд шударгаар сонгогдсон эсэх

15. Одоогийн УИХ-ын гишүүд чөлөөт, шударга сонгуулиар сонгогдсон



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Нэгтгэн дүгнэхэд Улс төрийн эрхийн хэрэгжилт сул байгаа нь иргэдийн асуулгын хариултаар тодорч байна. Мөн улс төрийн сонгууль шударга явагддаггүй гэж иргэд үзэхийн зэрэгцээ сонгогдсон гишүүдэд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлжээ.

Улс төрийн сонгуулийг зохион байгуулдаг СЕХ-г засаглалын хувьд асуудалтай гэж үнэлсэн тул сонгуулийг хараат бус, ардчиллын зарчмаар сайн зохион байгуулж чаддаггүй гэсэн үнэлгээг иргэд өгч байв. Улаанбаатар хотын иргэдийн өгсөн улс төрийн эрхийн хэрэгжилтийн үнэлгээг Дундговь аймгийн оролцогчдын (1/4 хувь) энэ асуудалд өгсөн үнэлгээтэй харьцуулан үзвэл Дундговь аймгийн иргэд илүү өндөр үнэлгээ өгсөн байна. Улс төрийн эрхийн хэрэгжилтийн талаарх асуулгын хариултыг нэгтгэж үзэхэд дараах байдалтай байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Улс төрийн эрхийн хэрэгжилт

Асуултын дугаар	Асуулт	1 (оноо)	2	3	4	5	6 (оноо)
Улс төрийн эрхийн хэрэгжилт		Хувь					
11	Улс төрийн намын жагсаалт болон тойргийн мандатын сонголт (2024 оны УИХ-ын сонгууль) маш зөв.	16.7	10.0	29.3	16.8	10.3	16.8
12	УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийг сонгох улс төрийн сонгууль үргэлж шударга явагддаг.	27.8	16.4	21.5	14.4	8.0	11.9
13	Сонгуулийн Ерөнхий хороо нь УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийг хараат бус, ардчиллын зарчмыг ханган зохион байгуулдаг.	21.1	15.6	23.5	16.7	9.8	13.3
14	Сонгуулийн Ерөнхий хорооны удирдлагын сонгон шалгаруулалт зөв явагддаг.	20.8	14.5	26.0	19.3	8.6	10.7
15	Одоогийн УИХ-ын гишүүд чөлөөт, шударга сонгуулиар сонгогдсон.	22.9	14.4	23.6	17.7	8.1	13.2

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

“Улс төрийн эрхийн хэрэгжилт”-ийн үр дүнг харьцуулан дүгнэхэд “Улс төрийн намын жагсаалт болон тойргийн мандатын сонголт (2024 оны УИХ-ын сонгууль) маш зөв” гэсэн 3 онооны түвшинд 29.3 хувь, “УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийг сонгох улс төрийн сонгууль үргэлж шударга явагддаг” гэсэн 1 онооны түвшинд 27.8 хувь, “Сонгуулийн ерөнхий хороо нь УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийг хараат бус, ардчиллын зарчмыг ханган зохион байгуулдаг” гэсэн 3 онооны түвшинд 23.5 хувь, “Сонгуулийн ерөнхий хорооны удирдлагын сонгон шалгаруулалт зөв явагддаг” гэсэн 3 онооны түвшинд 26.0 хувь, “Одоогийн УИХ-ын гишүүд чөлөөт, шударга сонгуулиар сонгогдсон” гэсэн 1 онооны түвшинд хариулт 23.6 хувийг тус тус эзэлж байна. Эндээс дүгнэхэд иргэд улс төрийн эрхийн талаар харьцангуй сайн ойлголттой байна. Харин улс төрийн эрхийн хэрэгжилт тааруу гэж иргэд үнэлсэн байна.

Судалгааны дан тооллын үр дүнгээс газар зүйн байршил, нийгмийн бүлэг хооронд ялгаатай байдал байгаа эсэхийг тодорхойлох статистикийн ANOVA шинжилгээг хийж үзсэн болно. Ингэхдээ бүлгүүдийн тархалтын ижил байдлыг Левений тестээр шалгасан (p утга 0.570). Улс төрийн эрхийн хэрэгжилт Дархан-Уул болон Дундговь аймаг, Улаанбаатар хот гэсэн байршлуудад ялгаатай эсэхэд шинжилгээ хийхэд F утга 18.875 гарч байгаа нь бүлэг хоорондын ялгаа их байгааг харуулж байв. Харин P утга 0.05-аас бага буюу 0.001 гарч байгаа нь бүлгүүдийн хооронд статистикийн утгатай ялгаа байгааг илтгэж байв.

Хүснэгт 10. Улс төрийн эрхийн хэрэгжилтийн талаарх ANOVA шинжилгээний үр дүн

Cases	Sum of Squares	f	Mean Square	F	p
Байршил	1.409	12	0.705	18.875	< .001
Residuals	0.448	2	0.037		

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Түүнчлэн Дархан-Уул аймаг-1, Дундговь аймаг-2, Улаанбаатар хот-3 гэж кодлон бүлэг хоорондын ялгааг илүү нарийвчлан харвал дараах үр дүн гарч байна.

Хүснэгт 11. Бүлэг хоорондын ялгааны үр дүн

Mean Difference			SE	t	p
1	2	-0.480	0.122	-3.928	0.007
	3	0.260	0.122	2.128	0.147
2	3	0.740	0.122	6.056	< .001

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Хүснэгтээс харахад Дархан-Уул аймаг ба Улаанбаатар гэсэн бүлгүүдийн P утга 0.05-аас их буюу 0.147 байгаа нь Улс төрийн эрхийн хэрэгжилт ялгаагүй, Дархан-Уул аймаг ба Дундговь аймаг гэсэн бүлгийн P утга 0.007, Дундговь аймаг ба Улаанбаатар хот гэсэн бүлгийн P утга 0.001 байгаа нь Улс төрийн эрхийн хэрэгжилт ялгаатай байгааг тус тус харуулж байна. Эндээс дүгнэхэд хотын статус бүхий бүлгийн хооронд Улс төрийн эрхийн хэрэгжилт ялгаагүй, хот ба аймаг гэсэн бүлгийн хооронд ялгаа байна.


4.4.2 Иргэний эрхийн хэрэгжилт

Өөрийн эрх ашгийг хамгаалах, дуу хоолойгоо илэрхийлэхийн тулд иргэд зөвхөн төрийн үйл ажиллагааг харах биш иргэний нийгмийн байгууллагыг өөрсдөө байгуулах эрхтэй, үйл ажиллагаанд нь чөлөөтэй оролцох боломжтой гэдгээ сайн мэдэхгүй байгаа нь 20 дугаар асуултад

1-3 онооны түвшинд иргэдийн өгсөн үнэлгээний эзлэх хувиас (54.9-58.2) харагдаж байна. Хачирхалтай нь Монгол Улсад бүртгэлтэй ТББ-уудын дийлэнх нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг хэдий ч асуулгад оролцогчдын 58.2 хувь нь уг эрхээ сайн мэдэхгүй байв. Өмнөх асуултуудын адил Дундговь аймгийн судалгаанд оролцогчдын 1/4 нь 6 онооны түвшинд буюу бүрэн хангагдсан гэж хариулжээ (Зураг 27).

Зураг 27. Иргэний эрхээ хэрэгжүүлэхэд нийгмийн байгууллагын талаарх ойлголт

20. Би өөрийнхөө эрх ашгийг хамгаалах үүднээс төрийн бус байгууллагыг байгуулах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох боломжоор бүрэн хангагдсан




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Хэнийг ч сонгоод огт өөрчлөлт авчрахгүй гэсэн иргэдийн цөхөрсөн төлөв буюу төлөөллийн ардчилалд итгэл алдсан байдал судалгаанд оролцогчдын 17.4-22.1 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, арван хүн тутмын хоёр нь цөхөрсөн төлөвтэй байна (Зураг 28).

Зураг 28. Хэнийг ч сонгоод өөрчлөлт авчрахгүй

25. Хэнийг ч сонгоод өөрчлөлт авчрахгүй




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын 51.6-54.0 хувь нь зөв хүнээ төрийн аль нэг шатны эрх байгууллагад сонговол өөрчлөлт авчирна гэдэгт итгэсээр байна.

Эх орондоо сайхан амьдрах боломжтой эсэх талаар иргэдээс тодруулахад итгэл найдвар бүрэн алдсан, эсхүл бүрэн итгэлтэй байгаа гэсэн хоёр туйлын хооронд жигд тархалттай хариултыг өгчээ. Өөдрөг хариулт (4-6 онооны түвшинд) өгсөн хүмүүсийн эзлэх хувь 52.6-60.2 байгаа нь эерэг үр дүн юм (Зураг 29).

Зураг 29. Эх орондоо сайхан амьдрах боломжтой эсэх

26. Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилтийн үр дүнтэй харьцуулан үзвэл иргэний эрхийн ойлголт төдийлөн сайн биш, цөхөрсөн шинжтэй буюу иргэний нийгмийн тухай ойлголтгүй болох нь тодорч байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн сонголтоор засгийн бүх эрх мэдэл шийдэгдэх боломжтой гэсэн Үндсэн хуулийн 3-р зүйлийн агуулгын тухай мэдлэг дутмаг байв. Эндээс дүгнэхэд иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагаанд иргэд өөрсдөө идэвхтэй оролцдоггүй, нийгэмд тулгамдсан асуудлын талаар хаана, хэнд хандахаа сайн мэддэггүй, ер нь хэнд ч хэлээд өөрчлөлт төдийлөн авчрахгүй гэсэн цөхөрсөн байдал ялангуяа хотоос судалгаанд оролцогчдод илүү байгаа нь харагдаж байна. Иргэний эрхийн тухай ерөнхий асуултуудыг нэгтгэн үзэхэд дараах байдалтай байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Иргэний эрхийн асуултууд

Асуултын дугаар	Асуулт	1 (оноо)	2	3	4	5	6 (оноо)
Иргэний эрхийн ойлголт		Хувь					
20	Би өөрийнхөө эрх ашгийг хамгаалах үүднээс иргэний нийгмийн байгууллагыг байгуулах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох боломжоор бүрэн хангагдсан.	15.8	11.7	25.0	19.4	10.9	17.1
25	Хэнийг ч сонгоод өөрчлөлт авчрахгүй.	19.7	9.0	18.8	18.7	12.5	21.4
26	Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой.	14.8	11.6	16.2	16.7	11.3	29.3

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдыг “Иргэний эрхийн” тухай асуултуудаар тандаж үзэхэд “Би өөрийнхөө эрх ашгийг хамгаалах үүднээс иргэний нийгмийн байгууллагыг байгуулах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох боломжоор бүрэн хангагдсан” гэсэн гурван онооны түвшинд 25.0 хувь, “Хэнийг ч сонгоод өөрчлөлт авчрахгүй” гэсэн 6 онооны түвшинд 21.4 хувь, “Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой” гэсэн 6 онооны түвшинд 29.3 хувь нь хариулт тус тус өгчээ. Эндээс нэгтгэн дүгнэхэд иргэний эрхийн тухай мэдлэг хангалтгүй түвшинд, харин эх орондоо сайхан амьдрах боломжтой гэсэн итгэлтэй байгааг харж болно.

4.4.3 Иргэний эрхийн хэрэгжилтийн үнэлгээ

Сонгогчдын бүртгэл үнэн зөв, аливаа ялгаварлалгүй хийгддэг эсэхийг тодруулах асуулгад судалгаанд оролцогчдын 11.2-34.8 хувь нь бүрэн итгэж байна гэж хариулсан. Ялангуяа, Дундговь аймгийн оролцогчид 6 онооны түвшинд 34.8 хувьтай хариулжээ. Судалгаанд оролцогчдын хувьд асуултын хариултууд жигд тархалттай байгаа нь төвийг сахисан байдалтай байгааг илтгэж байна (Зураг 30).


Зураг 30. Сонгогчдын бүртгэл зөв хийгддэг эсэх



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Сонгуульд нэр дэвшигчид үг хэлэх, олон нийтийг хамарсан уулзалт хийх, сонгуулийн сурталчилгааны явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийг тэнцвэртэй ашиглах боломжоор бүрэн хангагдсан эсэхийг тодруулах асуултад судалгаанд оролцогчдын тал хувь нь тэнцвэртэй байдлаар сурталчилгаагаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр хийдэг хэмээн хариулжээ (Зураг 31).

Зураг 31. Нэр дэвшигчдэд ижил, тэгш боломж олгогддог эсэх




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Бүх шатны сонгууль нууц санал хураалтаар явагддаг гэсэн асуултад судалгаанд оролцогчид ялгаатай байдлаар хандсан байна. Тухайлбал, Дархан-Уул аймгийн хувьд асуулгад оролцогчдын 23.8 хувь, Улаанбаатар хотын хувьд 21.6 хувь, Дундговь аймгийн оролцогчдын 11.9 хувь нь нууц санал хураалтад ихээхэн эргэлздэг байна.

Харин нийт оролцогчдын 35.1-52.1 хувь нь сонгууль нууц санал хураалтаар явагддаг гэдэгт бүрэн итгэлтэй байна гэж хариулжээ. Улаанбаатар хотын хувьд уг асуудалд илүү эргэлзсэн байдлаар хариулсан байна (Зураг 32).

Зураг 32. Сонгууль нууц санал хураалтаар явагддаг эсэх

18. Улс төрийн бүх шатны сонгууль нууц санал хураалтаар явагддаг




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Иргэд өөрсдийн иргэний эрхийг хэрэгжүүлэх үүднээс санал бодлоо ил тод, чөлөөтэй илэрхийлэх нь чухал гэж Дархан-Уул аймгийн оролцогчдын 36.2 хувь, Улаанбаатар хотын оролцогчдын 36.6 хувь, Дундговь аймгийн оролцогчдын 46.5 хувь нь тус тус үзсэн байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь төвийг сахисан байр суурьтай буюу санал бодлоо төдийлөн сайн илэрхийлдэггүй болох нь 3-4 онооны түвшинд хариулсан тоон утгаас харагдаж байна (Зураг 33).

Зураг 33. Санал хүсэлтээ илэрхийлэх хэрэгтэй эсэх

23. Нийгмийн тулгамдсан асуудлыг иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах сувагт (11-11, санал хүсэлтийн хайрцаг, аймаг, сумын вэб хуудас) ил тод, нээлттэй илэрхийлэх нь асуудлыг шийдвэрлэх гарц мөн



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Иргэний эрхийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнг нэгтгэн үзэхэд үнэлгээ сайн биш байгаа нь доорх 4 асуултын хариултаас нотлогдож байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Иргэний эрхийн хэрэгжилт

Асуултын дугаар	Асуулт	1 (оноо)	2	3	4	5	6 (оноо)
Иргэний эрхийн хэрэгжилт		Хувь					
16	Сонгогчдын бүртгэл үнэн зөв, цаг тухайд нь ил тод, ялгаварлан гадуурхалтгүй хийгддэг	13.7	13.1	22.2	18.0	13.2	19.7
17	Нэр дэвшигчид үг хэлэх, олон нийтийг хамарсан уулзалт хийх, сонгуулийн сурталчилгааны явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийг тэнцвэртэй ашиглах боломжоор бүрэн хангагддаг	13.9	13.8	23.5	17.3	12.2	19.2
18	Улс төрийн бүх шатны сонгууль нууц санал хураалтаар явагддаг	10.9	9.0	19.8	18.8	11.9	29.6
23	Нийгэмд болохгүй байгаа асуудлыг төрийн байгууллагын иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах сувагт (11-11, санал хүсэлтийн хайрцаг, аймаг, сумын вэб хуудас) ил тод, нээлттэй илэрхийлэх нь асуудлыг шийдвэрлэх гарц мөн	10.5	9.1	20.2	21.2	13.9	25.0

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Харин “Иргэний эрхийн хэрэгжилт”-ийн үнэлгээний онооны түвшинг нэгтгэн үзэхэд “Сонгогчдын бүртгэл үнэн зөв, цаг тухайд нь ил тод, ялгаварлан гадуурхалтгүй хийгддэг” гэсэн асуулт 3 онооны түвшинд 22.2 хувь, “Нэр дэвшигчид үг хэлэх, олон нийтийг хамарсан уулзалт хийх, сонгуулийн сурталчилгааны явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийг тэнцвэртэй ашиглах боломжоор бүрэн хангагддаг” гэсэн асуулт 3 онооны түвшинд 23.5 хувь, “Улс төрийн бүх шатны сонгууль нууц санал хураалтаар явагддаг” гэсэн асуулт 6 онооны түвшинд 29.6 хувь, “Төрийн байгууллагаас иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах сувагт (11-11, санал хүсэлтийн хайрцаг, аймаг, сумын вэб хуудас) нийгэмд болохгүй байгаа асуудлыг ил тод, нээлттэй илэрхийлэх нь асуудлыг шийдвэрлэх гарц мөн” гэсэн асуулт 6 онооны түвшинд 25.0 хувийг тус тус бүрдүүлж байна. Эдгээрийг нэгтгэн дүгнэвэл иргэний эрхийн хэрэгжилтийн үнэлгээ төвийг сахисан тархалттай байгааг харуулж байна.

Иргэний эрхийн хэрэгжилтэд ANOVA шинжилгээг хийхдээ бүлгүүдийн тархалтын ижил байдлыг Левений тестээр шалгасан (p утга 0.570). ANOVA шинжилгээний үр дүнд F утга 6.065 гэсэн тоон үзүүлэлтэй гарч байгаа нь бүлэг хооронд ялгаатай байгааг харуулж байна. Харин P утга 0.05-аас бага буюу 0.021 тоон үзүүлэлтэй гарч байгаа нь бүлгүүдийн хооронд статистикийн утга ялгаа байгааг илтгэж байв.

Хүснэгт 14. Иргэний эрхийн хэрэгжилтийн талаарх ANOVA шинжилгээний үр дүн

Cases	Sum of Squares	df	Mean Square	F	p
Байршил	1.085	2	0.542	6.065	0.021
Residuals	0.805	9	0.089		

Мөн адил Дархан-Уул аймаг-1, Дундговь аймаг-2, Улаанбаатар хот-3 гэж кодлон бүлэг хоорондын ялгааг илүү нарийвчлан харвал дараах үр дүн гарч байна.

Хүснэгт 15. Бүлэг хоорондын ялгааны үр дүн

		Mean Difference	SE	t	p
1	2	-0.650	0.211	-3.074	0.040
	3	-0.025	0.211	-0.118	0.993
2	3	0.625	0.211	2.955	0.047

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотын нийгмийн бүлгүүдийн Р утга 0.05-аас их буюу 0.993 гэсэн тоон үзүүлэлтэй байгаа нь иргэний эрхийн хэрэгжилтэд ялгаа байхгүй, Дархан-Уул болон Дундговь аймгуудын нийгмийн бүлгийн Р утга 0.04, Дундговь аймаг ба Улаанбаатар хотын нийгмийн бүлгийн Р утга 0.047 гэсэн тоон үзүүлэлтэй байгаа нь иргэний эрхийн хэрэгжилт ялгаа байгааг харуулж байна. Эндээс дүгнэлт хийж үзвэл хотын статус бүхий нийгмийн бүлэг хооронд иргэний эрхийн хэрэгжилтэд ялгаа байхгүй, харин хотжилт өндөр бүс нутагт болон аймаг дахь нийгмийн бүлэг хооронд ялгаа байгаа нь тодорч байв.


Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагын төлөв байдлыг судлаач О.Хиршманы тодорхойлсон гурван хэмжээсээр ямар байгааг дан тооллын шинжилгээний үр дүнгээр танилцуулъя.

4.5 Эгэх хариуцлага

Иргэний эгэх хариуцлагын асуултын хариултаас үзвэл ерөнхий зүй тогтол нь хоёр туйл руу тэмүүлсэн хандлагатай байна. Улаанбаатар хотын иргэд эгэх хариуцлага султай байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал, судалгаанд оролцсон Улаанбаатар хотын иргэдийн 21.8 хувь нь иргэн эгэх хариуцлагатай байх ёстой гэсэн үнэлгээ өгсөн бол 28.1 хувь нь харин бид эгэх хариуцлагатай байх эсэх нь хамаагүй гэсэн байдлаар асуулгад хандсан байна (Зураг 34).

Зураг 34. Эгэх хариуцлагатай байх ёстой эсэх

19. "Төрийн төлөө оготно боож үхнэ" гэдэгтэй санал нэгдэнэ




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Харин Дархан-Уул, Дундговь аймгаас судалгаанд оролцогчид Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдоос илүү иргэд өөрсдөө эгэх хариуцлагыг чухалчилдаг байх ёстой гэж үзсэн байна. Зарим талаар эгэх хариуцлага байх ёстой гэсэн ойлголт судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд ойролцоо утга илэрхийлж байна. Эндээс нэгтгэн дүгнэвэл эгэх хариуцлагатай байгаа боловч ач холбогдолгүй буюу "хувиа бодож довоо шарлуулах" гэсэн үзэл хандлага Улаанбаатар хотод илүү өндөр байна. Эндээс дүгнэхэд иргэд эгэх хариуцлагын тухайд ялгаатай байр суурь илэрхийлж байгаа нь харагдлаа.

Төрийн эгэх хариуцлагын талаар иргэдийн үнэлгээ болох нийгэмд тулгамдсан асуудлын талаар иргэд дуу хоолойгоо илэрхийлэн төрийн үйл ажиллагаанаас хариу үйлдэл шаардах, мөн шаардлагад хэрхэн эгэх хариуцлагатай байж ирснийг тодруулах асуултад судалгаанд оролцогчдын 52.8-65.9 хувь нь "хаана ч хандаад нэмэргүй" буюу цөхөрсөн байдлыг илэрхийлж хариулсан байна. Өөрөөр хэлбэл, төрийн үйл ажиллагаанд иргэдийн итгэх итгэл алдарсан байгааг илэрхийлж байна (Зураг 35).

Зураг 35. Нийгмийн тулгамдсан асуудлын талаар хаана ч хэнд ч хандаад нэмэргүй

21. Нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар хаана ч, хэнд ч хандаад нэмэргүй



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан


Эдгээр хариултын оноог нэгтгэн дүгнэхэд төрийн эгэх хариуцлага маш муу буюу иргэдийн дуу хоолой илэрхийлсэн үйлдэлд хариу үйлдэл үзүүлдэггүй болох нь тодорч байна. Төрийн байгуулал, иргэн хоорондын харилцаанд иргэдийн итгэл алдарсан, мөн аливаа тулгамдсан асуудлын талаар хаана, хэнд хандахаа сайн мэдэхгүй буюу төрийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллийг иргэдэд ойлгомжтой байдлаар хүргэж чаддаггүй байгааг илтгэж байна.

4.5.1 Дуу хоолой

Судалгаанд оролцогчдын 40-өөс дээш хувь нь хувь хүнийхээ зүгээс дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх хэрэгтэй гэж үзэж байна. Харин Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдын хувьд иргэд дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхол бага буюу эзлэх хувь нь орон нутгийн иргэдээс 3.7-3.9 хувиар доогуур байна (Зураг 36).

Зураг 36. Жагсаал, цуглаанд оролцох хэрэгтэй эсэх

22. Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улаанбаатар хотын иргэд дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхол сул байгааг цаашид нарийвчлан судлах шаардлагатай нь харагдаж байна. Үнэлгээг 5, 6 онооны түвшинд нийлбэрээр нь авч үзвэл, Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдын 62.4 хувь, Дархан-Уул аймгийн судалгаанд оролцогчдын 63.8 хувь нь дуу хоолойгоо илэрхийлэх сонирхолтой байна. Харин Дундговь аймгийн иргэд жагсаал цуглаанд оролцох, дуу хоолойгоо илэрхийлэх сонирхол бага байгаа нь хөдөө орон нутагт жагсаал цуглаанаар дамжуулан дуу хоолойгоо илэрхийлэх соёл төдийлөн бүрдээгүй гэж үзэх талтай юм.

Харин нийгмийн сошиал сүлжээгээр иргэд дуу хоолойгоо илэрхийлэх нь жагсаал цуглаанд оролцон дуу хоолойгоо илэрхийлэхээс ялгаатай хэв шинжтэй болох нь судалгааны хариултаас харагдаж байна. Хэдийгээр дуу хоолойгоо илэрхийлдэг гэсэн хариултын хувь өндөр байгаа ч бусад хариултууд харьцангуй жигд тархалттай байна.

Зураг 37. Нийгмийн сүлжээгээр санал бодлоо илэрхийлдэг эсэх

24. Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг.



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Эндээс харахад дуу хоолойгоо илэрхийлдэггүй иргэдээс илэрхийлдэг иргэд нь 6.9 хувь (Дундговь аймаг) болон 12.7 (Улаанбаатар хот) хувиар илүү байна. Энэ нь хөдөө орон нутагт интернэтийн хүртээмж муу байгаагаар хамаарч болзошгүй юм.

Зарим талаар дуу хоолойгоо илэрхийлдэг гэсэн хариултын тархалт нь дундаж оноо руу тэмүүлсэн байдалтай байна. Асуултын хариултыг харьцуулан үзэхэд Дундговь аймагт илүү, Улаанбаатар хот, Дархан-Уул аймагт ойролцоо хувьтай байв. Эдгээр асуултын хариултуудыг нэгтгэхэд дараах байдалтай байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Иргэд дуу хоолойгоо хүргэх байдалтай холбоотой асуултын нэгтгэл

Асуултын дугаар	Асуулт	1 [оноо]	2	3	4	5	6 [оноо]
Дуу хоолой		Хувь					
22	Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай.	6.4	4.4	13.4	14.5	17.3	44.0
24	Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг.	16.4	10.0	16.6	16.6	13.0	27.4

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан


Иргэд “дуу хоолойгоо” хүргэх байдлыг авч үзвэл “Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай” гэсэн асуултын 6 онооны түвшинд 44.0 хувь, “Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг” гэсэн асуулттай санал нийлж, 6 онооны түвшинд хариулсан нь 27.4 хувьтай байна.

4.5.2 Эх орондоо үнэнч байдал

Эх орондоо үнэнч байдлыг тандсан асуултын хариулт нь хоёр туйл руугаа хэлбийсэн төлөвтэй байна. Дундговь аймгаас судалгаанд оролцсон иргэдийн 28.5 хувь нь гадаад улсад амьдрах амар биш гэж хариулсан бол Улаанбаатар хот (11.4%) болон Дархан-Уул аймгийн (15.7%) оролцогчдын хариулт арай өндөр хувьтай байна. Харин Улаанбаатар хотоос судалгаанд оролцсон иргэдийн 45.2 хувь нь гадаадад амьдрах нь амар гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, хотжилт бий болох тусам иргэдийн хандлага өөр болохыг харуулж буйн зэрэгцээ томоохон суурин газрын нэг болох Дархан-Уул аймгаас судалгаанд оролцогчдын 35.1 хувь нь ижил хариулт өгсөн байна (Зураг 38).

Зураг 38. Өндөр хөгжилтэй улсад амьдрах хүсэлтэй эсэх

27. Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Хүн амын гадаад, дотоод шилжилт хөдөлгөөний талаар тандан асуухад шилжилт хөдөлгөөн өндөр гарахаар байгаа нь ажиглагдсан. Үүнийг төрийн эгэх хариуцлагатай холбон тайлбарлах боломжтой юм. Учир нь төрийн байгууллагын эгэх хариуцлага сул байх тусам иргэдийн итгэх итгэл суларч тухайн оршин суугаа газраас, улсаас дайжих хөдөлгөөнд ордог болохыг олон улсын судлаачид хөнддөг (Schmelz, 2002). Үүний нэг жишээ бол оюуны дайжилтын буюу *Brain drain, brain gain, and mobility*³¹-ны тухай асуудал юм. Мөн шилжилт хөдөлгөөнийг бид социологи, нийгэм, эдийн засгийн талаас тайлбарлах боломжтой. Энэхүү асуулт нь улс төрийн эрхийн хэрэгжилт дэх иргэдийн байр суурь болон иргэдийн төсөөллийг тандахад чиглэсэн болно (Зураг 39).

Зураг 39. Гадаад, дотоод шилжилт хөдөлгөөний идэвхжилийн талаар

28. Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар аймаг, хот, эсвэл гадаад улс руу явсан




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

³¹ Bohdan Jalowieckii and Grzegorz Jerzy Gorzelak. Brain drain, brain gain, and mobility: Theories and perspective methods. 2007.

Судалгаанд оролцогчдын 18-21 хувь нь шилжилт хөдөлгөөнд орох магадлал өндөр байна. Мөн Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын 45.9 хувь нь гадаад болон дотоодод очиход хүлээн авах танил, хамаатан садны холбоо хэлхээтэй байна. Энэ нь улс орноо орхих боломж бүрдсэн гэж үзэх боломжийг илтгэхээс гадна хувь хүний зүгээс шилжилт хөдөлгөөн хийх суурь бүрдсэн байгааг илэрхийлж байна. Боломж олдвол шилжин суурьших сонирхолтой эсэхийг асуултаар тодруулахад хот суурин газрын иргэд сонирхол ихтэй болох нь ажиглагдсан. Тухайлбал, судалгаанд хамрагдсан Улаанбаатар хотын иргэдийн 57.7 хувь, Дархан-Уул аймгийн иргэдийн 45.3 хувь нь шилжилт хөдөлгөөн хийх сонирхолтой байна. Харин шилжилт хөдөлгөөн хийх сонирхолгүй иргэдийн хувь Дархан-Уул аймагт 28.8 хувь, Дундговь аймагт 29.2 хувь байгаа нь Улаанбаатар хотоос 20 гаруй хувиар илүү байна (Зураг 40).

Зураг 40. Орхих хүсэлтэй эсэх

29. Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Шилжилт хөдөлгөөнд орох сонирхолтой иргэдийн эзлэх хувь нь Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын хувьд их тал руугаа тэмүүлэх хандлагатай, харин Дархан-Уул, Дундговь аймгийн хувьд хоёр туйл руу тархалттай, төвийн онооны түвшинд нам тархалттай байгаа нь ажиглагдав. Эх орондоо үнэнч байх утга илэрхийлсэн асуултууд нь иргэд дуу хоолойгоо хүргэх, мөн дуу хоолойгоо хүргэх сонирхолгүй буюу идэвхгүй төлөвийг тодорхойлох зорилготой бөгөөд оролцогчдын өгсөн хариултыг нэгтгэхэд дараах төлөвтэй байна (Хүснэгт 17).

Хүснэгт 17. Эх орондоо үнэнч байдал

Асуултын дугаар	Асуулт	1 (оноо)	2	3	4	5	6 (оноо)
Эх орондоо үнэнч байдал							
27	Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар.	17.4	7.5	19.7	17.3	13.5	24.5
28	Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу явсан.	11.4	5.5	17.6	25.2	20.8	19.4
29	Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна.	21.3	5.7	10.7	13.5	13.8	34.9

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Эх орондоо үнэнч байх гэсэн асуултын хариултыг судлаач О.Хиршманы онолын хүрээнд авч үзэхэд “Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар” гэж үзсэн хүмүүсийн хариулт нь 6 онооны түвшинд 24.5 хувьтай, Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу явсан” гэж үзсэн хүмүүсийн хариулт нь 4 онооны түвшинд 25.2 хувьтай, “Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна” гэж хариулсан хүмүүс 6 онооны түвшинд 34.9 хувьтай байна. Судалгаанд оролцогчдын арван хүн тутмын гурав нь боломж олдвол өөр газар, гадаад улсад амьдрах хүсэлтэй байгаа нь эргэн тойрны ихэнх хүмүүс гадаад руу явсан, очвол тэдэнд танил тал байгаа тул өндөр хөгжилтэй улсад амьдрах боломжтойг илэрхийлсэн, шилжилт хөдөлгөөнд орох магадлал өндөр байгааг илтгэж байв.

Судалгааны дан тооллын үр дүнгээс иргэний улс төрийн эрхийн хэрэгжилтийн үнэлгээний зөрүү судалгаанд оролцсон төрийн албан хаагчид болон иргэд, олон нийтийн хооронд ялгаатай эсэхэд шинжилгээг хийж үзэхэд F утга 0.033 гарч байгаа нь бүлэг хооронд ялгаа байхгүйг илтгэж байна (Хүснэгт 18).

Хүснэгт 18. ANOVA шинжилгээ (иргэний улс төрийн эрхийн хэрэгжилт)

Cases	Sum of Squares	df	Mean Square	F	p
Column 2	0.006	1	0.006	0.033	0.86
Residuals	1.514	8	0.189		

Иргэний эрхийн хэрэгжилтийн талаарх ойлголтууд төрийн албан хаагчид болон иргэд, олон нийтийн хооронд ялгаатай байгаа эсэхэд шинжилгээг хийж үзэхэд F утга 2.885 гарч байгаа нь бүлэг хоорондын ялгаа маш бага байгааг илтгэж байв (Хүснэгт 19).

Хүснэгт 19. ANOVA шинжилгээ (иргэний эрхийн хэрэгжилт)

Cases	Sum of Squares	df	Mean Square	F	p
Column 2	0.18	1	0.18	2.885	0.14
Residuals	0.374	6	0.062		

Дархан-Уул аймгаас судалгаанд оролцогч төрийн албан хаагчид болон иргэд, олон нийтийн хооронд иргэний улс төрийн эрхийн хэрэгжилт ялгаатай байгаа эсэхэд шинжилгээ хийж үзэхэд F утга 0.647 гарч байгаа нь эдгээр бүлэгт ялгаа байхгүйг илтгэж байв (Хүснэгт 20).

Хүснэгт 20. ANOVA шинжилгээ (иргэний улс төрийн эрхийн хэрэгжилт, Дархан-Уул аймагт)

Cases	Sum of Squares	df	Mean Square	F	p
Column 2	0.365	1	0.365	0.647	0.444
Residuals	4.508	8	0.563		

Дархан-Уул аймгаас судалгаанд оролцогч төрийн албан хаагчид болон иргэд, олон нийтийн хооронд иргэний эрхийн хэрэгжилт ялгаатай байгаа эсэхэд шинжилгээ хийж үзэхэд F утга 0.829 гарч байгаа нь бүлэг хооронд ялгаа байхгүйг илтгэж байв (Хүснэгт21).

Хүснэгт 21. ANOVA шинжилгээ (иргэний эрхийн хэрэгжилт, Дархан-Уул аймагт)

Cases	Sum of Squares	df	Mean Square	F	p
Column 2	0.143	1	0.143	0.829	0.398
Residuals	1.036	6	0.173		

Дундговь аймгаас судалгаанд оролцогч төрийн албан хаагч болон иргэд, олон нийтийн хооронд иргэний улс төрийн эрхийн хэрэгжилт ялгаатай байгаа эсэхэд шинжилгээ хийж үзэхэд F утга 1.638 гарч байгаа нь эдгээр бүлэгт уг асуудлаар ялгаа байхгүйг илтгэж байв (Хүснэгт 22).

Хүснэгт 22. ANOVA шинжилгээ (Дундговь аймагт)

Cases	Sum of Squares	df	Mean Square	F	p
Column 2	0.031	1	0.031	1.638	0.237
Residuals	0.153	8	0.019		

Мөн ялгаа байгаа эсэхийг иргэний эрхийн хэрэгжилтийн үзүүлэлтэд хийж үзэхэд үзэхэд F утга 2.954 гарч байгаа нь бүлэг хооронд маш бага ялгаа байгааг илтгэж байв (Хүснэгт23).

Хүснэгт 23. ANOVA шинжилгээ (Иргэний эрхийн хэрэгжилт, Дундговь аймагт)

Cases	Sum of Squares	df	Mean Square	F	p
Column 2	0.113	1	0.113	2.954	0.136
Residuals	0.229	6	0.038		

Улаанбаатар хотоос судалгаанд оролцогч төрийн албан хаагчид болон иргэд, олон нийтийн хооронд иргэний улс төрийн эрхийн хэрэгжилт ялгаатай байгаа эсэхэд шинжилгээ хийж үзэхэд F утга 6.579 гарч байгаа нь эдгээр бүлэгт маш бага ялгаа байгааг илтгэж байв (Хүснэгт 24).

Хүснэгт 24. ANOVA шинжилгээ (Улаанбаатар хотод)

Cases	Sum of Squares	df	Mean Square	F	p
Column 2	0.361	1	0.361	6.579	0.033
Residuals	0.439	8	0.055		

Мөн ялгаа байгаа эсэхийг иргэний эрхийн хэрэгжилтийн хувьд хийж үзэхэд үзэхэд F утга 2.54 гарч байгаа нь бүлэг хооронд бараг ялгаа байхгүйг илтгэж байв (Хүснэгт 25).

Хүснэгт 25. ANOVA шинжилгээ (Иргэний эрхийн хэрэгжилт, Улаанбаатар хотод)

Cases	Sum of Squares	df	Mean Square	F	p
Column 2	0.149	1	0.149	2.54	0.162
Residuals	0.351	6	0.058		

Дархан-Уул, Дундговь аймгууд болон Улаанбаатар хотоос судалгаанд оролцогчдын хувьд төрийн албан хаагч болон иргэд, олон нийтийн хооронд иргэний улс төрийн эрхийн хэрэгжилт, иргэний эрхийн хэрэгжилт ялгаатай байгаа эсэхэд шинжилгээ хийж үзэхэд Дархан-Уул аймгийн хувьд бүлэг хооронд ялгаагүй, Дундговь болон Улаанбаатар хотын хувьд бага зэрэг ялгаатай үр дүнгүүд харагдаж байна.

4.6 Үзүүлэлтийн тархалт

4.6.1 Эгэх хариуцлага ба дуу хоолой үзүүлэлтийн тархалт

Дан тооллын үр дүнгийн нэгтгэлээс гадна судалгааны үзэл баримтлалын хүрээтэй уялдуулан тодорхой үзүүлэлтүүдийн, тухайлбал иргэдийн эгэх хариуцлага ба дуу хоолой үзүүлэлт хоорондын уялдааг тодорхойлох зорилгоор “кросстаб” хүснэгтийг хийж үзэхэд дараах үр дүн гарсан.

Судалгаанд оролцогчдын иргэний эгэх хариуцлагын ойлголтыг хувь хүний түвшинд тодруулах зорилготой асуулт болох “*төрийн төлөө оготно боож үхнэ*” гэдэгтэй санал нэгдэхгүй байгаа хүмүүсийн 134 (13%) нь үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн бол, 24 (2.3%) нь үгээ хэлэх шаардлагагүй гэж үзсэн. Хэдийгээр энэхүү тоон утга нь холимог үзэл бодлыг илэрхийлж байгаа боловч тухайн асуулгатай санал нэгдэхгүй ч үгээ хэлэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн хувь нь олонх байв.

Судалгаанд оролцогчдын “*төрийн төлөө оготно боож үхнэ*” гэдэгтэй санал нэгдэж буй 455 (44%) нь үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, иргэний эгэх хариуцлага, иргэдийн дуу хоолой хооронд хүчтэй хамаарал байгааг харуулж байв. Төвийг сахисан үнэлгээ болох 3 онооны түвшинд үнэлгээ өгсөн оролцогчдын 49 (4.7%) нь үгээ хэлэх шаардлагатай, бага 4, 5 онооны түвшинд 42 (4.1%), 33 (3.2%) байгаа нь үгээ хэлэх шаардлагатай гэсэн хандлагатай байна. Нийт онооны тархалтын хувьд судалгаанд оролцогчдын дийлэнх хувь нь 455 (44%) үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн (Хүснэгт 26).

Хүснэгт 26. Эгэх хариуцлага ба дуу хоолой (Асуулт 19, 22)

“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ	Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай.						Нийт
	Шаардлагагүй (1)	2	3	4	5	Шаардлагатай (6)	
Нэгдэхгүй (1)	24 2.3%	6 0.6%	25 2.4%	22 2.1%	35 3.4%	134 13.0%	246 23.8%
2	5 0.5%	14 1.4%	16 1.5%	15 1.5%	13 1.3%	26 2.5%	89 8.6%
3	6 0.6%	8 0.8%	49 4.7%	26 2.5%	25 2.4%	42 4.1%	156 15.1%
4	7 0.7%	8 0.8%	14 1.4%	42 4.1%	41 4.0%	48 4.6%	160 15.5%
5	3 0.3%	5 0.5%	7 0.7%	19 1.8%	33 3.2%	35 3.4%	102 9.9%
Нэгдэнэ (6)	21 2.0%	4 0.4%	28 2.7%	26 2.5%	32 3.1%	170 16.4%	281 27.2%
Нийт	66 6.4%	45 4.4%	139 13.4%	150 14.5%	179 17.3%	455 44.0%	1034 100.0%

Эх сурвалж: Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын дунд “*төрийн төлөө оготно боож үхнэ*” гэдэгтэй санал нэгдэхгүй байгаа 81 (7.8%) нь “*Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг*” гэж үзсэн бол 22 (5.8%) нь эсэргүүцлээ илэрхийлдэггүй гэж хариулсан байна.

Төвийг сахисан үнэлгээ (3, 4 онооны түвшинд) өгсөн оролцогчдын 60 (5.8%) нь үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн байна. Судалгаанд оролцогчдын дунд “төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэж буй 283 (27.4%) нь эсэргүүцлээ илэрхийлдэг байна. Харин тэдгээрийн 49 (4.7%) нь санал нэгдэж байгаа хэдий ч эсэргүүцлээ илэрхийлдэггүй байна. Өөрөөр хэлбэл, санал нэгдэж байгаа боловч үзэл бодлоо илэрхийлж эсэргүүцэл илэрхийлдэггүй байна. Төвийг сахисан оролцогчдын хувьд 4 онооны түвшинд хариулт өгсөн 47 (4.5%), 5 онооны түвшинд 24 (2.3%) байгаа нь тэд нийгмийн сүлжээнд санал бодлоо идэвхтэй илэрхийлэх хандлагатай байна (Хүснэгт 27).

Хүснэгт 27. Эгэх хариуцлага ба дуу хоолой (Асуулт 19, 24)

“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ	Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) чанал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг.						Нийт
	Шаардлага- гүй (1)	2	3	4	5	Шаардлага- тай (6)	
Нэгдэхгүй (1)	4 1.05%	4 1.05%	11 2.90%	5 1.3%	12 3.10%	42 11%	78 20.4%
2	1 0.3%	7 1.8%	6 1.6%	7 1.8%	6 1.6%	9 2.4%	36 9.4%
3	1 0.3%	1 0.3%	16 4.2%	10 2.6%	8 2.1%	16 4.2%	52 13.6%
4	2 0.5%	1 0.3%	3 0.8%	17 4.5%	16 4.2%	20 5.2%	59 15.4%
5	1 0.3%	4 1.0%	0 0.0%	9 2.4%	14 3.7%	15 3.9%	43 11.3%
Нэгдэнэ (6)	5 1.3%	3 0.8%	12 3.1%	8 2.1%	14 3.7%	72 18.8%	114 29.8%
Нийт	14 3.7%	20 5.2%	48 12.6%	56 14.7%	70 18.3%	174 45.5%	382 100.0%

Эх сурвалж: Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Эгэх хариуцлага болон иргэдийн дуу хоолой хоёрын огтлолцол болсон эдгээр асуултын уялдааг Дархан-Уул, Дундговь аймаг болон Улаанбаатар хотын оролцогчдоор ялган, тус тусад нь шинжилгээ хийв. Тухайлбал, иргэний эгэх хариуцлагыг ухамсарласан байдал болон иргэдийн дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх байдлыг Дархан-Уул аймгийн хувьд авч үзвэл дараах үр дүн харагдаж байна (Хүснэгт 28).

Хүснэгт 28. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Дархан-Уул аймаг (Асуулт 19, 22)

“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ	Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай.						Нийт
	Шаардлага- гүй (1)	2	3	4	5	Шаардлага- тай (6)	
Нэгдэхгүй (1)	4 1.05%	4 1.05%	11 2.90%	5 1.3%	12 3.10%	42 11%	78 20.4%
2	1 0.3%	7 1.8%	6 1.6%	7 1.8%	6 1.6%	9 2.4%	36 9.4%
3	1 0.3%	1 0.3%	16 4.2%	10 2.6%	8 2.1%	16 4.2%	52 13.6%
4	2 0.5%	1 0.3%	3 0.8%	17 4.5%	16 4.2%	20 5.2%	59 15.4%
5	1 0.3%	4 1.0%	0 0.0%	9 2.4%	14 3.7%	15 3.9%	43 11.3%
Нэгдэнэ (6)	5 1.3%	3 0.8%	12 3.1%	8 2.1%	14 3.7%	72 18.8%	114 29.8%
Нийт	14 3.7%	20 5.2%	48 12.6%	56 14.7%	70 18.3%	174 45.5%	382 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Дархан-Уул аймгийн судалгаанд оролцогчдын 4.2 хувь нь иргэний эгэх хариуцлагыг бүрэн ухамсарлаагүй байгаа учир дуу хоолойгоо хүргэх шаардлагагүй буюу цөхөрсөн төлөвтэй; иргэний эгэх хариуцлага муу байгаа хэдий ч дуу хоолойгоо илэрхийлэх хүсэлтэй иргэд 3.4 хувь; иргэний эгэх хариуцлагыг ухамсарласан байгаа ч өнөөгийн нөхцөлд дуу хоолойгоо илэрхийлэх шаардлагагүй гэж үзсэн буюу идэвхгүй төлөвт 18.1 хувь; цагийн аясыг даган хувьсах боломжтой буюу төвийг сахисан бүлэг 12.0 хувь; иргэний эгэх хариуцлагыг ухамсарласан, дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх хүсэлтэй бүлэг 30.1 хувийг эзэлж байв (Хүснэгт 29).

Хүснэгт 29. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Дархан-Уул аймаг (Асуулт 19, 24)

“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ	Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг						Нийт
	Эсэргүүцлээ илэрхийл- дэггүй (1)	2	3	4	5	Эсэргүүцлээ илэрхийл- дэг (6)	
Нэгдэхгүй (1)	22 5.8%	3 0.8%	11 2.9%	7 1.8%	6 1.6%	29 7.6%	78 20.4%
2	6 1.6%	10 2.6%	4 1.0%	6 1.6%	6 1.6%	4 1.0%	36 9.4%
3	3 0.8%	5 1.3%	24 6.3%	9 2.4%	4 1.0%	7 1.8%	52 13.6%
4	10 2.6%	12 3.1%	4 1.0%	16 4.2%	7 1.8%	10 2.6%	59 15.4%

5	3 0.8%	6 1.6%	7 1.8%	12 3.1%	8 2.1%	7 1.8%	43 11.3%
Нэгдэнэ (6)	21 5.5%	7 1.8%	14 3.7%	10 2.6%	11 2.9%	51 13.4%	114 29.8%
Нийт	65 17.0%	43 11.3%	64 16.8%	60 15.7%	42 11.0%	108 28.3%	382 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Иргэн эгэх хариуцлагаа ухамсарласан, төрийн зүгээс хэрэгжүүлж байгаа буруу бодлогыг эсэргүүцэн дуу хоолойгоо илэрхийлдэг эсэх талаар харьцуулалт хийж үзэхэд эгэх хариуцлагаа ухамсарлаагүй, дуу хоолойгоо ч хүргэх шаардлагагүй гэж үзсэн буюу цөхөрсөн төлөв байдалтай иргэд 10.7 хувь; иргэний эгэх хариуцлагыг ухамсарлаагүй ч дуу хоолойгоо илэрхийлэх хүсэлтэй иргэд 9.7 хувь; иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан байгаа хэдий ч өнөөгийн удирдлагуудад дуу хоолойгоо илэрхийлэх шаардлагагүй гэж үзсэн буюу цөхөрсөн төлөв байдалтай 11.8 хувь; цагийн аясыг даган хувьсах боломжтой буюу төвийг сахисан бүлэг 13.9 хувь; иргэний хариуцлагаа ч ухамсарласан, мөн дуу хоолойгоо ч идэвхтэй илэрхийлэх хүсэлтэй бүлэг 20.2 хувийг эзэлж байв. Тухайлбал, иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан байдал болон дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх байдлыг Дундговь аймгийн хувьд авч үзвэл дараах үр дүн гарав (Хүснэгт 30).

Хүснэгт 30. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Дундговь аймаг (Асуулт 19, 22)

"Төрийн төлөө оготно боож үхнэ" гэдэгтэй санал нэгдэнэ	Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай.						Нийт
	Шаардлага- гүй (1)	2	3	4	5	Шаардлага- тай (6)	
Нэгдэхгүй (1)	9 3.4%	2 0.7%	3 1.1%	5 1.9%	4 1.5%	37 13.9%	60 22.5%
2	0 0.0%	1 0.4%	3 1.1%	2 0.7%	2 0.7%	5 1.9%	13 4.9%
3	3 1.1%	1 0.4%	23 8.6%	5 1.9%	8 3.0%	11 4.1%	51 19.1%
4	4 1.5%	3 1.1%	4 1.5%	12 4.5%	7 2.6%	9 3.4%	39 14.6%
5	1 0.4%	1 0.4%	2 0.7%	7 2.6%	3 1.1%	7 2.6%	21 7.9%
Нэгдэнэ (6)	9 3.4%	0 0.0%	5 1.9%	12 4.5%	5 1.9%	52 19.5%	83 31.1%
Нийт	26 9.7%	8 3.0%	40 15.0%	43 16.1%	29 10.9%	121 45.3%	267 100.0%

Эх сурвалж: Судалгааны боловсруулсан үр дүн

Дундговь аймгийн судалгаанд оролцогчдын 4.5 хувь нь иргэний эгэх хариуцлагаа ухамсарлаагүй учир дуу хоолойгоо хүргэх шаардлагагүй гэж үзсэн буюу цөхөрсөн төлөвтэй; иргэний эгэх хариуцлагаа ухамсарлаагүй ч дуу хоолойгоо илэрхийлэх хүсэлтэй иргэд 4.1 хувь; иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан хэдий ч өнөөгийн удирдлагуудын үед дуу хоолойгоо илэрхийлэх шаардлагагүй гэж үзсэн буюу идэвхгүй төлөвт 18.0 хувь; цагийн аясыг даган хувьсах боломжтой буюу төвийг сахисан бүлэгт 16.5 хувь; иргэний эгэх хариуцлагаа ч ухамсарласан дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх хүсэлтэй бүлэг 25.1 хувийг тус тус эзэлж байв (Зураг 31).

Хүснэгт 31. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Дундговь аймаг /Асуулт 19, 24/

“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ	Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг						Нийт
	Эсэргүүцлээ илэрхийл- дэггүй (1)	2	3	4	5	Эсэргүүцлээ илэрхийл- дэг (6)	
Нэгдэхгүй (1)	19 7.1%	2 0.7%	4 1.5%	8 3.0%	5 1.9%	22 8.2%	60 22.5%
2	4 1.5%	1 0.4%	2 0.7%	3 1.1%	2 0.7%	1 0.4%	13 4.9%
3	8 3.0%	2 0.7%	21 7.9%	10 3.7%	2 0.7%	8 3.0%	51 19.1%
4	5 1.9%	4 1.5%	9 3.4%	14 5.2%	4 1.5%	3 1.1%	39 14.6%
5	1 0.4%	2 0.7%	3 1.1%	5 1.9%	5 1.9%	5 1.9%	21 7.9%
Нэгдэнэ (6)	20 7.5%	1 0.4%	5 1.9%	13 4.9%	5 1.9%	39 14.6%	83 31.1%
Нийт	57 21.3%	12 4.5%	44 16.5%	53 19.9%	23 8.6%	78 29.2%	267 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Дараагийн харьцуулалтыг Дундговь аймгийн судалгаанд оролцогчдын хувьд хийж үзвэл, эгэх хариуцлагаа ухамсарлаагүй тул дуу хоолойгоо ч хүргэх шаардлагагүй гэж үзсэн буюу цөхөрсөн төлөвтэй иргэд 9.7 хувь; иргэний эгэх хариуцлага ухамсарлаагүй хэдий ч дуу хоолойгоо илэрхийлэх хүсэлтэй иргэд 9.0 хувь; хариуцлагаа ухамсарласан хэдий ч өнөөгийн удирдлагуудын үед дуу хоолойгоо илэрхийлэх шаардлагагүй гэж үзсэн буюу идэвхгүй төлөвт 11.2 хувь; цагийн аясыг даган хувьсах боломжтой буюу төвийг сахисан бүлэгт 20.2 хувь; иргэний эгэх хариуцлагаа ч ухамсарласан дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх хүсэлтэй бүлэг 20.2 хувийг тус тус эзэлж байв.

Иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан байдал болон дуу хоолойгоо сошиал орчинд идэвхтэй илэрхийлдэг байдлыг Улаанбаатар хотын хувьд харьцуулан үзвэл дараах үр дүн харагдаж байна (Хүснэгт 31).

Хүснэгт 32. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Улаанбаатар хот (Асуулт 19, 22)

"Төрийн төлөө оготно боож үхнэ" гэдэгтэй санал нэгдэнэ	Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай.						Нийт
	Шаардлага- гүй (1)	2	3	4	5	Шаардлага- тай (6)	
Нэгдэхгүй (1)	11 2.9%	0 0.0%	11 2.9%	12 3.1%	19 4.9%	55 14.3%	108 28.1%
2	4 1.0%	6 1.6%	7 1.8%	6 1.6%	5 1.3%	12 3.1%	40 10.4%
3	2 0.5%	6 1.6%	10 2.6%	11 2.9%	9 2.3%	15 3.9%	53 13.8%
4	1 0.3%	4 1.0%	7 1.8%	13 3.4%	18 4.7%	19 4.9%	62 16.1%
5	1 0.3%	0 0.0%	5 1.3%	3 0.8%	16 4.2%	13 3.4%	38 9.9%
Нэгдэнэ (6)	7 1.8%	1 0.3%	11 2.9%	6 1.6%	13 3.4%	46 11.9%	84 21.8%
Нийт	26 6.8%	17 4.4%	51 13.2%	51 13.2%	80 20.8%	160 41.6%	385 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улаанбаатар хотын судалгаанд оролцогчдын 5.5 хувь нь иргэний эгэх хариуцлагаа ухамсарлаагүй учир дуу хоолойгоо хүргэх шаардлагагүй гэж үзсэн буюу цөхөрсөн төлөвтэй; иргэний эгэх хариуцлагаа ухамсарлаагүй хэдий ч дуу хоолойгоо илэрхийлэх хүсэлтэй иргэд 2.3 хувь; иргэний эгэх хариуцлага ухамсарласан хэдий ч өнөөгийн удирдлагуудын үед дуу хоолойгоо илэрхийлэх шаардлагагүй гэж үзсэн буюу идэвхгүй төлөвт 23.6 хувь; цагийн аясыг даган хувьсах боломжтой буюу төвийг сахисан бүлэгт 10.6 хувь; иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан, дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх хүсэлтэй бүлэг 22.9 хувь байв (Хүснэгт 33).

Хүснэгт 33. Эгэх хариуцлага ба дуу хоолой, Улаанбаатар хот (Асуулт 19, 24)

“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ	Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг						Нийт
	Эсэргүүцлээ илэрхийл- дэггүй (1)	2	3	4	5	Эсэргүүцлээ илэрхийл- дэг (6)	
Нэгдэхгүй (1)	19 4.9%	6 1.6%	14 3.6%	23 6.0%	16 4.2%	30 7.8%	108 28.1%
2	7 1.8%	6 1.6%	7 1.8%	1 0.3%	10 2.6%	9 2.3%	40 10.4%
3	6 1.6%	15 3.9%	8 2.1%	7 1.8%	7 1.8%	10 2.6%	53 13.8%
4	6 1.6%	9 2.3%	9 2.3%	17 4.4%	18 4.7%	3 0.8%	62 16.1%
5	2 0.5%	6 1.6%	4 1.0%	6 1.6%	11 2.9%	9 2.3%	38 9.9%
Нэгдэнэ (6)	8 2.1%	6 1.6%	22 5.7%	5 1.3%	7 1.8%	36 9.4%	84 21.8%
Нийт	48 12.5%	48 12.5%	64 16.6%	59 15.3%	69 17.9%	97 25.2%	385 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Иргэдийн эгэх хариуцлага болон дуу хоолойгоо илэрхийлэх байдалд хийсэн харьцуулалтаас дараах дүгнэлт гарч байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 28.3 хувь нь эгэх хариуцлагаа ухамсарлаагүй бөгөөд энэ шалтгаанаар дуу хоолойгоо хүргэх шаардлагагүй гэж үздэг буюу цөхөрсөн төлөвтэй байна. Харин 17.5 хувь нь эгэх хариуцлагаа ухамсарлаагүй хэдий ч дуу хоолойгоо илэрхийлэх сонирхолтой байдаг. Мөн 51 хувь нь иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан хэдий ч өнөөгийн удирдлагын нөхцөлд дуу хоолойгоо илэрхийлэх нь үр дүнгүй гэж үзсэн, идэвхгүй байр суурьтай байна. 34.3 хувь нь тодорхой байр суурьгүй, цагийн аясыг даган хувьсах магадлалтай буюу төвийг сахисан бүлэгт хамаарч байна. Харин 57.8 хувь нь иргэний эгэх хариуцлагаа ухамсарлаж, нийгмийн асуудлаар идэвхтэй дуу хоолойгоо илэрхийлэх хүсэлтэй байгаа нь ажиглагдаж байв.

4.6.2 Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолойны тархалт

Судалгаанд оролцогчдын дийлэнх “нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай” гэж үзсэн 455 (44%) оролцогчдын 153 (14.8%) нь “өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар” гэж үзсэн. Харин “нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагагүй” гэж үзсэн 66 (6.4%)

оролцогчдын 28 (2.7%) нь “өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас хэцүү” гэж үзсэн байна (Хүснэгт 34).

Хүснэгт 34. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 27, 22)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай	Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар						Нийт
	Амаргүй (1)	2	3	4	5	Амар (6)	
Үгээ хэлэх шаардлагагүй (1)	28 2.7%	7 0.7%	7 0.7%	9 0.9%	3 0.3%	12 1.2%	66 6.4%
2	3 0.3%	7 0.7%	13 1.3%	6 0.6%	9 0.9%	7 0.7%	45 4.4%
3	8 0.8%	13 1.3%	58 5.6%	25 2.4%	12 1.2%	23 2.2%	139 13.4%
4	19 1.8%	10 1.0%	35 3.4%	39 3.8%	25 2.4%	22 2.1%	150 14.5%
5	14 1.4%	22 2.1%	28 2.7%	37 3.6%	42 4.1%	36 3.5%	179 17.3%
Үгээ хэлэх шаардлагатай /6/	108 10.4%	19 1.8%	63 6.1%	63 6.1%	49 4.7%	153 14.8%	455 44.0%
Нийт	180 17.4%	78 7.5%	204 19.7%	179 17.3%	140 13.5%	253 24.5%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь “Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар” гэж үзсэн 253 (24.5%) оролцогчдын 113 (39.9%) нь “Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг” гэж үзсэн. Харин “Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдрах нь амаргүй” гэж үзсэн 180 (17.4%) оролцогчийн 72 (25.4%) нь “Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг” гэж үзсэн бол эсэргүүцлээ илэрхийлдэггүй гэж үзсэн 52 (30.6 хувь) байна. Эндээс иргэд дуу хоолойгоо илэрхийлэх байдал нь зөвхөн нийгмийн сүлжээгээр илэрдэггүй болохыг харуулж байв (Хүснэгт 35).

Хүснэгт 35. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 27, 24)

Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар	Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг						Нийт
	Эсэргүүцлээ илэрхийл- дэггүй (1)	2	3	4	5	Эсэргүүцлээ илэрхийл- дэг (6)	
Амаргүй (1)	52 30.6%	10 9.7%	12 7.0%	20 11.6%	14 10.4%	72 25.4%	180 17.4%
2	19 11.2%	11 10.7%	10 5.8%	10 5.8%	14 10.4%	14 4.9%	78 7.5%
3	25 14.7%	26 25.2%	70 40.7%	36 20.9%	19 14.2%	28 9.9%	204 19.7%
4	15 8.8%	17 16.5%	28 16.3%	59 34.3%	28 20.9%	32 11.3%	179 17.3%
5	19 11.2%	20 19.4%	17 9.9%	25 14.5%	35 26.1%	24 8.5%	140 13.5%
Амар (6)	40 23.5%	19 18.4%	35 20.3%	22 12.8%	24 17.9%	113 39.9%	253 24.5%
Нийт	180 17.4%	78 7.5%	204 19.7%	179 17.3%	140 13.5%	253 24.5%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь “нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай” гэж үзсэн 455 (44%) оролцогчийн 130 (12.6%) нь “өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар” гэж үзсэн. Харин “нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагагүй” гэж үзсэн 66 (6.4%) оролцогчийн 23 (2.2%) нь “өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас амаргүй” гэж үзсэн байна (Хүснэгт 36).

Хүснэгт 36. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 28, 22)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай	Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу явсан						Нийт
	Яваагүй (1)	2	3	4	5	Бүгд явсан (6)	
Үгээ хэлэх шаардлагагүй (1)	23 2.2%	3 0.3%	8 0.8%	13 1.3%	7 0.7%	12 1.2%	66 6.4%
2	4 0.4%	4 0.4%	10 1.0%	11 1.1%	11 1.1%	5 0.5%	45 4.4%
3	7 0.7%	5 0.5%	52 5.0%	34 3.3%	25 2.4%	16 1.5%	139 13.4%
4	10 1.0%	11 1.1%	21 2.0%	56 5.4%	35 3.4%	17 1.6%	150 14.5%
5	15 1.5%	8 0.8%	27 2.6%	55 5.3%	53 5.1%	21 2.0%	179 17.3%

Үгээ хэлэх шаардлагатай (6)	59 5.7%	26 2.5%	64 6.2%	92 8.9%	84 8.1%	130 12.6%	455 44.0%
Нийт	118 11.4%	57 5.5%	182 17.6%	261 25.2%	215 20.8%	201 19.4%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын дийлэнх “Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу явсан” гэж үзсэн 201 (19.4%) оролцогчийн 88 (31.1%) нь “Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг” гэж үзсэн. Харин “Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу яваагүй” гэж үзсэн 118 (11.4%) оролцогчийн 42 (24.7%) нь “эсэргүүцлээ илэрхийлдэггүй” гэж үзсэн бол 41 (14.5%) “эсэргүүцлээ илэрхийлдэг” гэж үзсэн байна.

Гадаадад амьдрах сонголт хийсэн хүмүүсийн эсэргүүцлээ илэрхийлэх байдал өндөр байгаа нь бусад улс оронтой эх орноо харьцуулах боломжтой болсных гэж үзэж болохоор юм. Нөгөө талаар “орхин яваагүй” хүмүүсийн дунд эсэргүүцлээ илэрхийлэх байдал хоёр туйлд хуваагдаж байгаа нь шилжилт хөдөлгөөн хийхээс үл хамааран эсэргүүцлээ илэрхийлэх байдал нь харилцан адилгүй байх хандлагатай байв (Хүснэгт 37).

Хүснэгт 37. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 28, 24)

Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу явсан	Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг						Нийт
	Эсэргүүцлээ илэрхийлдэггүй (1)	2	3	4	5	Эсэргүүцлээ илэрхийлдэг (6)	
Яваагүй (1)	42 24.7%	7 6.8%	11 6.4%	12 7.0%	5 3.7%	41 14.5%	118 11.4%
2	4 2.4%	8 7.8%	9 5.2%	10 5.8%	12 9.0%	14 4.9%	57 5.5%
3	24 14.1%	21 20.4%	46 26.7%	33 19.2%	18 13.4%	40 14.1%	182 17.6%
4	31 18.2%	25 24.3%	48 27.9%	64 37.2%	40 29.9%	53 18.7%	261 25.2%
5	33 19.4%	28 27.2%	38 22.1%	33 19.2%	36 26.9%	47 16.6%	215 20.8%
Бүгд явсан (6)	36 21.2%	14 13.6%	20 11.6%	20 11.6%	23 17.2%	88 31.1%	201 19.4%
Нийт	170 16.4%	103 10.0%	172 16.6%	172 16.6%	134 13.0%	283 27.4%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь “нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай” гэж үзсэн 455 (44%) оролцогчийн 202 (19.5%) нь “Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна” гэж үзсэн. Харин “нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагагүй” гэж үзсэн 66 (6.4%) оролцогчийн 25 (2.4%) нь “Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна” гэж хариулсан байна (Хүснэгт 38).

Хүснэгт 38. Эх орондоо үнэн байдал ба дуу хоолой (Асуулт 29, 22)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай	Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна						Нийт
	Хүсэлгүй (1)	2	3	4	5	Хүсэлтэй байна (6)	
Үгээ хэлэх шаардлагагүй (1)	25 2.4%	5 0.5%	5 0.5%	7 0.7%	4 0.4%	20 1.9%	66 6.4%
2	8 0.8%	4 0.4%	10 1.0%	6 0.6%	5 0.5%	12 1.2%	45 4.4%
3	25 2.4%	8 0.8%	32 3.1%	23 2.2%	17 1.6%	34 3.3%	139 13.4%
4	25 2.4%	14 1.4%	15 1.5%	29 2.8%	31 3.0%	36 3.5%	150 14.5%
5	28 2.7%	10 1.0%	18 1.7%	30 2.9%	36 3.5%	57 5.5%	179 17.3%
Үгээ хэлэх шаардлагатай (6)	109 10.5%	18 1.7%	31 3.0%	45 4.4%	50 4.8%	202 19.5%	455 44.0%
Нийт	220 21.3%	59 5.7%	111 10.7%	140 13.5%	143 13.8%	361 34.9%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын дийлэнх “Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй” гэж үзсэн 361 (34.9%) оролцогчийн 130 (45.9%) нь “Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг” гэж үзсэн. Харин “Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлгүй” гэж үзсэн 220 (21.3%) оролцогчийн 78 (27.6%) нь “эсэргүүцлээ илэрхийлдэг” гэж хариулсан. Эндээс дүгнэлт хийхэд иргэд өөр газар шилжиж амьдрах хүсэлтэй эсэхээс үл хамааран “эсэргүүцлээ илэрхийлэх” хандлагатай байна (Хүснэгт 39).

Хүснэгт 39. Эх орондоо үнэнч байдал ба дуу хоолой (Асуулт 29, 24)

Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна	Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг						Нийт
	Эсэргүүцлээ илэрхийлдэггүй (1)	2	3	4	5	Эсэргүүцлээ илэрхийлдэг (6)	
Хүсэлгүй (1)	55 32.4%	15 14.6%	22 12.8%	34 19.8%	16 11.9%	78 27.6%	220 21.3%
2	10 5.9%	7 6.8%	18 10.5%	9 5.2%	4 3.0%	11 3.9%	59 5.7%
3	11 6.5%	16 15.5%	39 22.7%	20 11.6%	12 9.0%	13 4.6%	111 10.7%
4	14 8.2%	15 14.6%	25 14.5%	36 20.9%	27 20.1%	23 8.1%	140 13.5%
5	10 5.9%	20 19.4%	26 15.1%	22 12.8%	37 27.6%	28 9.9%	143 13.8%
Хүсэлтэй (6)	70 41.2%	30 29.1%	42 24.4%	51 29.7%	38 28.4%	130 45.9%	361 34.9%
Нийт	170 16.4%	103 10.0%	172 16.6%	172 16.6%	134 13.0%	283 27.4%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

4.6.3 Дуу хоолой ба эх орондоо үнэнч байдлын тархалт

Судалгаанд оролцогчдын 66 (6.4%) нь “Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагагүй” гэж үзсэн ба эдгээрээс 28 (2.7%) нь “өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амаргүй” гэж үзсэн. “Үгээ хэлэх шаардлагатай” гэж үзсэн 455 (44%) хүнээс 153 (14.8%) нь “Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар” гэж үзсэн бол 108 (10.4%) нь “амаргүй” гэж үзсэн. Үгээ хэлэх шаардлага дунд түвшинд буюу 3 онооны түвшинд үнэлсэн нь 58 (5.6%), 4 онооны түвшинд 35 (3.4%), 5 онооны түвшинд үнэлсэн нь 42 (4.1%) буюу дийлэнх хувийг эзэлж байна. Нийт хариултын тархалтын хувьд үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн 455 (44%), “Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар” гэж үзсэн 253 (24.5%), “хэцүү” гэж үзсэн 180 (17.4%) оролцогч байв (Хүснэгт 40).

Хүснэгт 40. Дуу хоолой ба эх орондоо үнэнч байдал (Асуулт 22, 27)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай	Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар						Нийт
	Амаргүй (1)	2	3	4	5	Амар (6)	
Үгээ хэлэх шаардлагагүй (1)	28 2.7%	7 0.7%	7 0.7%	9 0.9%	3 0.3%	12 1.2%	66 6.4%
2	3 0.3%	7 0.7%	13 1.3%	6 0.6%	9 0.9%	7 0.7%	45 4.4%
3	8 0.8%	13 1.3%	58 5.6%	25 2.4%	12 1.2%	23 2.2%	139 13.4%
4	19 1.8%	10 1.0%	35 3.4%	39 3.8%	25 2.4%	22 2.1%	150 14.5%
5	14 1.4%	22 2.1%	28 2.7%	37 3.6%	42 4.1%	36 3.5%	179 17.3%
Үгээ хэлэх шаардлагатай (6)	108 10.4%	19 1.8%	63 6.1%	63 6.1%	49 4.7%	153 14.8%	455 44.0%
Нийт	180 17.4%	78 7.5%	204 19.7%	179 17.3%	140 13.5%	253 24.5%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын 66 (6.4%) нь “Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагагүй” гэж үзсэн ба эдгээрээс 23 (2.2%) нь “Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу яваагүй”, 12 (1.2%) нь явсан гэж хариулсан. “Үгээ хэлэх шаардлагатай” гэж үзсэн 455 (44%) оролцогчийн 130 (12.6%) нь “бүгд явсан” бол 59 (5.7%) “яваагүй” гэж хариулсан. Нийт хариултын тархалтын хувьд 261 (25.2%) нь төвийг сахисан байр суурьтай байв (Хүснэгт 41).

Хүснэгт 41. Дуу хоолой ба эх орондоо үнэнч байдал (Асуулт 22, 28)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай	Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу явсан						Нийт
	Яваагүй (1)	2	3	4	5	Бүгд явсан (6)	
Үгээ хэлэх шаардлагагүй (1)	23 2.2%	3 0.3%	8 0.8%	13 1.3%	7 0.7%	12 1.2%	66 6.4%
2	4 0.4%	4 0.4%	10 1.0%	11 1.1%	11 1.1%	5 0.5%	45 4.4%
3	7 0.7%	5 0.5%	52 5.0%	34 3.3%	25 2.4%	16 1.5%	139 13.4%
4	10 1.0%	11 1.1%	21 2.0%	56 5.4%	35 3.4%	17 1.6%	150 14.5%

5	15 1.5%	8 .8%	27 2.6%	55 5.3%	53 5.1%	21 2.0%	179 17.3%
Үгээ хэлэх шаардлагатай /6/	59 5.7%	26 2.5%	64 6.2%	92 8.9%	84 8.1%	130 12.6%	455 44.0%
Нийт	118 11.4%	57 5.5%	182 17.6%	261 25.2%	215 20.8%	201 19.4%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын “Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагагүй” гэж үзсэн 66 (6.4%) нь “Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлгүй” гэж хариулсан нь 25 (2.4%), “хүсэлтэй” байгаа гэж хариулсан нь 20 (1.9%) оролцогч байв. Харин “үгээ хэлэх шаардлагатай” гэж үзсэн 202 (19.5%) нь “Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна” гэж хариулсан. Нийт тархалтын түвшинд “үгээ хэлэх шаардлагатай” гэж үзсэн 202 (19.5%) оролцогч байгаа бол “үгээ хэлэх шаардлагагүй болон хүсэлгүй” гэсэн хариултыг 25 (2.4%) нь өгчээ (Хүснэгт 42).

Хүснэгт 42. Дуу хоолой ба эх орондоо үнэнч байдал (Асуулт 22, 29)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай	Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна						Нийт
	Хүсэлгүй (1)	2	3	4	5	Хүсэлтэй байна (6)	
Үгээ хэлэх шаардлагагүй (1)	25 2.4%	5 0.5%	5 0.5%	7 0.7%	4 0.4%	20 1.9%	66 6.4%
2	8 0.8%	4 0.4%	10 1.0%	6 0.6%	5 0.5%	12 1.2%	45 4.4%
3	25 2.4%	8 0.8%	32 3.1%	23 2.2%	17 1.6%	34 3.3%	139 13.4%
4	25 2.4%	14 1.4%	15 1.5%	29 2.8%	31 3.0%	36 3.5%	150 14.5%
5	28 2.7%	10 1.0%	18 1.7%	30 2.9%	36 3.5%	57 5.5%	179 17.3%
Үгээ хэлэх шаардлагатай (6)	109 10.5%	18 1.7%	31 3.0%	45 4.4%	50 4.8%	202 19.5%	455 44.0%
Нийт	220 21.3%	59 5.7%	111 10.7%	140 13.5%	143 13.8%	361 34.9%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Эдгээр тархалтын тоон үр дүнг нэгтгэн дүгнэхэд иргэд дуу хоолойгоо ч илэрхийлэх сонирхолгүй, өөр тийш шилжин амьдрах ч бодолгүй иргэд 4.1 хувь, дуу хоолойгоо илэрхийлэх хүсэлгүй хэдий ч өөр тийш шилжин амьдрах сонирхолтой 4.0%, дуу хоолойгоо илэрхийлэх зайлшгүй

шаардлагатай гэж үзсэн, гэхдээ би хаашаа ч явахгүй эндээ амьдарна гэж боддог 15.9 хувь, дуу хоолойгоо илэрхийлэн жагсаал цуглаанд оролцох хүсэлтэй, гэхдээ боломж гарвал өөр аймаг, хот, эсвэл гадагшаа явж амьдрах хүсэлтэй хүн нийт судалгаанд оролцогчдын 1/3 хувийг эзэлж байв.

4.7 Хамаарлын шинжилгээний үр дүн

4.7.1 Корреляцийн шинжилгээ

Судалгаанд оролцогчдын “Улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт” болон “дуу хоолой-1” (асуулт 22) гэсэн үзүүлэлт хоорондын Пирсоны корреляцийн коэффициент 0.080, “дуу хоолой-2” (асуулт 24) хоорондын хамаарлын коэффициент 0.126 байгаа нь эдгээр үзүүлэлт хоорондын хамаарал сул байгааг илтгэж байна Харин корреляцийн коэффициентын ач холбогдол $P(\text{sig})$ утга 0.000 байгаа нь хувьсагч хооронд статистикийн ач холбогдолтой байна. Иргэний эрхийн ойлголт, хэрэгжилт болон дуу хоолойг төлөөлөх хувьсагчдын хамаарал 0.257, 0.257 байгаа нь хувьсагчид хооронд сул хамааралтайг харуулж байгаа бөгөөд $P(\text{sig})$ утга 0.000 байгаа нь статистикийн ач холбогдолтой байгааг харуулж байна. Эндээс улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт нь дуу хоолойноос гадна өөр бусад хүчин зүйлүүдэд илүү нөлөөлж магадгүй. Харин дуу хоолойгоо илэрхийлэхийг дэмжих нь иргэний эрхээ ойлгох, хэрэгжүүлэхэд илүү чухал үүрэгтэй байж болохыг харуулж байна.

Хүснэгт 43. Улс төрийн эрхийн ойлголт/хэрэгжилт, иргэний эрхийн ойлголт/хэрэгжилт ба дуу хоолой

Хүчин зүйлсийн нэр	Correlations	Дуу хоолой-1 (Асуулт 22)	Дуу хоолой-2 (Асуулт 24)
Улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт	Correlation Coefficient Sig. (2-tailed) N	0.080** 0.001 1034	0.126** 0.000 1034
Иргэний эрхийн хэрэгжилт	Correlation Coefficient Sig. (2-tailed) N	0.257** 0.000 1034	0.257** 0.000 1034

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

4.7.2 Харилцан хамаарлын шинжилгээ

Улс төрийн эрхийн ойлголт дуу хоолой илэрхийлэх сонирхлын хамаарал

Улс төрийн эрхээ ойлгосон байдал дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхлыг харьцуулан авч үзвэл улс төрийн эрхээ ч ойлгоогүй, дуу хоолойгоо ч илэрхийлэхийг хүсдэггүй бүлэг буюу идэвхгүй бүлэг (4%), улс төрийн эрхээ ойлгосон боловч дуу хоолойгоо илэрхийлэх

сонирхолгүй залхсан [3%], улс төрийн эрхийн хагас ойлголттой, дуу хоолойгоо илэрхийлэх сонирхол дунд буюу саарал [14%], улс төрийн эрхийн ойлголттой, дуу хоолойгоо илэрхийлэх өндөр сонирхолтой [36%], Улс төрийн эрхийн ойлголтгүй боловч дуу хоолойгоо илэрхийлэх өндөр сонирхолтой намирах магадлалтай [10%] гэсэн бүлгүүдэд хуваан үзэж болохоор байна. Харин судалгаанд оролцогчдын 32 хувь нь завсрын бүлэгт байгаа буюу нөхцөл байдлаас хамааран аль нэг талд орж нийгмийн харилцааг савлуулахад нөлөөлж болохуйц байна (Хүснэгт 44).

Хүснэгт 44. Дуу хоолой (идэвхтэй), улс төрийн эрхийн ойлголтын харьцуулалт (асуулт 22, 8)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай	Иргэн таны улс төрийн эрх бол ардчиллын баталгаа мөн						Нийт
	Ардчиллын баталгаа биш (1)	2	3	4	5	Ардчиллын баталгаа мөн (6)	
Үгээ хэлэх шаардлагагүй (1)	23 20.2%	8 12.7%	9 5.2%	6 3.8%	3 2.2%	17 4.4%	66 6.4%
2	6 5.3%	8 12.7%	9 5.2%	7 4.4%	7 5.1%	8 2.1%	45 4.4%
3	9 7.9%	8 12.7%	53 30.8%	17 10.6%	19 14.0%	33 8.5%	139 13.4%
4	7 6.1%	3 4.8%	35 20.3%	41 25.6%	20 14.7%	44 11.3%	150 14.5%
5	6 5.3%	15 23.8%	27 15.7%	38 23.8%	38 27.9%	55 14.1%	179 44.0%
Үгээ хэлэх шаардлагатай (6)	63 55.3%	21 33.3%	39 22.7%	51 31.9%	49 36.0%	232 59.6%	455 44.0%
Нийт	114 11.0%	63 6.1%	172 16.6%	160 15.5%	136 13.2%	389 37.6%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Эдгээрийг нэгтгэн дүгнэж үзвэл улс төрийн ойлголт нэмэгдэх тусам иргэдийн дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхол нэмэгдэж байгаа нь ажиглагдаж байна. Судалгаанд оролцогчдын 50.8 хувь ойлголт өндөртэй байгаа бөгөөд тэдгээрийн 71.0 хувь нь дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхол өндөртэй, 9.0 хувь нь идэвхтэй боловч сонирхолгүй, 20.0 хувь нь нөхцөл байдлаас хамааран дуу хоолойгоо илэрхийлэх идэвх сонирхолтой байна.

Улс төрийн эрхээ ойлгосон байдал болон дуу хоолойгоо идэвхгүй илэрхийлэх сонирхлыг харьцуулан авч үзвэл улс төрийн эрхээ ойлгоогүй, дуу хоолойгоо илэрхийлэхийг хүсдэггүй бүлэг (7%), улс төрийн эрхээ ойлгосон боловч дуу хоолойгоо илэрхийлэх сонирхолгүй бүлэг (10%), улс төрийн эрхийн хагас ойлголттой, дуу хоолойгоо илэрхийлэх сонирхолтой

бүлэг (14%), улс төрийн эрхийн ойлголттой, дуу хоолойгоо илэрхийлэх сонирхол өндөртэй бүлэг (24%), Улс төрийн эрхийн ойлголтгүй боловч дуу хоолойгоо илэрхийлэх сонирхол өндөртэй байгаа ч хувирах магадлалтай бүлэг (7%) гэсэн бүлгүүдэд хуваан үзэж болохоор байна (Хүснэгт 45).

Хүснэгт 45. Дуу хоолой (идэвхгүй), улс төрийн эрхийн ойлголтын харьцуулалт (асуулт 24, 8)

Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг.	Иргэн таны улс төрийн эрх бол ардчиллын баталгаа мөн						Нийт
	Ардчиллын баталгаа биш (1)	2	3	4	5	Ардчиллын баталгаа мөн (6)	
Эсэргүүцлээ илэрхийлдэггүй (1)	42 36.8%	4 6.3%	18 10.5%	24 15.0%	16 11.8%	66 17.0%	170 16.4%
2	8 7.0%	15 23.8%	23 13.4%	31 19.4%	9 6.6%	17 4.4%	103 10.0%
3	11 9.6%	5 7.9%	61 35.5%	19 11.9%	28 20.6%	48 12.3%	172 16.6%
4	3 2.6%	12 19.0%	27 15.7%	40 25.0%	30 22.1%	60 15.4%	172 16.6%
5	9 7.9%	11 17.5%	18 10.5%	20 12.5%	23 16.9%	53 13.6%	134 13.0%
Эсэргүүцлээ илэрхийлдэг (6)	41 36.0%	16 25.4%	25 14.5%	26 16.3%	30 22.1%	145 37.3%	283 27.4%
Нийт	114 11.0%	63 6.1%	172 16.6%	160 15.5%	136 13.2%	389 37.6%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Эдгээрийг нэгтгэн дүгнэж үзвэл улс төрийн ойлголт нэмэгдэх тусам дуу хоолойгоо илэрхийлэхгүй, идэвхгүй байх сонирхол нэмэгдэж байгаа боловч дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхлоос бага байна. Ойлголт өндөртэй бүлэг судалгаанд оролцогчдын 50.8 хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн 48.0 хувь нь дуу хоолойгоо илэрхийлэхгүй, идэвхгүй байх сонирхол өндөртэй, 21.0 хувь нь сонирхолгүй, 32.0 хувь нь нөхцөл байдлаас хамааран дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхолтой байна.

Дуу хоолойгоо идэвхтэй, идэвхгүй илэрхийлэх байдлыг улс төрийн эрхээ ойлгосон байдалтай хамааруулан дүгнэлт хийхэд ойлголт өндөр байх тусмаа иргэд өөрсдийн дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхолтой байна. Судалгаанд оролцогчдын 65.0 хувь нь өөрсдийн дуу хоолойгоо бүх хэлбэрээр илэрхийлэх сонирхолтой бол нийт судалгаанд

оролцогчдын 7.0 хувь нь дуу хоолойгоо ямар нэгэн хэлбэрээр илэрхийлэх сонирхолгүй байна.

4.8 Эгэх хариуцлага ба улс төрийн эрх, иргэний эрхийн харьцуулалт

Иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан байдлыг улс төрийн эрхийн ойлголттой харьцуулан үзвэл улс төрийн эрхийн ойлголтгүй иргэний эгэх хариуцлагаа ухамсарлаагүй буюу нийгмийн харилцааг үл тоогчдын бүлэг (8%), улс төрийн эрхийн ойлголт сайн боловч иргэний эгэх хариуцлагагүй цөхөрсөн бүлэг (16%), эгэх хариуцлагаа ухамсарласан байдал болон улс төрийн эрхийн ойлголт дунд бүлэг (14%), улс төрийн эрхийн ойлголт сул боловч иргэний эгэх хариуцлагаа өндөр ухамсарласан бүлэг (6%), иргэний эгэх хариуцлагаа өндөр ухамсарласан, улс төрийн эрхийн ойлголт өндөртэй бүлэг (22%), завсрын бүлэг (35%) тус тус эзэлж байна (Хүснэгт 46).

Хүснэгт 46. Иргэний эгэх хариуцлага, улс төрийн эрхийн ойлголтын харьцуулалт (асуулт 19, 8)

“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ	Иргэн таны улс төрийн эрх бол ардчиллын баталгаа мөн						Нийт
	Ардчиллын баталгаа биш (1)	2	3	4	5	Ардчиллын баталгаа мөн (6)	
Нэгдэхгүй (1)	41 36.0%	15 23.8%	32 18.6%	28 17.5%	32 23.5%	98 25.2%	246 23.8%
2	10 8.8%	15 23.8%	15 8.7%	13 8.1%	13 9.6%	23 5.9%	89 8.6%
3	14 12.3%	10 15.9%	47 27.3%	27 16.9%	20 14.7%	38 9.8%	156 15.1%
4	6 5.3%	9 14.3%	31 18.0%	37 23.1%	17 12.5%	60 15.4%	160 15.5%
5	2 1.8%	3 4.8%	16 9.3%	26 16.3%	25 18.4%	30 7.7%	102 9.9%
Нэгдэнэ (6)	41 36.0%	11 17.5%	31 18.0%	29 18.1%	29 21.3%	140 36.0%	281 27.2%
Нийт	114 11.0%	63 6.1%	172 16.6%	160 15.5%	136 13.2%	389 37.6%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улс төрийн ойлголт өндөртэй оролцогчдын хувь (51%) нь иргэний эгэх хариуцлагаа өндөр ухамсарласан оролцогчдын хувь (37%)-аас 14 хувиар илүү байгаа нь иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан байдал харьцангуй сул байгааг илтгэж байна. Улс төрийн эрхийн ойлголт нэмэгдэх нь иргэний эгэх хариуцлагыг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй байна. Тухайлбал, иргэний эгэх хариуцлага өндөр байгаа бүлгийн 58.0 хувь нь улс төрийн эрхийн ойлголт өндөртэй оролцогчид байв. Харьцуулалтаас харахад иргэний эгэх хариуцлага маш өндөр байх тусам,

мөн улс төрийн эрхээ маш сайн ойлгосон гэж хариулсан оролцогчдын тоо (140 буюу нийт оролцогчдын 14%) бусад бүлгээс хамгийн их нь байв.

Улс төрийн эрхийн хэрэгжилт, иргэний эгэх хариуцлага хоорондын хамаарлыг харьцуулж үзвэл улс төрийн эрхийн хэрэгжилтийг муу гэж дүгнэсэн ба иргэний эгэх хариуцлагаа сул ухамсарласан бүлэг (17%), улс төрийн эрхийн хэрэгжилтийг өндөр үнэлсэн иргэний эгэх хариуцлагаа ухамсарлаагүй (5%), улс төрийн эрхийн үнэлгээ дундаж ба иргэний эгэх хариуцлагаа дунд зэрэг ухамсарласан (18%), улс төрийн эрхийн хэрэгжилтийг муу үнэлсэн, иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан (14%) болон улс төрийн эрхийн хэрэгжилтийг өндрөөр үнэлсэн ба иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан сэтгэл ханамжтай (11%) гэсэн бүлгүүдэд хуваагдаж байна (Хүснэгт 47).

Хүснэгт 47. Иргэний эгэх хариуцлага, улс төрийн эрхийн хэрэгжилтийн харьцуулалт (асуулт 19, 15)

“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ	Одоогийн УИХ-ын гишүүд чөлөөт, шударга сонгуулиар сонгогдсон						Нийт
	Чөлөөт, шударга сонгуулиар сонгогдоогүй (1)	2	3	4	5	Чөлөөт шударга сонгуулиар сонгогдсон (6)	
Нэгдэхгүй (1)	91 38.4%	41 27.5%	52 21.3%	23 12.6%	13 15.5%	26 19.0%	246 23.8%
2	12 5.1%	32 21.5%	19 7.8%	18 9.8%	7 8.3%	1 .7%	89 8.6%
3	23 9.7%	24 16.1%	71 29.1%	20 10.9%	4 4.8%	14 10.2%	156 15.1%
4	12 5.1%	11 7.4%	32 13.1%	62 33.9%	24 28.6%	19 13.9%	160 15.5%
5	15 6.3%	16 10.7%	21 8.6%	24 13.1%	20 23.8%	6 4.4%	102 9.9%
Нэгдэнэ (6)	84 35.4%	25 16.8%	49 20.1%	36 19.7%	16 19.0%	71 51.8%	281 27.2%
Нийт	237 22.9%	149 14.4%	244 23.6%	183 17.7%	84 8.1%	137 13.2%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улс төрийн эрхийн хэрэгжилт сайн байх нь иргэний эгэх хариуцлагыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй байна. Тухайлбал, улс төрийн эрхийн хэрэгжилтийг өндрөөр үнэлсэн оролцогчдын тоо 221 буюу нийт оролцогчдын 51.0 хувь нь иргэний эгэх хариуцлага өндөртэй харин 21.0 хувь нь сул байна.

Иргэний эгэх хариуцлага болон иргэний эрхийн хэрэгжилтийг харьцуулан үзвэл иргэний эрхийн хэрэгжилт хангалтгүй гэж үнэлсэн

болон иргэний эгэх хариуцлагаа ухамсарлаагүй бүлэг(15%), иргэний эрхийн хэрэгжилтийг өндөр үнэлсэн боловч иргэний эгэх хариуцлагаа ухамсарлаагүй (6%), иргэний эрхийн хэрэгжилтийг дунд үнэлсэн ба иргэний эгэх хариуцлагаа дунд ухамсарлаж байгаа (20%), иргэний эрхийн хэрэгжилт хангалтгүй гэж үнэлсэн ба иргэний эгэх хариуцлага өндөр (8%), иргэний эрхийн хэрэгжилтийг өндөр үнэлсэн ба иргэний эгэх хариуцлага өндөр бүлэг (11%) гэж тус тус ангилагдаж байна (Хүснэгт 48).

Хүснэгт 48. Иргэний эгэх хариуцлага, иргэний эрхийн хэрэгжилтийн харьцуулалт (асуулт 19, 20)

“Төрийн төлөө оготно боож үхнэ” гэдэгтэй санал нэгдэнэ	Би өөрийнхөө эрх ашгийг хамгаалах үүднээс иргэний нийгмийн байгууллагыг байгуулах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох боломжоор бүрэн хангагдсан						Нийт
	Бүрэн хангагдаагүй (1)	2	3	4	5	Бүрэн хангагдсан (6)	
Нэгдэхгүй (1)	81 49.7%	31 25.6%	51 19.7%	26 12.9%	16 14.2%	41 23.2%	246 23.8%
2	12 7.4%	32 26.4%	21 8.1%	14 7.0%	6 5.3%	4 2.3%	89 8.6%
3	11 6.7%	19 15.7%	83 32.0%	21 10.4%	10 8.8%	12 6.8%	156 15.1%
4	8 4.9%	11 9.1%	39 15.1%	63 31.3%	23 20.4%	16 9.0%	160 15.5%
5	6 3.7%	9 7.4%	20 7.7%	35 17.4%	20 17.7%	12 6.8%	102 9.9%
Нэгдэнэ (6)	45 27.6%	19 15.7%	45 17.4%	42 20.9%	38 33.6%	92 52.0%	281 27.2%
Нийт	163 15.8%	121 11.7%	259 25.0%	201 19.4%	113 10.9%	177 17.1%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Судалгаанд оролцогчдын 241 буюу 23.0 хувь нь иргэний эрхийн хэрэгжилтийг өндөр үнэлсэн байна. Тэдний 47.0 хувь нь иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан байдал өндөр, 28.0 хувь нь сул байна. Эндээс дүгнэлт хийж үзвэл иргэний эрхийн хэрэгжилт нь иргэний эгэх хариуцлагаа ухамсарлахад шууд нөлөө байхгүй байна.

4.8.1 Нийгмийн эгэх хариуцлага ба улс төрийн эрх, иргэний эрхийн хэрэгжилтийн харьцуулалт

Нийгмийн эгэх хариуцлагыг улс төрийн эрхийн ойлголттой харьцуулан үзвэл улс төрийн эрхийн ойлголт сул, нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ муутай байгаа бүлэг (11%), улс төрийн эрхийн ойлголт өндөр хэдий ч нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ муу байгаа бүлэг (16%), нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ болон улс төрийн эрхийн хэрэгжилтийн дундаж

үнэлгээтэй бүлэг (17%), нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ өндөр байгаа боловч улс төрийн эрхийн хэрэгжилт муутай бүлэг (2%), нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ өндөр болон улс төрийн эрхийн хэрэгжилт өндөр бүлэг (17%) гэсэн ялгаатай бүлгүүдэд хуваагдаж байна. Судалгаанд оролцогчдын 390 буюу 38.0 хувь нь завсрын бүлгийг бүрдүүлж байна. Ялангуяа завсрын бүлгийн 47.0 хувь нь нийгмийн эгэх хариуцлага дунд боловч улс төрийн эрхийн ойлголт өндөр байна (Хүснэгт 49).

Хүснэгт 49. Нийгмийн эгэх хариуцлага, улс төрийн эрхийн ойлголтын харьцуулалт (асуулт 21, 8)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар хаана ч, хэнд ч хандаад нэмэргүй.	Иргэн таны улс төрийн эрх бол ардчиллын баталгаа мөн						Нийт
	Ардчиллын баталгаа биш (1)	2	3	4	5	Ардчиллын баталгаа мөн (6)	
Хэлээд нэмэргүй (1)	65 57.0%	20 31.7%	39 22.7%	24 15.0%	24 17.6%	78 20.1%	250 24.2%
2	16 14.0%	14 22.2%	17 9.9%	24 15.0%	21 15.4%	38 9.8%	130 12.6%
3	13 11.4%	15 23.8%	64 37.2%	36 22.5%	28 20.6%	68 17.5%	224 21.7%
4	5 4.4%	7 11.1%	37 21.5%	34 21.3%	24 17.6%	69 17.7%	176 17.0%
5	1 0.9%	3 4.8%	9 5.2%	24 15.0%	22 16.2%	37 9.5%	96 9.3%
Хэлэх нь нэмэртэй (6)	14 12.3%	4 6.3%	6 3.5%	18 11.3%	17 12.5%	99 25.4%	158 15.3%
Нийт	114 11.0%	63 6.1%	172 16.6%	160 15.5%	136 13.2%	389 37.6%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улс төрийн эрхийн ойлголт өндөртэй судалгаанд оролцогчдын нийгмийн эгэх хариуцлагын талаарх үнэлгээ муу байгаа (31%), дундаж байгаа (36%), сайн байгаа (33%) нь бүлэг хооронд ойролцоо тархалттай байна. Нийгмийн эгэх хариуцлага ба улс төрийн эрхийн хэрэгжилт гэсэн үзүүлэлтийг харьцуулан үзвэл улс төрийн эрхийн хэрэгжилт ба нийгмийн эгэх хариуцлага үнэлгээ муу бүлэг (24%), улс төрийн эрхийн хэрэгжилт өндөр хэдий ч нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ муу бүлэг (4%), нийгмийн эгэх хариуцлага болон улс төрийн эрхийн хэрэгжилтийн үнэлгээ дундаж бүлэг (24%), нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ өндөр боловч улс төрийн эрхийн хэрэгжилт муу бүлэг (6%), нийгмийн эгэх хариуцлага болон улс төрийн эрхийн хэрэгжилтийн үнэлгээ өндөр байгаа бүлэг (11%) гэсэн ангилал гарч байна (Хүснэгт 50).

Хүснэгт 50. Нийгмийн эгэх хариуцлага, улс төрийн эрхийн хэрэгжилтийн харьцуулалт (асуулт 21, 15)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар хаана ч, хэнд ч хандаад нэмэргүй	Одоогийн УИХ-ын гишүүд чөлөөт, шударга сонгуулиар сонгогдсон						Нийт
	Чөлөөт, шударга сонгуулиар сонгогдоогүй (1)	2	3	4	5	Чөлөөт шударга сонгуулиар сонгогдсон (6)	
Хэлээд нэмэргүй (1)	141 59.5%	38 25.5%	39 16.0%	8 4.4%	7 8.3%	17 12.4%	250 24.2%
2	24 10.1%	41 27.5%	29 11.9%	20 10.9%	11 13.1%	5 3.6%	130 12.6%
3	26 11.0%	28 18.8%	95 38.9%	56 30.6%	9 10.7%	10 7.3%	224 21.7%
4	10 4.2%	13 8.7%	37 15.2%	64 35.0%	26 31.0%	26 19.0%	176 17.0%
5	6 2.5%	16 10.7%	26 10.7%	19 10.4%	17 20.2%	12 8.8%	96 9.3%
Хэлэх нь нэмэртэй (6)	30 12.7%	13 8.7%	18 7.4%	16 8.7%	14 16.7%	67 48.9%	158 15.3%
Нийт	237 22.9%	149 14.4%	244 23.6%	183 17.7%	84 8.1%	137 13.2%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Улс төрийн эрхийн хэрэгжилт муу гэж үнэлгээ өгсөн оролцогчдын (386 буюу 37%) 63.0 хувь нь нийгмийн эгэх хариуцлага муу байна гэж дүгнэсэн байна. Харин улс төрийн эрхийн хэрэгжилт муу байх нь нийгмийн эгэх хариуцлага муу байхад шууд нөлөөтэй байна.

Харин нийгмийн эгэх хариуцлага болон иргэний эрхийн хэрэгжилтийг харьцуулан үзвэл иргэний эрхийн хэрэгжилт ба нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ аль аль нь муу бүлэг (24%), иргэний эрхийн хэрэгжилт өндөр хэдий ч нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ муу бүлэг (5%), нийгмийн эгэх хариуцлага болон иргэний эрхийн хэрэгжилтийн үнэлгээ дундаж бүлэг (25%), нийгмийн эгэх хариуцлагын үнэлгээ өндөр боловч иргэний эрхийн хэрэгжилт муу бүлэг (3%), нийгмийн эгэх хариуцлага болон иргэний эрхийн хэрэгжилтийн үнэлгээ өндөртэй бүлэг 14%-ийг тус тус эзэлж байна (Хүснэгт 51).

Хүснэгт 51. Нийгмийн эгэх хариуцлага, иргэний эрхийн хэрэгжилтийн харьцуулалт (асуулт 21, 20)

Нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар хаана ч, хэнд ч хандаад нэмэргүй	Би өөрийнхөө эрх ашгийг хамгаалах үүднээс иргэний нийгмийн байгууллагыг байгуулах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох боломжоор бүрэн хангагдсан						Нийт
	Бүрэн хан-гагдаагүй (1)	2	3	4	5	Бүрэн хан-гагдсан (6)	
Хэлээд нэмэргүй (1)	111 68.1%	33 27.3%	46 17.8%	18 9.0%	14 12.4%	28 15.8%	250 24.2%
2	13 8.0%	43 35.5%	30 11.6%	25 12.4%	12 10.6%	7 4.0%	130 12.6%
3	13 8.0%	25 20.7%	111 42.9%	42 20.9%	16 14.2%	17 9.6%	224 21.7%
4	7 4.3%	10 8.3%	39 15.1%	69 34.3%	25 22.1%	26 14.7%	176 17.0%
5	2 1.2%	4 3.3%	22 8.5%	25 12.4%	34 30.1%	9 5.1%	96 9.3%
Хэлэх нь нэмэртэй (6)	17 10.4%	6 5.0%	11 4.2%	22 10.9%	12 10.6%	90 50.8%	158 15.3%
Нийт	163 15.8%	121 11.7%	259 25.0%	201 19.4%	113 10.9%	177 17.1%	1034 100.0%

Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан

Иргэний эрхийн хэрэгжилт муу гэж үнэлгээ өгсөн оролцогчид (334 буюу 32%)-ын 75.0 хувь нь нийгмийн эгэх хариуцлага муу байна гэж дүгнэсэн байна. Эндээс үзвэл иргэний эрхийн хэрэгжилт муу байх нь нийгмийн эгэх хариуцлага муу байхад шууд нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн эрхийн хэрэгжилт муу байх нь иргэний эрхийн хэрэгжилт муудах нөхцөл болж, улмаар нийгмийн эгэх хариуцлага муу байхад шууд нөлөөтэй байна гэж дүгнэхүйц байна.


4.9 Кросстаб хүснэгтийн нэгдсэн үр дүн

Судалгаанд хамрагдсан 1034 оролцогчдын асуулгын үр дүнг О.Хиршманы онолын үзэл баримтлалын хүрээнд үзүүлэлт тус бүрээр нь нэгтгэн авч үзвэл “Дуу хоолой”-гоо илэрхийлэх буюу нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн 61.3 хувь, “Үнэнч байдал” буюу Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой гэж үзсэн 40.6 хувь, “Орхих” буюу боломж олдвол өөр аймаг, хот эсвэл гадаадад амьдрах хүсэлтэй 48.7 хувийг тус тус бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, арван хүн тутмын зургаа нь үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн, арван хүн тутмын дөрөв нь Монголдоо сайхан амьдрах хүсэлтэй, харин нийт оролцогчдын 48,7 хувь буюу хоёр хүн тутмын нэг нь шилжилт хөдөлгөөнд орох магадлалтай байгаа нь улс төрд итгэх итгэл иргэдийн дунд алдарсан байгааг илтгэж байна.

Эдгээр хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийг харьцуулж үзэхэд, “Дуу хоолой ба Үнэнч байдал” 13.9 хувь, “үнэнч байдал ба орхих” гэсэн сонголттой нь 5.2 хувь, “орхих ба дуу хоолой” сонголттой хэсэг 19.1 хувь байгаа бол “цөхөрсөн бүлэг” гэсэн ангилалд 14.2 хувь хамрагдахаар байна. Энэхүү “цөхөрсөн бүлэг” дуу хоолойгоо илэрхийлэх сонирхолтой, үнэнч байдлаа хадгалж байгаа хэдий ч эх орноо орхиход бэлэн байдлыг нэгэн зэрэг агуулсан бүлгийн төлөөлөл юм.

Эндээс дүгнэлт хийж үзэхэд, иргэд нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар дуу хоолойгоо илэрхийлэх хүсэл эрмэлзэлтэй, төрийн байгуулал дахь систем доторх шийдлүүдэд найдаж, тууштай байх хандлага сул байна. Энэхүү найдвар хүлээсэн байдал нь нөхцөл байдлаас шалтгаалан бэхжих эсвэл үзэл бодлоо өөрчлөн орхих үйлдлийг хийхэд бэлэн байгааг харуулж байна (Зураг 41).

Зураг 41. Судалгаанд оролцогчдын “дуу хоолой, үнэнч байдал, орхих” гурван хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан.


Дархан-Уул аймгаас судалгаанд хамрагдсан нийт 382 оролцогчдын “Дуу хоолой” үзүүлэлт буюу нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн 63.9 хувь, “Үнэнч байдал” буюу Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой гэж үзсэн 39.0 хувь, “Орхих” буюу боломж

олдвол өөр аймаг, хот эсхүл гадаадад амьдрах хүсэлтэй 45.3 хувийг тус тус бүрдүүлж байна.

Эдгээр хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийг харьцуулан үзэхэд, “дуу хоолой ба үнэнч байдал” 16.4 хувь, “үнэнч байдал ба орхих” 3.9 хувь, “орхих ба дуу хоолой” 18.8 хувь байгаа бол “саарал буюу цөхөрсөн бүлэг” 11.2 хувийг эзэлж байна. Энэхүү “цөхөрсөн бүлэг” дуу хоолойгоо илэрхийлэх сонирхолтой, үнэнч байдлаа хадгалж байгаа ч эх орноо орхиход бэлэн байдлыг нэгэн зэрэг агуулсан бүлгийн төлөөлөл юм.

Эндээс дүгнэхэд Дархан-Уул аймгийн иргэд нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар дуу хоолойгоо илэрхийлэх хүсэл эрмэлзэлтэй, төрийн байгуулал дахь систем доторх шийдлүүдэд үнэнч байдлаа хадгалан үлдэхэд бэлэн байгаа ч нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд болон бодлого шийдвэрт итгэл алдрах, улмаар эх орноо орхин гарахад бэлэн байгааг харуулж байна (Зураг 42).

Зураг 42. Дархан хотын иргэдийн “дуу хоолой, үнэнч байдал, орхих” хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан.


Улаанбаатар хотын судалгаанд оролцсон 385 иргэдийн “Дуу хоолой” буюу нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал,

цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн нь 62.3 хувь, “Үнэнч байдал” буюу Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой гэж үзсэн 38.4 хувь, “Орхих” буюу боломж олдвол хот эсвэл гадаадад амьдрах хүсэлтэй 57.4 хувийг тус тус бүрдүүлж байна.

Эдгээр хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийг харьцуулан үзэхэд, “дуу хоолой ба үнэнч байдал” 9.3 хувь, “үнэнч байдал ба орхих” 5.4 хувь, “орхих ба дуу хоолой” 23.8 хувь байгаа бол “цөхөрсөн бүлэг” 17.9 хувийг эзэлж байна. Энэхүү “цөхөрсөн бүлэг” дуу хоолойгоо илэрхийлэх сонирхолтой, үнэнч байдлаа хадгалж байгаа ч эх орноо орхиход бэлэн байдлыг нэгэн зэрэг агуулсан бүлгийн төлөөлөл юм.

Эндээс дүгнэхэд Улаанбаатар хотын иргэд нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар дуу хоолойгоо илэрхийлэх сонирхол сул, төрийн байгуулал, засгийн газрын шийдлүүдэд болон нийслэлийн засаг захиргааны хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрт итгэл алдрах хандлагатай байна. Улмаар эх орноо орхин гарахад бэлэн байгааг харуулж байна [Зураг 43].

Зураг 43. Улаанбаатар хотын иргэдийн “дуу хоолой, үнэнч байдал, орхих” хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн




Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан.

Дундговь аймгийн судалгаанд оролцсон 267 иргэдийн “Дуу хоолой” буюу нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн 56.2 хувь, “Үнэнч байдал” буюу Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой гэж үзсэн 46.1 хувь, “Орхих” буюу боломж олдвол өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй 40.8 хувийг тус тус бүрдүүлж байна.

Эдгээр хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийг харьцуулан үзэхэд, “дуу хоолой ба үнэнч байдал” 16.8 хувь, “үнэнч байдал ба орхих” 6.7 хувь, “орхих ба дуу хоолой” 12.7 хувь байгаа бол “саарал буюу цөхөрсөн бүлэг” 13.1 хувийг эзэлж байна. Энэхүү “цөхөрсөн бүлэг” дуу хоолойгоо илэрхийлэх сонирхолтой, үнэнч байдлаа хадгалж байгаа ч эх орноо орхиход бэлэн байдлыг нэгэн зэрэг агуулсан бүлгийн төлөөлөл юм.

Эндээс дүгнэлт хийж үзэхэд Дундговь аймгийн иргэд нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар дуу хоолойгоо илэрхийлэх, төрийн байгуулал, систем доторх шийдлүүдэд болон орон нутгийн засаг захиргааны бодлого, шийдвэрт үнэнч тууштай байхад бэлэн байгааг харуулж байна. Энэхүү найдвар хүлээсэн байдал нь нөхцөл байдлаас шалтгаалан бэхжих эсвэл орхиход бэлэн байгааг харуулж байна [Зураг 44].

Зураг 44. Дундговь аймгийн иргэдийн “дуу хоолой, үнэнч байдал, орхих” хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн



Эх сурвалж: Судалгааны багийн боловсруулсан.

Судалгаанд оролцогчдыг Улаанбаатар, Дархан-Уул болон Дундговь аймгийн хооронд харьцуулан дүгнэлт хийж үзвэл Улаанбаатар хотын “цөхөрсөн бүлэг” 14.2 хувь, Дархан-Уул аймгийн “цөхөрсөн бүлэг” 17.9 хувь, Дундговь аймгийн цөхөрсөн бүлэг” 13.1 хувийг тус тус эзэлж байна. Эдгээр тоон үзүүлэлт нь нэг талдаа тухайн хот, аймгийн иргэдийн хандлагыг тодорхойлж байгаа хэдий ч нөгөө талдаа улсын хэмжээнд эдгээр тоон үзүүлэлтийг гаргаж, харьцуулсан дүгнэлт хийх хэрэгцээ байгаа нь энэхүү асуулгын нэгдсэн үр дүнгээр тодорч байна.

4.10 Экспертүүдтэй хийсэн ярилцлагын дүн шинжилгээ

2023 оны Фрийдом Хаусын ардчиллын эрх чөлөөний үзүүлэлтээр Монгол Улс 84 оноо авсан буюу эрх чөлөөтэй ангилалд багтаж³² (Freedom House, 2023) эрх чөлөөний түвшин 1.5 оноо, улс төрийн эрхийн хэрэгжилт 1 оноо, иргэний эрхийн хэрэгжилтээр 2 оноо авсан хэдий ч ардчиллын чанарын үзүүлэлтүүд нь Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлтүүдээр суларсан төлөвтэй байна³³. Иймд иргэний улс төрийн эрхийн болон иргэний эрхийн хэрэгжилт засаглалын чанар хоорондоо ямар уялдаатай байгааг тодруулах шаардлага үүсэж байна. Иймд судалгааны хүрээнд ардчилал, хүний эрх, эрх чөлөөний чиглэлээр дотоодын болон олон улсын байгууллагуудтай олон жил хамтарч ажиллаж, төслийн удирдагч, зөвлөх хийж байсан таван экспертэй ярилцлага хийсэн.

Эдгээр судлаачид Монгол Улс дахь ардчиллын төлөв байдал, сонгуулийн тогтолцоо, хүний эрх, эрх чөлөөний чиглэлд олон тооны судалгааны өгүүлэл, илтгэл бичиж, дотоодын болон гадаадын судалгааны багт ажиллаж тайлан боловсруулахад оролцож байсан арвин туршлагатай. Ярилцлагын зорилго нь Фрийдом Хаус олон улсын судалгааны байгууллагаас Монгол Улсад өгсөн үнэлгээний талаарх тухайн судлаачийн ойлголтын түвшин, хандлагыг тодруулахад чиглэсэн болно. Ярилцлагыг экспертийн ажлын байран дээр зохион байгууллаа.

Ярилцлагын хүрээнд нэгдүгээрт, “Монгол Улс Фрийдом Хаусын 2022 оны судалгааны үнэлгээгээр Улс төрийн эрхийн хэрэгжилт дээр 40 оноо авахаас 36 оноо авсан. Үүний цаад шалтгааныг дараах 3 агуулгын хүрээнд Та тайлбарлаж өгнө үү” гэсэн асуултыг тавьсан.

Монгол Улс дахь сонгуулийн үйл явцын тухайд судлаачдын хувьд Фрийдом Хаусын 11/12 оноо өгсөн үнэлгээтэй санал зөрүүтэй байгаа нь ярилцлагын явцад харагдав. Нэг талаас Фрийдом хаусын судалгааны

³² {0 = хамгийн бага эрх чөлөөгүй, 100 = хамгийн их эрх чөлөөтэй }

³³ <https://www.theglobaleconomy.com/Mongolia/indicators> retrieved on 2024.12.05

арга зүй судалгааны үр дүнд нөлөөлж байна гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, тус судалгаа нь тухайн орны хууль эрх зүйн баримт бичгүүд, сонгуулийн ерөнхий процесс хэр шударга явагдаж буйд анхаарал хандуулж байгаа бөгөөд улс төрийн орчны бодит байдал дээр иргэдийн дуу хоолой ямар байна вэ? гэдгийг бүрэн гаргаж чадахгүй байна гэж дүгнэсэн.

Харин иргэдийн хувьд *“Иргэд улс төрийн эрх (үгээ хэлэх, сонгууль өгөх, сонгогдох)-ээ бүрэн дүүрэн эдэлдэг үү”* гэсэн асуултад Дундговь аймгийн оролцогчдын 46.8 хувь нь бүрэн эдэлдэг, Улаанбаатар хотын судалгаанд хамрагдагчдын 53.8 хувь нь ямар нэг хэмжээгээр улс төрийн эрхээ эдэлдэг гэсэн бол харин Дархан-Уул аймгийн оролцогчид улс төрийн эрхээ төдийн эдэлж чадахгүй байгаа гэж үзсэн. Тэдний 54.9 хувь нь улс төрийн эрхээ тодорхой хэмжээнд эдэлж чаддаггүй гэж хариулснаас харагдаж байна [Зураг 18, хууд.52].

Судлаачдын байр суурь болон судалгаанд оролцогчдын санал асуулгын үр дүнгийн хооронд зөрүү гарч байв. Учир нь иргэдийн хувьд улс төрийн сонгууль шударга бус, хараат байдал нийгэмд байдаг гэж үзсэн. Тухайлбал, Улаанбаатар хотын оролцогчдын тал хувь (50.9%), Дундговь аймгийн оролцогчдын 43.4 хувь нь улс төрийн эрхийн хэрэгжилт тодорхой түвшинд хараат байгааг хүлээн зөвшөөрсөн [Зураг 21, хууд. 53].

Улс төрийн олон ургалч байдлын тухай үнэлгээний хувьд Фрийдом Хаусын үнэлгээгээр 16/16 оноо авсан. Энэ тухайд судлаачид бүгд санал нэгтгэйгээр улс төрийн олон ургалч үзэл Монгол Улсад сайн хэрэгжиж байгаа гэдэгтэй санал нийлж байв. Гэхдээ зарим судлаач оноо өндөр гарахад тухайн судалгааны арга зүй, асуулгын агуулга нөлөөлж байгааг анхааруулж байв.

Харин иргэдийн хувьд өөрийн эрх ашгийг хамгаалах, дуу хоолойгоо илэрхийлэхийн тулд зөвхөн төрийн үйл ажиллагаа, бодлого шийдвэрийг харах биш иргэний нийгмийн байгууллагыг өөрсдөө байгуулах эрхтэй, нийгмийн олон талт үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох боломжтой гэдгээ сайн мэдэхгүй байгаа нь судалгааны анкетын 22 дугаар асуултын хариултын дүнгээс харагдаж байна [Зураг 27, хууд. 59].

Хачирхалтай нь Монгол Улсад бүртгэлтэй ТББ-уудын дийлэнх нь Улаанбаатар хотод байдаг хэдий ч хотын оролцогчдын 58.2 хувь нь уг эрхийн тухай ойлголт сул, эрхээ мэдэхгүй байна [Зураг 27, хууд. 59]. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө буюу иргэний эрхээ хэрэгжүүлэх иргэний нийгмийн байгууллагын талаарх ойлголтын тухайд экспертүүд бүгд санал нэгтгэйгээр Монгол Улсын хувьд хамгийн сайн хэрэгжиж байгаа гэсэн үнэлгээ өгсөн нь иргэдийн өгсөн саналтай зөрсөн болно. Харин улс

төрийн эрхийн хэрэгжилт дээр ноцтой асуудлууд байхгүй, төрөөс бодлого, эрх зүйн орчны хувьд хязгаарласан зүйлгүй байна. Нэг анхаарах өнцөг гарч ирсэн нь ТББ-уудын идэвхжил юм. Өөрөөр хэлбэл, 30 гаруй мянган ТББ-ууд үйл ажиллагаа явуулж байгаа ч идэвхтэй нь цөөхөн байгааг судлаачид онцолж байв.

Засгийн газрын үйл ажиллагаа үзүүлэлт дээр 9/12 оноо авсан тухайд эксперт судлаачдын хувьд дийлэнх нь санал нийлж байв. Учир нь Монгол Улсад бодлогын залгамж чанар, уялдаа холбоо байхгүй байна гэж үзсэн байна. Мөн энэ асуудлыг улс төрийн намын дотоод ардчилал, улс төрийн авлигын нөхцөл байдалтай холбон тайлбарлаж байв. Харин иргэдийн хувьд улс төрийн сонгууль шударга явагддаггүй тул сонгогдсон гишүүдэд сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлж, мөн Монгол Улсын СЕХ-ны засаглал асуудалтай буюу сонгуулийг хараат бус, ардчиллын зарчмаар сайн зохион байгуулж чаддаггүй гэж Улаанбаатар хотынхон үзсэн байна (Зураг 24, хууд.56).

Өөр нэгэн анхаарал татсан өнцөг бол судалгааны арга зүй, түүнийг ашиглаж буй байдалтай холбоотой асуудал байв. Тухайлбал, тухайн судалгааг хэзээ, хэнээс авсан, тухайн цаг үед дотоодын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал ямар байсан нь судалгааны үр дүнд тодорхой хэмжээгээр нөлөөлдөг гэдгийг судлаачид анхааруулж байв.

Ярилцлагын хүрээнд тодруулсан хоёр дахь бүлэг том сэдэв нь *“Иргэний эрх чөлөө”* гэсэн үзүүлэлтээр Монгол Улс 60 онооноос 48 оноогоор дүгнэгдсэнтэй холбоотойгоор *“Үүний цаад шалтгааныг дараах 3 агуулгын хүрээнд Та тайлбарлаж өгнө үү?”* гэсэн асуулт байв.

Иргэдийн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо эрх чөлөөтэй илэрхийдэг байх (14/16) үзүүлэлтийн тухайд судлаачид Фрийдом Хаусын үнэлгээтэй шууд санал нийлэхгүй байв. Монгол Улсад үзэл бодлоо илэрхийлэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг Үндсэн хуулиар олгосон, хэрэгжилт харьцангуй сайн байж ирсэн боловч сүүлийн жилүүдэд энэ байдал, зарчим хумигдаж цаашид үнэлгээ буурах хандлага руу орохыг анхааруулж байв. Харин иргэдийн хувьд өөрсдийн иргэний эрхийг хэрэгжүүлэхдээ санал бодлоо ил тод илэрхийлэх нь чухал гэж (Дархан-Уул аймгийн оролцогчдын 36.2 хувь, Улаанбаатар хотын оролцогчдын 36.6 хувь, Дундговь аймгийн оролцогчдын 46.5 хувь) үзсэн байна (Зураг 33, хууд. 63). Гэхдээ асуулгад оролцогчдын ихэнх нь төвийг сахисан байр суурьтай буюу санал бодлоо төдийлөн сайн илэрхийлдэггүй болох нь тодорч байв. Үүнд нөлөөлж байгаа нэг хүчин зүйл нь хэвлэлийн эрх чөлөө, буруу ташаа мэдээлэл буюу дисинформэйшн сүүлийн жилүүдэд

нэмэгдсэнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт чангарч, энэ нь эргээд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах байдал руу орж байгааг судлаачид онцолж байв.

Судлаач, экспертүүдтэй хийсэн ярилцлагыг нэгтгэн дүгнэхэд Фрийдом Хаусын үнэлгээний арга зүй, түүнийг ашиглан Монгол улсад хийсэн үнэлгээ, тайлангийн үр дүнтэй судлаачдын байр суурь зөрүүтэй байгаа нь ажиглагдлаа. Судлаачдын зүгээс тухайн үнэлгээний арга зүй, асуулгын оновчтой байдалд шүүмжлэлтэй хандаж, дотоодын нөхцөл байдалтай илүү нийцсэн үнэлгээг хөгжүүлэх шаардлага байгааг онцолж байв. Энэ нь аливаа бодлогын шийдвэрийн хэрэгжилт, нөхцөл байдлыг үнэлэхдээ Монгол Улс олон улсын байгууллагуудын гаргасан судалгааны тайлан, үнэлгээг шууд авч ашиглах бус, үндэсний хэмжээнд ашиглах судалгааны аргачлал боловсруулах, түүнийг ашиглаж үнэлэх хэрэгцээ байгааг тодорхойлж байна.



5.1 Судалгааны дүгнэлт

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 47 дугаар заалтаар “Дэлхийн Банкны засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба хариуцлага”-ыг жил тутамд хэмжих, үзүүлэлтийг тоон болон экспертийн ярилцлагын үр дүнгээр тодорхойлж байх, хэрэгжүүлэгч байгууллагыг ЗГХЭГ-ын харьяа Төрийн албаны сургууль гэж үүрэгжүүлж өгсний дагуу Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн судалгааны баг “Засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагыг хэмжих нь” сэдэвт тодорхойлох судалгааг хийв.

Судалгааны зорилгын хүрээнд нэгдүгээрт, “иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага үзүүлэлтэд улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилт хэрхэн нөлөөлж байна вэ? гэсэн асуултыг дэвшүүлж, улс төрийн эрхийн ойлголт, хэрэгжилтийг хамаарах хувьсагчаар тодорхойлж, асуулгын анкетаар Улаанбаатар хот, Дархан-Уул, Дундговь аймгуудаас түүвэр авч, судалгаа хийхэд улс төрийн эрхийн ойлголт нэмэгдэх тусам иргэдийн дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхол нэмэгдэж байгаа нь нотлогдлоо. Тухайлбал, улс төрийн эрхийн ойлголт өндөртэй бүлэг судалгаанд оролцогчдын 50.8 хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн 71.0 хувь нь дуу хоолойгоо идэвхтэй илэрхийлэх сонирхолтой, 9.0 хувь нь идэвхтэй боловч илэрхийлэх сонирхолгүй, 20.0 хувь нь нөхцөл байдлаас хамааран дуу хоолойгоо илэрхийлэх сонирхолтой байна (Хүснэгт 44, хууд. 87). Судалгаанд оролцогчдын 65.0 хувь нь өөрсдийн дуу хоолойгоо бүх хэлбэрээр илэрхийлэх сонирхолтой бол нийт судалгаанд оролцогчдын 7.0 хувь нь дуу хоолойгоо ямар нэгэн хэлбэрээр илэрхийлэх сонирхолгүй байна.

Хэдийгээр иргэд дуу хоолойгоо хүргэх сонирхолтой байгаа хэдий ч иргэний нийгмийн тухай ойлголт муу, ТББ-ын үйл ажиллагаанд ямар хэлбэрээр идэвхтэй оролцох, асуудлыг эвлэлдэн нэгдэх замаар хэрхэн шийдвэрлэх, асуудлын гарцыг оновчтой тодорхойлох тал дээр ойлголтгүй байна (Зураг 27, хууд.59). Мөн улс төрийн орчинд иргэдийн итгэх итгэл суларсан төлөвтэй байна. Энэ нь Засгийн газрын 11-11 төвийн үйл ажиллагааны тайлан мэдээнээс тодорхой харагдаж байна. Тухайлбал, иргэдийн 11-11 төвд ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулгад дүн шинжилгээ хийж үзэхэд Улс төрийн олон ургалч байдал, Иргэний оролцоотой холбоотой өргөдөл, гомдол хамгийн өндөр буюу 24.0 хувийг эзэлж

байна. Харин хувь хүний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх асуудалтай холбоотой өргөдөл, гомдол 21.0 хувь, Засгийн газрын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 17.0 хувь, Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл, гомдол 15.0 хувь, Эрх зүйт төрийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 14.0 хувь, Хувь хүний халдашгүй байдал болон хувийн эрхийн хэрэгжилтийн асуудалтай холбоотой өргөдөл, гомдол 9.0 хувьтай байв (Зураг 9, хууд.46).

Судалгаанд оролцогчдын хариултын үр дүнг судлаач О.Хиршманы онолын үзэл баримтлалын хүрээнд иргэдийн “Дуу хоолой”, “Үнэнч байдал”, “Орхих” хүчин зүйлсийн харилцан хамааралд Улаанбаатар хот, Дархан-Уул болон Дундговь аймгийн хооронд харьцуулан дүгнэлт хийж үзэхэд Улаанбаатар хотын зургаан дүүргийн 395 иргэдийн дунд улс төрд итгэл алдарсан “цөхөрсөн бүлэг” 14.2 хувь, Дархан-Уул аймгийн 382 иргэдийн дунд “цөхөрсөн бүлэг” 17.9 хувь, Дундговь аймгийн 267 иргэдийн дунд “цөхөрсөн бүлэг” 13.1 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, иргэд дуу хоолойгоо төрийн байгуулалд хүргэх хүсэлтэй боловч иргэдийн дуу хоолойд хариу үйлдэл үзүүлэх эгэх хариуцлагын механизм сул байна.

Судалгаанд оролцогчдын иргэний эгэх хариуцлагыг хувь хүний түвшинд тодруулах зорилготой асуулга “*төрийн төлөө оготно боож үхнэ*” гэдэгтэй санал нэгдэхгүй байгаа хүмүүсийн 134 (13%) нь үгээ хэлэх шаардлагатай гэж үзсэн бол, 24 (2.3%) нь үгээ хэлэх шаардлагагүй гэж үзсэн. Хэдийгээр энэхүү тоон утга нь холимог үзэл бодлыг илэрхийлж байгаа боловч тухайн асуулгатай санал нэгдэхгүй ч үгээ хэлэх зайлшгүй шаардлагатай гэж үзсэн хувь нь олонх байв (Хүснэгт 26, хууд.74). Өөрөөр хэлбэл, иргэдийн эгэх хариуцлага иргэдийн дуу хоолойд хүчтэй нөлөөтэй гэдгийг эндээс харж болохоор байна.

Судалгааны зорилгын хүрээнд хоёрдугаарт, “*Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага үзүүлэлтэд иргэний эрхийн хэрэгжилт хэрхэн нөлөөлж байна вэ*” гэсэн асуулт дэвшүүлж, иргэний эрхийн хэрэгжилтийг үл хамаарах хувьсагчаар тодорхойлж, асуулгын тоон мэдээлэлд шинжилгээ хийв.

Судалгаанд оролцогчдын “*Иргэний эрхийн*” тухай ойлголт, хандлагыг асуултаар тандаж үзэхэд “*Би өөрийнхөө эрх ашгийг хамгаалах үүднээс иргэний нийгмийн байгууллагыг байгуулах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох боломжоор бүрэн хангагдсан*” гэсэн асуултад гурван онооны түвшинд хариулт өгсөн нь 25.0 хувь, “*Хэнийг ч сонгоод өөрчлөлт авчрахгүй*” гэсэн асуултын 6 онооны түвшинд хариулт өгсөн нь 21.4 хувь, “*Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой*” гэсэн асуултын

6 онооны түвшинд хариулт өгсөн нь 29.3 хувийг тус тус бүрдүүлж байна. Эндээс нэгтгэн дүгнэхэд иргэний эрхийн тухай мэдлэг хангалтгүй түвшинд, харин эх орондоо сайхан амьдрах боломжтой гэсэн итгэлтэй байгааг харж болно (Хүснэгт 12, хууд.61).

Иргэний эгэх хариуцлага болон иргэний эрхийн хэрэгжилтийг харьцуулан үзвэл иргэний эрхийн хэрэгжилт муу гэж үнэлгээ өгсөн оролцогчид (334 буюу 32%)-ын 75.0 хувь нь нийгмийн эгэх хариуцлага муу байна гэж дүгнэсэн байна. Иргэний эрхийн хэрэгжилт муу байх нь нийгмийн эгэх хариуцлага муу байхад шууд нөлөөтэй байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн эрхийн хэрэгжилт муу байх нь иргэний эрхийн хэрэгжилт муудах нөхцөл болж, улмаар нийгмийн эгэх хариуцлага буурахад шууд нөлөөтэй байна гэж дүгнэхүйц байна (Хүснэгт 48, хууд.90). Өөрөөр хэлбэл, улс төрийн боловсрол нь иргэний нийгмийн суурь болохын зэрэгцээ иргэний эрхийн хэрэгжилт, эгэх хариуцлагыг нийгмийн харилцаанд төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй болох нь харагдаж байна.

Улс төрийн эрхийн хэрэгжилт муу гэж үнэлгээ өгсөн оролцогчдын (386 буюу 37%) 63.0 хувь нь нийгмийн эгэх хариуцлага муу гэж дүгнэсэн байна. Харин улс төрийн эрхийн хэрэгжилт хангалтгүй байх нь нийгмийн эгэх хариуцлага муу байхад шууд нөлөөтэй байна. Судалгаанд оролцогчдын 241 буюу 23.0 хувь нь иргэний эрхийн хэрэгжилтийг өндөр үнэлсэн байна. Тэдний 47.0 хувь нь иргэний эгэх хариуцлагаа ухамсарласан байдал өндөр, 28.0 хувь нь сул байна. Эндээс дүгнэхэд иргэний эрхийн хэрэгжилт нь иргэний эгэх хариуцлагаа ухамсарлахад шууд нөлөө байхгүй байна. Харин улс төрийн эрхийн хэрэгжилт сайн байх нь иргэний эгэх хариуцлагыг нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй байна.

5.2 Судалгааны хязгаарлалт

Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн судалгааны баг “Засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлагыг хэмжих нь” сэдэвт судалгааны ажлын төлөвлөлтийг хийхдээ уг асуудлыг судлахдаа УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 47 дугаар заалтаар баталсан “Дэлхийн Банкны судалгааны арга зүй”-г ашиглахаар төлөвлөсөн. Гэтэл Дэлхийн Банкны судалгааны үр дүн нь эрдэм шинжилгээний, тинк-танк, болон хүний эрхийн байгууллагуудын зөвлөх, шинжээч, экспертүүдийн багийн өгсөн онооны нэгдсэн үнэлгээ боловч энэхүү судалгаа нь дунджаар 60 орчим шинжээч, 30 орчим зөвлөхийн тусламжтай хийгддэг, шууд авч ашиглах дата, мэдээлэл нь хаалттай болох нь судалгааны явцад тогтоогдлоо.

Мөн Фрийдом Хаус, Ардчиллын индекс, Ардчиллын зэрэглэл тогтоох судалгааны арга зүй дээр ялгаатай байдал илэрч байсан. Тухайлбал, Ардчилсан засаглалын шилжилтийг тодорхойлох судалгаа хийдэг ХБНГУ-ын Бертелстманы сангаас засаглалын индекс тооцсон, улс төрийн шилжилтийн үнэлгээ хийсэн судалгааны дата мэдээллийг авах хүсэлтийг 2024 оны 7 дугаар сард Берлин хотын Бертелстманы салбарын эрхлэгч Maria Jourdan-д хандан гаргасан боловч судалгааны өгөгдөл мэдээлэл тухайн судлаачдын оюуны өмч болохыг онцолж, өгөх боломжгүй гэдэг хариулт өгсөн. Энэ мэт нөхцөл байдлаас шалтгаалан судалгааны дизайн боловсруулах явцад хийсэн төлөвлөлт, арга зүйн сонголтод зарчмын өөрчлөлт орсныг дурдаж байна.

Түүнчлэн 2024 онд УИХ-ын болон Орон нутгийн сонгуультай холбогдуулан асуулгын анкетаар мэдээлэл цуглуулах ажил цаг хугацааны хувьд хойшилсон нь мөн уг судалгааг хязгаарлах нэг хүчин зүйл болсон.

Судлагдахууны хязгаарлалтын тухайд, “иргэдийн дуу хоолой” гэх ойлголтыг улс төрийн эрхийн ойлголт, түүний хэрэгжилтээр үнэлгээ өгч, “эгэх хариуцлага” гэх ойлголтыг иргэний эрхийн хэрэгжилт гэсэн үзүүлэлтээр явцуу хүрээнд хязгаарлан үнэлсэн болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

- Benz, A. (2001). Vom Stadt-Umland-Verband zu "regional governance" in Stadtregionen. *Deutsche Zeitschrift fuer Kommunalwissenschaften*, 55-71.
- Bertelsmann Stiftung. (2022 оны January 20). *Transformation Index*. <https://bti-project.org>: <https://bti-project.org/en/methodology>-ээс Гаргасан
- Buehlmann. M, Merkel. W, Mueller. L, Giebler. H, Wessels. B. (2012). Demokratiebarometer; ein neues Instrument zur Messung von Demokratiequalitaet. *ZfVP* 6, 115-159.
- Buhlmann, M. (2012). *Demokratiebarometer*.
- Dahl. R.A. (1971). *Polyarchy: participation and opposition*. New Haven: Yale University Press. *Freedom house*. (2023).
- Freedom House. (2023 оны February 12). *Freedom House / Expanding freedom and democracy*. freedomhouse.org: <https://freedomhouse.org>-ээс Гаргасан
- Gerardo. L.M, Vertkuilen. A. (2002). Conceptualizing and Measuring Deomcracy: Evaluating Alternative Indices. *Comparative Political Studies* 35, 5-34.
- Hennig Nuissl, J. H. (2009). *"Good Governance" auf lokaler Ebene-Ansaetze zur Konzeptualisierung und Operationalisierung*. Leipzig.
- Hirschman, A. (1970). *Exit, Voice and Loyalty: Responses to Decline in Firms, Organizations, and States*. Cambridge: Harvard University Press.
- Huntington, S. P. (1991). *The Third Wave: Democratization in the Late Twentieth Century*.
- Kaufmann. D, Kraay. A, Mastruzzi. M. (2010). *Worldwide Governance Indicators: Methodology and Analytical Issues*. Washington: World Bank, Development Research Group.
- Lauth, H.-J. (2004). *Demokratie und Demokratiemessung*. Wiesbaden.
- Lauth, H.-J. u. (2019). Kontextmessung der Demokratiemessung. www.demokratiematrix.de.
- Lauth. H.J, S. (2020). *Konzeption der Demokratiematrix*.
- Luethi, K. (2023). *Governance grenzueberschreitender Professionalsierung und gesellschaftlicher Integration*. Zuerich, Schweiz.

- Merkel, W, Puhle, H.J, Croissant, A. (2003). *Defekte Demokratie*. Opladen.
- O'Donnel, G, Cullell, J.V, Iazzetta, O.M. (2004). *The Quality of Democracy. Theory and Application*. Indiana: University of Notre Dame.
- Pickel, S., Gert, P. (2006b). *Politische Kultur-und Demokratisierung. Grundbegriffe, Theorien, methoden. Eine Einfuehrung*. Wiesbaden.
- Schmelz, A. (2002). *Migration und Politik im geteilten Deutschland während des Kalten Krieges. Die West-Ost-Migration in die DDR in den 1950er und 1960er Jahren*. Leske+Budrich Verlag.
- Schmidt, M. G. (2013). Vier Welten der Demokratie: Ein Kommentar zu Arend Lijpharts. *Varieties, Crises, and Innervations of Democracy*.
- Schröder, W. H., & Wilke, J. (1998). *Politische Strafgefangene in der DDR: Versuch einer statistischen Beschreibung*. www.ssoar.info.
- The World Bank. (2007). *A Decade of Measuring the Quality of Governance*. Washington: The World Bank.
- World Bank. (2021). *Worldbank*. Worldwide Governance Indicators: <https://info.worldbank.org/governance/wgi/>-ээс Гаргасан
- World Bank. (2023). *Worldwide Governance Indicators*. Washington.
- World Economic Forum. (2021). *The Global Competitiveness Report 2020*. Cologny/Geneva: World Economic Forum.
- КАС. (2021, S.66). *Монгол дахь засаглал, институт, оролцоо, тэгш байдлын тулгамдсан асуудал, цаашдын хандлага*. Улаанбаатар: S.66.
- Конрад-Аденауэр-Сан. (2022). *Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар.
- Наранжаргал, х. (2018). Эгэх хариуцлагыг хөхиүлэн дэмжихэд хэвлэл мэдээллийн үүрэг. *Зүүн өмнөд азийн улс орнуудын нийгмийн эгэх хариуцлага, сургамж, сорил* (хууд. х.28).
- П.Доржсүрэн, Н.О. (2010). *Ардчилсан засаглал*.
- Campbell, D.F.J, Barth, T.D. (2009). Wie koennen Demokratie und Demokratiewualitaet gemessen werden? Demokartie-Indices und laenderbeispiele im globalen Vergleich. *SWS-Rundschau*, 209-233.
- УИХ. (2024). *Монгол Улсын Их Хурлын тухай хууль*.
- Улсын Их Хурал. (2020). *Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль*. Улаанбаатар хот.

Улсын Их Хурал, 2020. [огноо байхгүй]. *Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого*. Улаанбаатар.

Үндэсний Статистикийн Хороо. (2023). *Статистикийн эмхэтгэл*. Улаанбаатар хот.

Чулуунбаатар, Г. (2013). *Монголын нийгмийн өөрчлөлт*. БЭМБИ САН ХХК.

ШУА-ийн Философи, с. э. (2010). *Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2009-2010*. Сансудай ХХК.

Эмхэтгэл, С. а. (2003). Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын 5-р бага хурал. Урлах Эрдэм ХХК.

Хавсралт 1. АСУУЛГА СУДАЛГААНЫ АНКЕТ

СУДАЛГААНЫ АНКЕТ

Танд энэ өдрийн мэнд хүргэе!

Удирдлагын академийн Судалгааны багаас “Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага” хэмээх Засаглалын шалгуур үзүүлэлтийн өнөөгийн түвшинг тодорхойлох зорилгоор энэхүү асуулгыг та бүхнээс авч байна. Судалгаа, эрдэм шинжилгээний зорилгоор цуглуулсан хувь хүний мэдээллийг өөр зорилгоор ашиглахгүй бөгөөд мэдээллийг дараах хуулиудын хүрээнд нууцлах болно.

① Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 11.3-т заасны дагуу “мэдээллийн эзэн бичгээр зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд хүнийг тодорхойлох боломжгүй болгож түүх, эрдэм шинжилгээ, урлаг, утга зохиолын бүтээл туурвих, статистикийн мэдээлэл бэлтгэх зорилгоор мэдээлэл боловсруулж, ашиглана”, мөн хуулийн 29.1-т заасны дагуу “мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авснаас өөр зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахыг хориглоно”.

② Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай Монгол Улсын хуулийн 8.1-д заасны дагуу “Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана”. Мөн 8.4.27-д заасны дагуу “мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан” нь нээлттэй мэдээлэлд багтана.

Та бүхнийг энэхүү судалгаанд идэвхтэй оролцохыг урьж байна.

А. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

1	Та хэдэн настай вэ? (тохирох насны бүлгийг дугуйлна уу)	20-34	35-49	2	Таны хүйс (тохирох хариултыг дугуйлна уу)	Эрэгтэй	1
		50-64	65+			Эмэгтэй	2
3	Таны боловсролын түвшин (Зөвхөн нэг хариулт сонгоно уу)	Боловсролгүй				1	
		Бага боловсролтой				2	
		Бүрэн бус дунд боловсролтой				3	
		Бүрэн дунд боловсролтой				4	
		Мэргэжлийн ба техникийн боловсролтой				5	
		Бакалавр				6	
		Магистр ба түүнээс дээш				7	
4	Та ажил эрхэлдэг үү? (Зөвхөн нэг хариулт сонгоно уу)	Тийм (бүтэн цагийн)					1
		Тийм (хагас цагийн)					2
		Ажилгүй (ажил хайж байгаа)					3
		Ажилгүй (ажил хайгаагүй)					4
		Оюутан					5
		Тэтгэвэрт					6
		Гэртээ өвчтэй хүн асардаг					7
		Гэртээ хүүхдээ хардаг					8
		Бусад					9
5	Таны ажилладаг байгууллагын төрөл (Зөвхөн нэг хариулт сонгоно уу)	Төрийн захиргааны байгууллага					1
		Төрийн үйлчилгээний байгууллага					2
		Төрийн болон орон нутгийн өмчит компани					3
		Хувийн аж ахуйн нэгж					4
		Хувиараа хөдөлмөр эрхлэгч					6
		Малчин					9
		Бусад					10
6	Оршин суугаа нутаг дэвсгэр (Зөвхөн нэг хариултыг нөхөж бичнэ үү)	Хот					1
		Хөдөө					2
		Хилийн чанад					3

Б. УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ОЙЛГОЛТ

Та дараах агуулгад тохирох өөрийн санал бодлоо 1-6 оноогоор үнэлнэ үү. (Жишээлбэл, иргэд улс төрийн эрхээ бүрэн эдэлдэггүй гэж үзвэл 1, эрхээ бүрэн эдэлдэг гэж үзвэл 6 гэсэн оноо байна. Эрхээ эдэлж чадах хувь хэмжээг төсөөлөн 1-6 онооны аль нэгийг сонгоно уу)

7	Иргэд улс төрийн эрхээ бүрэн дүүрэн эдэлдэг.					
1 (Эрхээ бүрэн эдэлдэггүй)		2	3	4	5	6 (Эрхээ бүрэн эдэлдэг)
8	Иргэн таны улс төрийн эрх бол ардчиллын баталгаа мөн.					
1 (Ардчиллын баталгаа биш)		2	3	4	5	6 (Ардчиллын баталгаа мөн)
9	Миний улс төрийн эрхэнд хэн ч халдаж чадахгүй.					
1 (Амархан халддаг)		2	3	4	5	6 (Халдаж чадахгүй)



10	Иргэд улс төрийн эрхээ хараат бусаар эдэлж чаддаг.					
	1 (Чаддаггүй)	2	3	4	5	6 (Чаддаг)
11	Нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд жагсаал, цуглаанд оролцож үгээ хэлэх шаардлагатай.					
	1 (Үгээ хэлэх шаардлагагүй)	2	3	4	5	6 (Үгээ хэлэх шаардлагатай)
12	Улс төрийн намын жагсаалт болон тойргийн мандатын сонголт маш зөв.					
	1 (Маш буруу)	2	3	4	5	6 (Маш зөв)
13	УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийг сонгох улс төрийн сонгууль үргэлж шударга явагддаг.					
	1 (Шударга явагддаггүй)	2	3	4	5	6 (Шударга явагддаг)
14	Сонгуулийн Ерөнхий хороо нь УИХ, Ерөнхийлөгч, Орон нутгийн сонгуулийг хараат бус, ардчиллын зарчмыг ханган зохион байгуулдаг.					
	1 (Зохион байгуулж чаддаггүй)	2	3	4	5	6 (Зохион байгуулж чаддаг)
15	Сонгуулийн Ерөнхий хорооны эрх зүйн зохицуулалт нь маш сайн.					
	1 (Маш муу)	2	3	4	5	6 (Маш сайн)
16	Одоогийн УИХ-ын гишүүд чөлөөт, шударга сонгуулиар сонгогдсон.					
	1 (Чөлөөт, шударга сонгуулиар сонгогдоогүй)	2	3	4	5	6 (Чөлөөт шударга сонгуулиар сонгогдсон)
17	Сонгогчдын болон нэр дэвшигчдийн бүртгэл үнэн зөв, цаг тухайд нь ил тод, ялгаварлан гадуурхалтгүй хийгддэг.					
	1 (Хийгддэггүй)	2	3	4	5	6 (Хийгддэг)
18	Нэр дэвшигчид үг хэлэх, олон нийтийг хамарсан уулзалт хийх, сонгуулийн сурталчилгааны явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийг тэнцвэртэй ашиглах боломжоор бүрэн хангагддаг.					
	1 (Хангагддаггүй)	2	3	4	5	6 (Бүрэн хангагддаг)
19	Улс төрийн бүх шатны сонгууль нууц санал хураалтаар явагддаг.					
	1 (Явагддаггүй)	2	3	4	5	6 (Явагддаг)

В. УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Та улс төрийн эрхийн хэрэгжилтийн талаарх өөрийн санал бодлыг 1-6 онооны хооронд үнэлнэ үү.						
20	"Төрийн төлөө оготно боож үхнэ" гэдэгтэй санал нэгдэнэ.					
	1 (Нэгдэхгүй)	2	3	4	5	6 (Нэгдэнэ)
21	Нийгэмд болохгүй байгаа асуудлыг төрийн байгууллагын иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах сувагт (11-11, санал хүсэлтийн хайрцаг, аймаг, сумын вэб хуудас) ил тод, нээлттэй илэрхийлэх нь асуудлыг шийдвэрлэх гарц мөн.					

	1 (Шийдвэрлэх гарц биш)	2	3	4	5	6 (Шийдвэрлэх гарц мөн)
22	Би өөрийнхөө эрх ашгийг хамгаалах үүднээс иргэний нийгмийн байгууллагыг байгуулах, үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцох боломжоор бүрэн хангагдсан.					
	1 (Бүрэн хангагдаагүй)	2	3	4	5	6 (Бүрэн хангагдсан)
23	Би нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар нийгмийн сүлжээнд (Facebook, X, Instagram, Youtube гэх мэт) санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, бусдын постыг шэйрлэх (хуваалцах) зэргээр эсэргүүцлээ илэрхийлдэг.					
	1 (Эсэргүүцлээ илэрхийлдэггүй)	2	3	4	5	6 (Эсэргүүцлээ илэрхийлдэг)
24	Нийгмийн өмнө тулгамдсан асуудлын талаар хаана ч, хэнд ч хандаад нэмэргүй.					
	1 (Хэлээд нэмэргүй)	2	3	4	5	6 (Хэлэх нь нэмэртэй)
25	Хэнийг ч сонгоод өөрчлөлт авчрахгүй.					
	1 (Өөрчлөлт авчрахгүй)	2	3	4	5	6 (Өөрчлөлт авчирна)
26	Монгол залуус эх орондоо ажиллаж, амьдрах бүрэн боломжтой.					
	1 (Боломжгүй)	2	3	4	5	6 (Боломжтой)
27	Өндөр хөгжилтэй гадаад улсад амьдрах нь эх орондоо амьдарснаас илүү амар.					
	1 (Амаргүй)	2	3	4	5	6 (Амар)
28	Миний эргэн тойрны ихэнх хүмүүс дээрх шалтгаанаар өөр аймаг, хот, эсвэл гадаад улс руу явсан.					
	1 (Яваагүй)	2	3	4	5	6 (Бүгд явсан)
29	Боломж олдвол би өнөөдөр ч өөр аймаг, хот эсвэл гадаадад очиж амьдрах хүсэлтэй байна.					
	1 (Хүсэлгүй)	2	3	4	5	6 (Хүсэлтэй байна)

Судалгаанд идэвхтэй оролцсон Танд баярлалаа

Хавсралт 2. ЭКСПЕРТИЙН ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТ

**“Засаглалын шалгуур үзүүлэлтийг хэмжих нь:
Иргэдийн дуу хоолой ба эгэх хариуцлага”
судалгааны экспертийн ярилцлага**

Нэр	
Байгууллага	
Нас	
Хүйс	
Боловсролын зэрэг	
Ярилцлага хийсэн өдөр	
Ярилцлагын хугацаа	
Монгол Улс Фрийдом хаусын 2022 оны судалгааны үнэлгээгээр Улс төрийн эрхийн хэрэгжилт дээр 40 оноо авахаас 36 оноо авсан. Үүний цаад шалтгааныг дараах 3 агуулгын хүрээнд Та тайлбарлаж өгнө үү?	
Сонгуулийн үйл явц (11/12)	
Улс төрийн олон урьгалч байдал (16/16)	
Засгийн газрын үйл ажиллагаа (9/12)	
Иргэний эрх чөлөө шалгуур үзүүлэлтээр Монгол Улс 60 оноо авахаас 48 оноо авсан. Үүний цаад шалтгааныг дараах 3 агуулгын хүрээнд Та тайлбарлаж өгнө үү?	
Итгэл үнэмшилтэй, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө (14/16)	
Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө (11/12)	
Хувь хүний халдашгүй байдал болон хувийн эрх чөлөө (12/16)	

